

Гүнзгий мэд

MONGOLIAN ECONOMY

2016 ОНЫ 02 САР №03 (105)

mongolianeconomy.mn

ЭДИЙН ЗАСАГ

Б.Лакшми: Засаглалын тогтворгүй байдал хөрөнгө оруулалт, бизнесийн хөгжилд саад болдог


ОНЦЛОХ

“Эргэлзэх бүртээ The Economist-ыг хүлээдэг”

ХӨГЖИЛ

Хэвлэлийн зөвлөл бол ардчиллын мөн чанарын илэрхийлэл юм

Дэлхийг форматлах үйлдвэрлэл 4.0?





МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЧУУЛГАН



СУРГАМЖ, СОРИЛТ, ШИЙДЭЛ

2016 ОНЫ 3 ДУГААР САРЫН 30-31,
ТӨРИЙН ОРДОН

ЦАХИМ БҮРТГЭЛ

WWW.MEFORUM.MN/REGISTER

ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ

ВЭБ WWW.MEFORUM.MN
УТАС 11321051

ДЭЛХИЙН ХӨТӨЧ Бүтэн жилийн турш таны ширээн дээр



“Mongolian Economy” сэтгүүл “The Economist” сэтгүүлийн жилийн
“The World in 2016” дугаарыг тусгай зөвшөөрлийн хүрээнд монгол хэлээр гаргаад байна.

Дэлхий 2016: Энэ оныг гурван үгээр дүгнэж болох.

ЗОВЛОН ЗҮДГҮҮР, ЭМЭГТЭЙЧҮҮД болон ЯЛАЛТ.

Энэ удаагийн дугаарт Энэтхэгийн Ерөнхий сайд Нарендра Моди зэрэг нөлөө бүхий улстөрчдөөс гадна тусгай бүлэгт Канадийн зохиолч, Америкийн чиг хандлага ажиглагч, Израилийн шинэлэг загвар зохион бүтээгч болон Австралийн алдартай зурхайч гэх мэтийн хүмүүс хувь нэмрээ оруулжээ. Тус сэтгүүлд дэвшүүлэн тавьсан таамаг төлөвийн 90 хувь нь биелдгээрээ давуу талтай гэдгийг үг сэтгүүлийн эрхлэгч Даниел Франклин онцлон тэмдэглэсэн. Тийм учраас сэтгүүлийн байнгын уншигчид жил бүр эргэн ирдэг.

Бид Монголын уншигчдыг ч энэ эгнээнд элсүүлж чадсандаа баяртай байна. Та бүхэн таалан уншина уу.

Үнэ: 40.000₮

Утас: 7011 5477, 7011 5476, 88006228, 94092904



**БҮХ СУВЕНИРИЙН 20% НЬ 20% ХЯМДАРЧ,
80% НЬ 50% ХЯМДАРЛАА**



store 1:
НАЙРСАГ УЛААНБААТАР ИХ ДЭЛГҮҮР 4 F

store 2:
SKY SHOPPING CENTER 2 F
Tel: 99150969 96098829

Агуулга



Тэднийг амжилттай хөгжөөлөө

Тэд юу ярих? Бид юу ярих? Дэлхийн эдийн засгийн чуулганд явсан төлөөлөгчид маань богцноосоо задлахгүй болохоор богцгүй ирсэн юм болов уу, хуудас 9



ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ ЭРХЛЭГЧ:

Д.Бэхбаяр

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ,

ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.Отгонжаргал

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:

О.Түвшин

СЭТГҮҮЛЧИД:

Б.Үүрийнтуяа

Б.Энхцэцэг

Г.Орхон

Ц.Элбэгсайхан

ОРЧУУЛАГЧ:

Б.Энхмөнх

ДИЗАЙНЕР:

Ш.Оюундарь

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:

Д.Бариянжав

Хаяг: Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, I хороо, Экспресс тауэр. 1101 тоот

Вэб: www.mongolianeconomy.mn

И-мэйл: info@mongolianeconomy.mn

Утас: 976-7011 5476

Борлуулах цэгүүд:

“Интер ном”

“Цэцэг төв”

“Минж плаза”

“Алтантүлхүүр” номын дэлгүүр

“Номин” супермаркетин бүх салбар

“Макс” супермаркетин бүх салбар

“Фреско” супермаркет

BTSI супермаркет

“Аз орчлон” номын дэлгүүр

“Билэг” их дэлгүүрийн номын тасаг

“Гранд Плаза” дахь супермаркет

“Мир” номын дэлгүүрийн:

“Grand plaza”

“Metro mall”

“Sky” супермаркет

“Улаанбаатар” их дэлгүүр

“Max mall” дахь салбарууд

Эдийн засаг

9 Тэднийг амжилттай хөгжөөлөө

Хөрөнгө татах биш урсгаж олон жил явлаа

11 Үйлдвэрлэлийн IV хувьсгал эдийн засгийн бодлогод хэрхэн нөлөөлөх вэ?

Оксфордын Их сургуулийн Карл Бенедикт, Майлк Осборн нарын таамаглаж буйгаар хөгжингүй эдийн засгуудад нийт ажлын байрны 40-50 хувь нь өөрчлөгдөж эсвэл бүр байхгүй болно гэжээ.

13 Ч.Ганхуяг: Давост хийнэ гэж ярьсан юм аа ирээд хэрэгжүүлдэггүй

Жил бүрийн чуулганаар оролцож буй хүмүүс нь баяжиж, шинэ санаанууд өвөртөлж ирдэг. Тэндээс тодорхой дүгнэлтийг хийж болдог

15 Б.Лакшми: Засаглалын тогтворгүй байдал хөрөнгө оруулалт, бизнесийн хөгжилд саад болдог

Бидэнд алдаж оносон зүйл их бий, ашиглаж чадаагүй боломж ч их бий. Энэ бүхнээ эргэж харж, чиг хандлагаа тодорхойлох талаар ярилцах болно

16 Ипотекийн үнэ цэнэ

Бүх юмны үнэ хямдарч, инфляци бүүрч байгаагийн шалтгааныг тайлбарлах хоёр хүчин зүйл бий

18 АСЕМ-аар “амьсгалахаас” өмнө

Энэ онд АСЕМ-ийн 20 жилийн ой тохиож буй тул зохион байгуулагч оронд ирэх хариуцлага өндөрсөж буйг албаныхан онцолж байна

19 Хотын жинс

Цаашид хувцасны бүх төрлийг үйлдвэрлэн “Urban” брэндийн дүү нарыг төрүүлэх нь тэдний ойрын зорилго

Онцлох

22 “Дэлхий 2016” сэтгүүл Монголд

23 Дэлхий 2016 онд: 7.3 тэрбум хүн, 197 үндэстэн, 1 гариг

Ирээдүй юуг агуулж байгаа бол гэж та боддог уу? 2016 онд ямар мөч дэлхийг нэгтгэж, ямар мөч дэлхийг салгах вэ? Ямар хүмүүс, газрууд мөн төлөвлөгөөнүүдийг анхааралтай ажиглах ёстой вэ?

25 “Эргэлзэх бүртээ

The Economist-ыг хүлээдэг”

The Economist чөлөөт худалдаа болон чөлөөт зах зээлээс өөр юунд итгэдэг вэ? The Economist өөрийгөө радикалуудын нэг гэж үзэхийг эрмэлздэг

Хөгжил

27 Өнгөө өөрчлөх хотын худалдан авалт

Өдрөөс өдөрт өнгө засч “шилэн” болж буй Улаанбаатар хот өнгөрсөн онд эдийн засгийн хувьд хямраагүй аж

29 Хэвлэлийн зөвлөл бол ардчиллын мөн чанарын илэрхийлэл юм

Монголын хэвлэлийн зөвлөлийг бүх ажлыг хийж, тулгарах сорилт бэрхшээлийг даван туулж чадна гэдэгт итгэлтэй байна

34 Найрсаг хот энэ онд

34 Трендийн араас

Монголд тренд хаана явна вэ?

36 ТӨХ-г татан буулгах цаг дор

Улс төр

38 Улс төрийг хэрхэн ойлгож, тайлбарлах вэ?

40 Холын зорилго үгүй бол ойрын зовлон оршино-3

42 Ёс суртахуунлаг хүмүүс төр барьсан цагт л Монгол Улс хөгжинө



Давост хийнэ гэж ярьсан юм аа ирээд хэрэгжүүлдэггүй

Засгийн газар бонд босгох гээд гадны банкируудтай уулзаад явж байхад ийм зүйл болсноороо гацааж орхилоо, хуудас 13



Засаглалын тогтворгүй байдал хөрөнгө оруулалт, бизнесийн хөгжилд саад болдог

Том дүр зургаар харвал аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгал Ази тивд их хүчтэй өрнөнө, хуудас 15



“Эргэлзэх бүртээ The Economist-ыг хүлээдэг”

The Economist бичих сэдэв болон хэвлэлтийн хэмжээний хувьд анхнаасаа л ирээдүйгээ харж өргөн хүрээнд хилийн чанадыг харж байсан, хуудас 25



Хотын жинс

Сэтгэлийг гижигдэж, халаасаа хоослохоос үл буцаам байдалд оруулж буй брэнд “Urban jeans”, хуудас 19

Монголд



Ипотек

УИХ-аас нэгдүгээр сарын 19-ний өдөр Иргэний хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг баталснаас хойш банкууд нийт 759 зээлдэгчид 47.2 тэрбум төгрөгийн орон сууцны ипотекийн зээл шинээр олгохоор шийдвэрлэсэн байна. Үүнээс зургаан банк 110 зээлдэгчид 5.1 тэрбум төгрөгийн орон сууцны ипотекийн зээл олгожээ.

Ипотекийн зээлийн хүүг таван хувь болгон бууруулах асуудлыг гуравдугаар сард багтаан шийдвэрлэнэ хэмээн Монголбанкны ерөнхийлөгч Н.Золжаргал мэдэгджээ. Бэлтгэл ажлууд эхэлсэн бөгөөд нийт таван гэрээ болон ипотекийн зээлийн журамд өөрчлөлт оруулах шаардлагатай байгаа аж. Мөн “Ирээдүйн өв сангийн тухай” хуулийг баталсан тул тус хуульд нийцүүлэн зохицуулалт хийх хэрэгтэй болжээ.

Шатахууны жижиглэнгийн худалдааны үнэ Улаанбаатарт энэ сарын 21-ний өдрөөс 80-150 төгрөгөөр буурлаа. 2015 оны арванхоёрдугаар сараас шатахууны жижиглэнгийн үнийг баруун бүсэд 80-400, зүүн бүсэд 10-230 төгрөгөөр тус тус бууруулсан. Мөн энэ



сарын 20-ноос Өмнөговь, Дорноговь, Хөвсгөл, Архангай зэрэг аймагт шатахууны үнийг 100-150 төгрөгөөр бууруулах ажлыг Уул уурхайн яамнаас зохион байгуулжээ.

Шатахууны хангамж нэг улсын, нэг компаниас хэт хараат байсны уршгаар шатахууны хилийн үнэ бүс нутгийн зах зээлийн үнээс тонн тутамдаа 300-400 ам.доллараар өндөр байсан. Төрөөс татварыг өөрчлөх замаар жижиглэнгийн борлуулалтын үнийг тогтворжуулж ирсэн юм.

2014 оны наймдугаар сараас дэлхийн зах зээл дээр газрын тосны үнэ буурч эхэлсэн үеэс Засгийн газар, Уул уурхайн яам зах зээлийн үнийн хэлбэлзлийг ажиглан дараах арга хэмжээг авчээ. Тухайлбал, шатахуун импортлогч компаниудад олгож байсан хөнгөлөлттэй зээлийг 2015 оны нэгдүгээр сарын 1-нээс зогсоосон ба зээлийн хүү 16-18 хувь болсон байна. Хөтөлбөрийг бүрэн зогсоож зээлийн санхүүжилт эргэн төлөгдөж дууссан байна.

Ухаалаг шийдэл



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилга, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэмжлэгээр ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, Информатикийн хүрээлэнгийн эрдэмтэн судлаачид хамтран Монгол хэлний их тайлбар толийг бүтээжээ. Уг цахим толийн гар утасны хувилбарын нээлт энэ сарын 2-нд болсон бөгөөд үүнийг “Unlimited idea” компанийн ажилтнууд нэг сарын хугацаанд хийсэн

байна. Энэхүү хувилбарыг 2013, 2014 оноос хойшхи бүх үтсанд татах боломжтой аж. Цахим толь нь 60 мянга гаруй толгой үг, 80 мянга гаруй хоршоо, холбоо үг, нийтдээ 140 мянган үг агуулсан Монгол хэлний их тайлбар цахим толь юм. Тус толийг цаашид баяжуулж хөгжүүлэх боломжтой бөгөөд ингэхийн тулд www.монголтоль.мон, www.mongoltoli.mn хаяг руу орж бүртгүүлэн хэн ч шинэ үг нэмж оруулах боломжтой аж.

Зээлийн хүү



УИХ-ын чуулган нэгдүгээр сарын 28-нд нэгдсэн хуралдаан Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах тухай УИХ-ын гишүүн Г.Уянга нарын 19 гишүүний саналыг хэлэлцлээ. Санал хураалтыг “Ерөнхий сайдыг огцруулах шаардлагагүй” гэсэн томъёоллоор явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн 57.5 хувь нь дэмжсэн юм.

Санал хураалтад 73 гишүүн оролцжээ. Ерөнхий сайдыг нь “Оюу толгойн хоёр дахь шатны бүтээн байгуулалтын төлөвлөгөөг баталсан” гэдэг үндэслэлээр огцруулах санал оруулсан нь бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчдын анхаарлыг татаж байлаа.

Олон улсын үзэсгэлэн

Олон улсын уул уурхайн томоохон хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт болох “PDAC”-т Монголын уул уурхайн салбарыг сурталчлах, хөрөнгө оруулалтын төслүүдийг танилцуулахаар Уул уурхайн яам, Ашигт малтмалын газар, Хөрөнгө оруулалтын газар



болон “Эрдэнэс Монгол” ХХК хамтран ажиллаж байна. Чуулга уулзалт Канадын Торонто хотноо ирэх сарын 6-9-нд зохион байгуулагдана.

Чуулга уулзалтын үеэр Монголын уул уурхайн үзэсгэлэн болон “Монголын уул уурхайн бизнес форум”-ыг гуравдугаар сарын 8-нд зохион байгуулах юм. Тус арга хэмжээнд Канадын болон бусад орны уул уурхайн салбарын хөрөнгө оруулагчид, бизнесүүд оролцоно. Монголын талаас Уул уурхайн сайд тэргүүтэй албаны болон бизнесийн төлөөлөгчид оролцож, уул уурхайн салбарын бодлого, хөрөнгө оруулалтын боломж, шинэ төсөл хөтөлбөрүүдийг танилцуулна.

Монголын хайгуулын болон уул уурхайн компаниудыг өргөнөөр оролцуулах, тэдний үйл ажиллагаа, холбогдох төслүүдийг олон улсын болон гадаадын хөрөнгө оруулагчдад танилцуулахад ихээхэн анхаарч байгаа аж. Чуулганы үеэр гарах үзэсгэлэнд Монголын геологи, уул уурхайн салбарын мэдээллээс гадна манай уул уурхайн томоохон компаниудын талаар танилцуулж, Ашигт малтмалын газар хайгуулын төслүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл хийх юм.

Канадын уул уурхайн хайгуул, олборлогчдын холбооноос жил бүр зохион байгуулдаг “PDAC” нь олон улсын уул уурхайн салбарын хамгийн том уулзалт. Өнгөрсөн жил гэхэд л тус чуулга уулзалтад 100 гаруй улсаас 20 гаруй мянган төлөөлөгч оролцжээ.

Дэлхий дахинд

Хөрөнгийн зах зээл



Дэлхийн хөрөнгийн зах зээл 2016 оныг сайн мэдээтэй угтсангүй. Шинэ оны эхээр бараг бүх гол индекс эрс буурсан байна. Тэр дундаа БНХАУ-ын хөрөнгийн уналт хүндхэн байгаа юм. Харин АНУ болон Европын хөрөнгийн зах зээл нэгдүгээр сарын 11-ний даваа гаригт нэгээс хоёр оноог эргэн олж авч чадсан бол Хятадын хувьцаа доош унасаар байгаа аж. Жилийн ажлын эхний өдрүүдэд хүнд хохирол амссан “Shanghai Composite” 5.3 хувиар унасан бол “Shenzhen Composite” 6.2 хувиар унасан байна. Шинэ он гарснаар Шанхайн хөрөнгийн зах зээл өөрийн үнэ цэнийн 15 хувийг алдсан аж. Харин Өмнөд Солонгос, Австрали болон Энэтхэгийн хөрөнгийн зах зээл хэдэн өдрийг улаан заалттайгаар хаажээ. Хэдийгээр Хятадын хөрөнгийн зах зээл Барууны орнуудынхтай адил эдийн засагт өндөр ач холбогдолтой байдаггүй ч тус улсын эдийн засгийн удаашралд анхаарал хандуулахад хүргэж, тус улсын засгийн газрыг ийм маягийн цохилтыг зохицуулах чадварт дахин санаа зовниход хүргэж байгаа юм.

АНУ-ын эдийн засаг

АНУ-ын Хөдөлмөрийн статистикийн товчоо өнгөрсөн арванхоёрдугаар сард 292,000 ажлын байр шинээр нэмэгдэж жилийн хүчтэй үзүүлэлттэй төгсгөсөн гэдгийг баталжээ. Газрын

тосны үнэ, Хятадын удаашрал болон бусад дотоод хүчин зүйлүүдийг үл хамаарч ажилгүйдлийн түвшин таван хувьд тогтвортой байж, мөн Холбооны нөөцийн сан бараг 10 жилийн турш нэмээгүй бодлогын хүүгээ нэмсэн нь найдвар төрүүлж байгаа юм. Хэдийгээр Хятадын хөрөнгийн зах зээлүүд шиг хүнд байдалд ороогүй ч Dow Jones индекс оны эхний дөрвөн өдрийн арилжаагаар таваас дээш хувь унасан боловч нэгдүгээр сард алдагдлаа нөхөж чаджээ. Хүчтэй ам.доллар болон хүлээж байснаас сул гадаадын эрэлт нь экспортын баримжаатай салбарын хэтийн төлөвийг сулруулж болох юм. Хэрэв оны эхний улирлын турш одоогийн ажил



олголтын хурд үргэлжилсээр байвал ХНС-г хүүгийн түвшингээ ирэх гуравдугаар сард болох уулзалтаар дахин нэмнэ хэмээн хөрөнгө оруулагчид таамаглаж байна. ХНС-гийн албан тушаалтнууд хүүгийн түвшин энэ онд ойролцоогоор нэг хувиар өснө гэж мэдэгдсэн аж.

Суннитууд Шийтүүдийн эсрэг

Саудын Араб болон Иран улсын аль хэдийн хурцадмал



байдалд хүрсэн харилцаа даамжрах магадлалтай байна. Шийтийн санваартан Нимр Аль-Нимрийг цаазалсны дараа Ойрхи Дорнод даяар үймээн шуугиан дэгдсэний улмаас бүс нутгийн өрсөлдөгч тус хоёр улс дипломат харилцаагаа тасалжээ. Мөн Тегеран Риадтай бүх худалдааны холбоогоо тасалж Саудын Арабаас ирэх бүх импортыг хоригложээ. Аль-Нимрийг хааны гэр бүлээс урваж, хүчирхийлэлд турхирч, мөн гадаадын оролцоог эрэлхийлсэн хэмээн цаазаар авах ял оноожээ. Тэрээр Шийтийн ард иргэд дунд нэр хүндтэй нэгэн байсан бөгөөд тус хаант улсад болсон Арабын Хаврын бослогод голлох үүрэг гүйцэтгэж байсан юм. Харин Саудын эрх баригчид түүнийг Иранд үнэнч радикал түрэмгий этгээд байсан гэж буй аж. Түүнийг цаазаар авсан нь Ойрхи Дорнод дахь Шийтүүдийг хэлэгнэхэд хүргэж улмаар Тегеран дахь Саудын Арабын элчин сайдын яамыг уур хилэнд автсан жагсагчид шатаажээ. Шийтүүд иргэдийн олонхыг бүрдүүлдэг Иран улс болон Суннит давамгаалсан Саудын Араб Сирийн иргэний дайнд бие биенээсээ эсрэг талыг дэмжиж байгаа нь нууц биш юм. Суннит-Шийтийн зөрчилдөөн аль 7-р зуунаас эхлэлтэй бөгөөд номлогч Мухаммед нас барсны дараа хэн түүний халифатын хууль ёсны залгамжлагч байх ёстой вэ гэдэг дээр маргалдан хоёр хуваагдсан юм.

Кельн, Герман

Германы канцлер Ангела Меркель гэмт хэрэг үйлдсэн цагаачдыг албадан гаргахыг хялбар болгохын тулд нэлээд чанга хуулийг санал болголоо. Кельны сүмийн



болон төв метроны буудлын хоорон дахь талбайд Хойд Африк эсвэл Араб гаралтай эрчүүд тэргүүтэй мянга мянган хүмүүс цуглаж олон зуун хулгай болон эмэгтэйчүүдэд халдсан хэрэг мэдүүлсэн нь Герман даяар маргаан үүсгэж байна. Хотын захиргаа болон холбооны цагдаагийн албаныхныг уг нөхцөл байдлыг муу зохицуулсан хэмээн ихээр шүүмжилж байгаа бөгөөд “The Spiegel” сонин тэднийг өрөвдөлтэй гэмээр ажилласан гэжээ. Үүний улмаас алс барууныг баримтлах үзэл хүчээ авсан бөгөөд цагаачлалын эсрэг босогчдыг тараахын тулд даралтат усан буу болон чинжүүны шингэн шүрсэн аж. Мөн феминист жагсагчид болон цагаачлалын эсрэг хөдөлгөөний жагсаал цуглаанууд болсон юм. Германы хамгийн том телевиз болох “ZDF” уг нөхцөл байдлын талаар мэдээллэж чадаагүйдээ уучлалт хүссэн юм. Германы олон иргэн телевизийн сувгуудыг цагаачдын талаар сөрөг мэдээллийг албаар гаргахгүй байна гэдэгт итгэлтэй байгаа аж. Кельн хотын орших Хойд Рейн-Вестфалын мужын цагдаагийн газрын даргыг халдлагын талаарх мэдээллийг нуун дарагдуулсан хэмээн ажлаас нь түр чөлөөлсөн байна. Герман улс 2015 онд нэг сая гаруй дүрвэгчид болон цагаачдыг хүлээн авсан нь Европын Холбооны бусад улсаас хавьгүй илүү тоо юм. Гэвч Германы тэсвэр тэвчээрт хязгаар бий гэдгийг харуулах үүрэг Меркельд оногдоод байгаа юм. ■

ИМАКО ИНСТИТУТ:
ОРОЛЦООНД ТҮШИГЛЭСЭН СУРГАЛТ,
МЭРГЭШСЭН КОНСАЛТИНГ

SINCE 2002

*БАЙГУУЛЛАГЫН КОРПОРАТИВ СОЁЛ,

*ҮЙЛЧЛЭХ СОЁЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
СТАНДАРТ, ДЭГ ЖАЯГ,

*МАНЛАЙЛАХ ШААРДЛАГА, МАНЛАЙЛЛЫГ ХЭМЖИХ

*БАГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА, АЖИЛТНЫ ЁС ЗҮЙ

*ХАМТ ОЛНЫ ДОТООД ХАРИЛЦАА, ЭС ЗОХИЦЛЫГ
ШИЙДВЭРЛЭХ

*АЖИЛТНЫ ХАНДЛАГЫГ ЭЕРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГА

*БҮТЭЭГДХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР БҮТЭЭМЖИЙГ
НЭМЭГДҮҮЛЭХ

*ГОМДЛЫН МЕНЕЖМЕНТ, ГОЛОГДОЛ, ЗӨРЧЛИЙГ
УДИРДАХУЙ



Дэлхийн эдийн засгийн чуулган

Тэднийг амжилттай хөгжөөлөө

Б.ҮҮРИЙНТУЯА

Хөрөнгө татах биш урсгаж олон жил явлаа

“Зохин”, “A-Sound”. Бас бус морин хуурын тоглолт. Манай улсын төлөөлөгчид 2016 оны Дэлхийн эдийн засгийн форумыг ийн “доргиожээ”. Өөрөөр хэрхэн оролцсон талаар цахимд ховор дуулдав. Аан тийм, “Монголын үдэш” арга хэмжээнд үндэсний хувцасны загварын шоу болсныг бас цахимаар цацагдсан зургуудаас харсан. Дэлхийн эдийн засгийн чуулганыг нүдээрээ харж, бэхээрээ тэмдэглэж чадаагүй үзэгтнүүдийн хувьд бусад нь юу гэхийг харж суув. Германы “Die Welt”, “Welt am Sonntag” сонины Бизнес хариуцсан редактор Олаф Герсманн Монгол Улсыг хөрөнгө оруулагчдын итгэлийг татах гэж оролдож буй хамгийн цөхрөнгөө барсан орон хэмээгээд морин хуурчдын тоглолтын хэсгийн бичлэгийн хамтаар жиргэсэн нь монгол жиргээчдийг ихээхэн бухимдуулсан. Тэднийг гэлтгүй Монгол сэтгэлтэй хүн бүрт хүнд туссан биз. Зөвхөн энэ жил биш өнгөрсөн, баларсан жилүүдэд ч “WOW” үр дүн гарч байсангүй. Манайхан, Монгол Улс, тус чуулганыг урлагийн наадамтай эндүүрээд нэлээд олон жил явчих шиг гэсэн бодол төрөх.

Тэд юу ярив?

Цаг уурын өөрчлөлтөөс эхлээд дэлхий нийтийн эрүүл мэнд, Хятадын эдийн засгийн удаашрал болон үүнээс үүдэх дэлхийн эдийн засгийн “түгжрэл”, дүрвэгсдийн хямрал, ажилгүйдэл, жендерийн эрх тэгш байдал гээд маш чухал сэдвүүдийг хэлэлцэхээр дэлхийн томчууд Давост чууллаа. Үндэслэгч Клаус Швабын дэвшүүлсэн Үйлдвэрлэлийн IV хувьсгал гэх санаа 2016 оны Дэлхийн эдийн засгийн форумын гол сэдэв байв. Технологийн эринд дарлагдаж, өрсөлдөөн ширүүсэхийн хэрээр компаниудын нэрс архивт шилжиж байгааг Дэлхийн эдийн засгийн чуулганаар онцолсон байгаа юм. Ийм ч учраас дижитал харилцаа холбоо, роботжилт төдийгүй нэмэгдсээр буй асар том цахим мэдээллийн сангийн хүртээмж зэргээс үүдэн баян орнуудад нийт ажлын байрны 50 хүртэлх хувь нь ойрын жилүүдэд өөрчлөгдөх эсвэл үгүй болно гэж Оксфордын Их сургуулийн Карл Бенедикт, Майкл Осборн нар таамаглаж. Энэ өнцөгөөс харвал Үйлдвэрлэлийн IV хувьсгал ирэх жилүүдэд дэлхий нийт талхны төлөө хэрхэн тэмцэх шаардлагатай тулгар буйг илтгэж байгаа аж. Тухайлбал, цахим худалдаа уламжлалт борлуулалтаас харьцангуй хямд тусдаг тул хямд өртөг бүхий өрсөлдөөн ширүүсэхийн хэрээр

бизнесийн уламжлалт арга үнийн өрсөлдөөний өмнө хүчин мөхсөдөж байна. Хэрэглээний үнийн өрсөлдөөн, жил ирэх тусам улам хомсдох ажлын байр, үүнээс улбаалах татварын хүндрэлүүд цаашлаад улс орны төсөвт ч хүнд тусах эрсдэл чуулганы чухал хуралдаануудын сэдэв болсон.

Түүнчлэн Орос ба бусад, Ассад болон Исламын улс бүлэглэл гээд энхтайванд “харшилж” байгаа геополитикийн асуудлуудыг мөн хөнджээ. Цагаачид Европын хувьд хямрал болчихоод байна. Дайн тэдний дүрвэх шалтгаан. ОХУ буюу манай хөрш үүнд эсрэг дүрээр дэлхийтэй тулалдаж байгаа. Нөгөө хөршийн маань эдийн засагч мөн таагүй байдалд шилжиж буй нь эргээд дэлхийд нөлөөлнө. Үүнийг Монгол тойроод гарахгүй нь тодорхой.

Дээрх мэтээр дэлхийн эдийн засаг хааш чиглэж байгааг салбар бүрт тал талаас нь асуудал дэвшүүлэн ярилцсан Дэлхийн эдийн засгийн чуулганд Монгол Улс хаагуур явав?

Тус чуулганд манай улс цөөнгүй жил оролцож буй. Өмнөх жилүүдэд Монгол Улсын талаар тусгай бага хурал зохион байгуулагдаж байсан, Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Хамтын ажиллагааны харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан гээд сануулахад илүүдэхгүй чухал алхмууд бий. Энэ жилийн чуулганаар Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “Дэлхийн усны хомсдол, хүртээмж: Дэлхийн усны хөтөлбөрийн хэрэгжилтийг түргэсгэх нь” тэргүүтэй хурлуудад оролцохоор товлож Зүүн Азийн эдийн засгийн уулзалтуудыг эх орондоо зохион байгуулах асуудлаар Клаус Швабтай ярилцсан бөгөөд чуулганыг үндэслэгч 2017 онд манай улсад зочлох болсноо мэдэгдсэн. Гэвч үүнээс өөр амжилт өнөөг хүртэл тэнд зарцуулсан их зардлаас давахгүй байгааг санах нь бас зүйтэй. Хөрөнгө оруулалт татах хүсэлтэй тийш зүглэдэг ч хөрөнгө оруулчихаад ирдэг тухай шүүмжлэл цөөнгүй гардаг.

Бид юу ярив?

Дотоодын цөөн хэдэн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр чуулганаар танилцуулсан тайлан, судалгаанд нийтэлсэн Монгол Улсын салбаруудын үзүүлэлтүүдийг мэр сэр дурьдаж буй ч бодит байдал дээр бид гадаадад нэрээ “хугалжээ”. Гаднынхан биднийг цөхөрсөн гэлээ. Харин бид өөрсдийгөө шившигээ тариад ирлээ гэх. Дэлхийн эдийн засгийн чуулганд явсан төлөөлөгчид маань ▶

▶ богцноосоо задлахгүй болохоор богцгүй ирсэн юм болов уу гэж бодоход хүргэж байна.

Таварын ханш 2017 оны дундуур багахан өсөлт алгуурхан мэдрэх магадлал гарсан ч өнөөгийн байдлаар сөхөрчихөөд буй. Нүүрс, зэс, алт манай улсын эдийн засгийн тэжээл хэвээр байгаа үед эдгээрийг төсөвтөө суулгахдаа тэнгэрийн үнээр тооцоор ирсэн. Үүн дээр нэмээд Монголыг тоох хөрөнгө оруулагч “өдрийн од” болчихлоо. Ийм байтал гаднын, тодруулбал дэлхийн томоохон эдийн засаг Германы нэр хүнд бүхий

хэвлэлийн нэгэн эрхлэгчээр “Цөхөрсөн” гэж дуудуулсан нь авсан дахь сүүлийн хадаас болов.

Дэлхийн эдийн засгийн чуулганы зорилго дүгнэхдээ гол нь биш. Үр дүн гэж ч улайрдаггүй. Харин гарц эрэлхийлэх боломжит алхам, шийдлийг олонд хүргэх. Ингэхдээ учир мэддэг чухал хүмүүсийг цуглуулан ярилцах. Ярилцдаг гэдэг утгаар нь гаднынхны зарим нь тус чуулганыг ач холбогдолгүй цугларалт гэх нь бий. Гэвч манай улсын төлөөлөгчдийн хувьд нэгэнт яваад ирдгээс хойш үр дүн биш юм аа гэхэд ахиц, дэвшил, шинэлэг



санаа өвөртлөөд ирдэг болвол. Суусан цэцнээс явсан тэнэг дээр гэдэг дээ.

Албаныхан ажлаа хамгаалах нь мэдээж. Зорилго тээгээд явж байгаа нь сайшаалтай. Гэвч урлагийн тоглолт хөрөнгө оруулалт татахад хангалтгүй, мянган “Монголын үдэш” зохион байгуулаад гадны баячууд Монголд ирэхгүй. Эцсийн дүнд тогтвортой байдал, шударга тогтолцоо хүснэ, тэд. Дуугаар уяраах биш, тууштай бодлого танилцуулаад ирдэг бол энэ үр дүн. Дэлхийн эдийн засгийн чуулган болдог жамаараа ирэх жилүүдэд үргэлжилнэ. Биднийг шоглох гэж биш сонирхож урьдаг нь лавтай. Харин манай төлөөлөгчид “Тэднийг амжилттай хөгжөөлөө” гэхээс өөр үггүй бас үйлдэлгүй ирдэг байвал энд ч тэр, тэнд ч тэр Монгол Улсын нэр хүнд ингэглээ “цөхрөхгүй”.

“Шаардлага гэдэг нь аливаа зүйлийг зохион бүтээх эсвэл олж нээхийн эх үндэс биш. Гэвч энэ нь зарим Төвбанк болон Засгийн газрыг уналтад орохгүй тэсч, эдийн засгаа сэргээхийн тулд 2008 оны санхүүгийн хямралаас хойш үзэгдээгүй зүйлсийг хийхэд хүргэж байна” хэмээн “Roubini Global Economics” эдийн засгийн зөвлөх фирмийн захирал Нурейл Рубини чуулганыг дүгнэжээ. Мөн тэрбээр зах зээлүүдийн хувьд өвлийн жихүүн уур амьсгал хүлээж байснаас ч удаан үргэлжлэхээр байгааг анхааруулсан. Түүний энэхүү анхааруулга манай улсад ч хамааралтай. Дэлхийн орнууд эдийн засгаа алдчихгүй торгоох гэж дор бүрнээ хичээж байна. Урьд үзэгдэж, мэдрэгдэж байгаагүй арга хэмжээг хүртэл хэрэгжүүлэхэд бэлэн байгаа.

Монгол Улсад эдийн засгаа сэргээх шаардлага бусдын тохуурхах үндэс байх учиргүй. Энэ жил бид цөхөрсөн ард байг. Ирэх жил харин Давост хэн болж очих талаараа нухацтай тунгаахгүй бол Монголын оршихуй хүртэл олон улсын доог болох нь. ■

Товчхондоо

Үйлдвэрлэл 4.0

Өнгөрсөн зууны дунд үеэс үйлдвэрлэлийн салбарт шинэ хувьсгал өрнөх болж, хөгжин өөрчлөгдсөөр 2016 онд Үйлдвэрлэлийн IV хувьсгал гэж ярих боллоо. Үйлдвэрлэл 4.0 чухам юу өгүүлж байна вэ?


Анхны хувьсгал гэх шинэчлэл 1784 онд ус болон уурын эрчим хүч ашиглан эхэлсэн бол зуу хүрэхгүй жилийн дараа хөдөлмөрийн хуваарилалт, цахилгаан эрчим хүчний тусламжтайгаар нийтийн үйлдвэрлэл бий болж, хоёр дахь хувьсгалыг өрнүүлсэн. Ийнхүү 1969 онд электроник, мэдээлэл технологи, автомат үйлдвэрлэл зэрэг шинэ өөрчлөлт өнөөдөр бидний ярьж буй Үйлдвэрлэлийн IV хувьсгалын үндэс болж байв.

Гэвч Үйлдвэрлэл 4.0 бол хувьсгалын гурав дахь үед дөрөөлсөн өөрчлөлт төдий зүйл биш. Хурд, цар хүрээ, тогтолцоонд үзүүлэх нөлөөллөөрөө өмнөх хувьсгалуудтай харьцуулахад дөрөв дэх үе шулуун хурдаар биш экспоненциаль эрчээр хөгжиж байна. Түүнчлэн дэлхийн бүх улсын бүх салбарт уламжлалт гэгдэх тогтолцоог самууруулж байна. Хиймэл оюун ухаан, nano технологи, гурван хэмжээст

хэвлэл, биолтехнологи, эрчим хүчний агууламж, жолоочгүй авто машин. Энэ бүхэн дөрөв дэх үеийн анхдагч зураглал.

Үйлдвэрлэл 4.0 дэлхийн нийтийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх потенциал арвинтай. Технологийн дэвшил хүмүүсийн өдөр тутмын амьдралыг илүү тав тухтай болгож байна. Такси дуудах, кино үзэх, төлбөр төлөх, онгоцны тасалбар захиалах гээд бүгд гарт багтдаг болж. Энэ мэтээр технологийн инноваци хангамж талаасаа урт хугацаанд үр дүнгээ өгөх үйлдвэрлэл болж хувирч буй юм. Тээвэрлэлт, харилцаа холбооны үнэ буурч, ложистик болон глобал хангамжийн гинжин хэлхээ улам бэхжин худалдааны зардал татарч, улмаар шинэ зах зээлүүд бий болсноор эдийн засгийн өсөлт нэмэгдэнэ. Гэвч энэ бүх дэвшил төдий тооны сөрөг үр дагавар үүсгэхээр байгааг эдийн засагчид анхааруулж байна. Одоогоор шинэ хувьсгал хэрхэн биелэхийг таамаглах төдий ярьж буй. Үйлдвэрлэлийн IV хувьсгал хүн төрөлхтөн, бизнесийн орчин, Засгийн газруудад олгох боломжийнхоо хэрээр шалгуур зааж буйг анхаарах хэрэгтэй.

Эцсийн дүнд бид хүн гэх ойлголтыг тэргүүнд тавьж, тэднийг хүчирхэгжүүлснээр ирээдүйн гольдролыг загварчилж болно. Хамгийн гутрангй үзлээр авч үзвэл Үйлдвэрлэлийн IV хувьсгал хүн төрөлхтнийг роботжуулах байх. Гэвч хүний мөн чанар бидний шинэ ирээдүйг тодорхойлох нь дамжиггүй. Харин ийм ирээдүй цогцлоох үүрэг, хариуцлага бидний өмнө тулгараад байна. ■



Дэлхийн эдийн засгийн чуулган

Үйлдвэрлэлийн IV хувьсгал эдийн засгийн бодлогод хэрхэн нөлөөлөх вэ?



АНДЕРС БОРГ, Дэлхийн эдийн засгийн форумын Дэлхийн Санхүүгийн систем санаачлагын удирдагч

Бидний амьдралын хэв маяг, ажил тэр ч бүү хэл өөр хоорондоо харилцах харьцааг үндсээр нь өөрчлөх технологийн хувьсгалын эхлэх цэгт зогсож байна. Профессор Клаус Швабын дэвшүүлсэн Үйлдвэрлэлийн IV хувьсгал гэх ойлголт Давост болдог Дэлхийн эдийн засгийн чуулганы энэ жилийн ерөнхий эсдэв боллоо.

Давос хотноо өрнөсөн чухал хэлэлцүүлгүүд болон Сангийн сайд, Төв болон хөрөнгө оруулалтын банкир зэрэг туршлагадаа үндэслэн дээрх хувьсгал эдийн засгийн бодлогод хэрхэн нөлөөлж болох талаар тодорхой хэдэн урьдчилсан дүгнэлт хүргэхийг зорилгоо.

Эхний онцлох асуудал бол дижитал ертөнцөд тэлж буй технологийн өөрчлөлтүүд хөдөлмөрийн зах зээлд өргөн хүрээнд нөлөө үзүүлэх болсон. Үйлдвэрлэлийн IV хувьсгал сүйрэл дагуулаа. Оксфордын Их сургуулийн Карл Бенедикт, Майлк Осборн нарын таамаглаж буйгаар хөгжингүй эдийн засгуудад нийт ажлын байрны 40-50 хувь нь өөрчлөгдөж эсвэл бүр байхгүй болно гэжээ. Иймэрхүү тооцоололд зарим нь шүүмжлэлтэй ханддаг. Тэгвэл нэгэн бодит жишээ дурьдая. Өнгөрсөн таван жилийн хугацаанд Хойд бүсийн орнуудын (Nordic countries: Атлангийн хойд болон Хойд Европын орнууд, тэдний автономит газар нутаг) банкууд боловсон хүчнээ жилд дунджаар таван хувиар бууруулжээ. Энэ хандлага ирэх таван жил үргэлжилбэл нийт цомхотгол 40 хүртэлх хувьд хүрэх юм. Энд ижил хугацаанд Хойд бүсийн банкууд хувьцаа эзэмшигчдийн ашиг хамгийн сайн хүртсэн (Return on equity) Европын банкуудын тоонд орж байгааг онцлох хэрэгтэй.

Хөдөлмөрийн зах зээлийн нэмэгдсээр буй эргэлт нь уян хатан байдал улам нэмэгдэх шаардлагыг үүсгэнэ гэсэн үг. Ажиллах хүчний эх үүсвэрийг хуучны тохиролцогч салбаруудаас шинэ, өргөжиж буй салбарт хөрвүүлж чадаж байгаа орнууд ажилгүйдлийн түвшин, боломжит өндөр өсөлтийн хүрээнд илүү олон давуу тал бий болгоно.

Хөдөлмөрийн зах зээлд дээрх аргачлалыг нэвтрүүлж буй ч өөр хандлага үүсч буй тодорхой нөхцлүүд бий. Их хямралын дараах АНУ, Их Британийн эдийн засгийн сэргэлтийн үед нийгмийн үр ашиг бүхий уламжлалт бус үндсэн ажлын байруудыг олон тоогоор гаргаж байсан. Хувиараа ажил эрхлэх байдал, богино хугацааны гэрээт, улирлын чанартай эсвэл гэрээт ажил ноёлж байлаа. Харин үүний сул тал нь ажлын байрны баталгаа үгүй болж байсанд оршиж байгаа юм.

Цөөхөн ажлын байр, бага татвар

Үйлдвэрлэлийн IV хувьсгал төсвийн бодлогод хүндрэл учруулах магадлалтай. Хэрэв машинжилт, цахимжилт ажлын байранд аюул учруулж байгаа бол энэ нь татварын орлогод нөлөөлөх нь дамжиггүй. Хэрэв ажлын байруудыг компьютер, машинаар орлуулаад байвал урт хугацаандаа хувь хүний орлогын албан татварын орлого буурна. Түүнчлэн ажлаас чөлөөлөх хүрээнд татвар дахь нийгмийн зардал болон ДНБ-ий үзүүлэлт бага байх явдал нэмэгдэнэ. Татварын нийт дүн багасах магадлал өндөр болж нийгэмд бий болох сөрөг үр дагаварыг авч үзвэл татварын хэмжээ нэмэгдэж мэднэ. Татварын орлого сөрөг нөхцөл бүрдүүлснээр жижиглэнгийн худалдаа болон НӨАТ-

ыг цахимжуулах хэлбэрийг нэвтрүүлэх шаардлага үүсэх болно. Шведүүдийн 1/3 нь Зул сарын баярын бэлгээ онлайнгаар худалдан авчээ. Тэгвэл 25-аас доош насны залуус орлогынхоо 1/3 хүртэлх хувийг интернэтээр зарцуулсан байна. Энэ утгаараа Швед тэргүүлж байна. (Хэдий Франц улсын хүн ам Шведийнхээс зургаа дахин их боловч Швед улсад дижитал зах зээл Францынхаас том). Гэхдээ бусад улс Шведийн замыг даган алхаж байна.

Дунд хугацааны өнцгөөс харвал НӨАТ-ын орлогод сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл байна. Бараа бүтээгдэхүүний эргэлт чөлөөтэй болж цахим үйлчилгээ үзүүлэгчид дижитал бүтээгдэхүүн ашиглах эрх авах болсон. (спорт, насанд хүрэгчдэд зориулсан контент, мөрийтэй тоглоом зэргийн хэрэглээ ёс зүйн хэм хэмжээ эсвэл дижитал эриний татварын тогтолцоонд бүдрэхгүй байх шиг)

Глобальчлагдсан ертөнцөд урт хугацаандаа татварын “шилжилт хөдөлгөөн” өрнөх нь тодорхой. Татварын эдийн засгийн ерөнхий онолоор бол хөдөлмөр эрхлэлтэд ногдуулах татвар нь орлогод ногдуулах татвар, нийгмийн үйлчилгээний төлбөр болон НӨАТ-ын хослол гэдэг. Хэрэв Үйлдвэрлэлийн IV хувьсгал үйлдвэрлэлийн нөхцөл болж хөдөлмөр эрхлэлтэд далд утга бий болгох бол НӨАТ-ын орлогод ч нөлөө үзүүлнэ.

Технологи vs Боловсрол

Төсвийн бодлогод хүндрэл учруулдаг хүчин зүйл бол Засгийн газруудын зардалтай холбоотой өссөөр буй дарамтууд. Бодлого тодорхойлогчдын хувьд технологийн сорилттой нүүр тулах хамгийн зохистой арга бол боловсролын салбарт хөрөнгө оруулах бөгөөд боловсрол дахин олгох явдал. Нобелийн шагналт Роберт Соловийн хэлснээр дижитал үеийн онцлог шинж бол технологи, боловсрол хооронд үүссэн уралдаан. Технологийн өөрчлөлтүүд орлогын хуваарилалтад нөлөө үзүүлж, улмаар Засгийн газрын зарцуул алт дарамт үүсгэх юм. Ажлын байранд гарах өөрчлөлт бага орлоготой бүлгүүдийн амьжиргааны ▶

Эх үүсвэрт сөрөг үр дагавар авчирна. Дижитал цаг үе технологийн шинэ саятнуудад харин ялалт байгуулах боломж. Мэргэжлийн хүмүүс болон экспертүүд 70 хүртэлх насандаа ажиллах боломжтойг бодолцож үзвэл тэтгэвэрийн орлого улам бүр тэгш бус оногдоно. Тэгэхээр тэгш бус байдалтай тэмцэхийн тулд хүүхдийн сурган хүмүүжүүлэх болон бага насны хүүхдэд боловсрол олгох санхүүжилтийг нэмэгдүүлэх хэрэгтэй. Эдийн засгийн хүчийг үл харгалзан эрүүл мэндийн болон өндөр настнуудыг асран хамгаалах үйлчилгээ нь тэгш бус байдлыг багасгах хөшүүрэг болдог. Дахин хэлэхэд, эдгээр нь төрийн зарцуулалтыг нэмэгдүүлэх шаардлага үүсгэдэг.

Энэ бүхэн тун хүндрэлтэй. Татварын хумигдалт, зарлагыг нэмэгдүүлэх шаардлага төсвийн бодлогын урт хугацааны тогтвортой байдалд харш нөлөөтэй. Үүнийг “эмчлэх” нэг арга бол нийгмийн аюулгүй байдлын зарцуулалтыг танах. Европт тэтгэвэрт эрт гарагсад, эрүүл мэндийн болон ажилгүйдлийн халамж төдийгүй хөдөлмөрийн зах зээлийн хөтөлбөрүүд төрийн зарцуулалтын 1/4-1/3-д хэлбэлздэг. Европын ихэнх оронд нийгмийн томоохон бүлгүүд, тэр дундаа залуучууд эрхэлсэн ажилгүй, боловсрол эсвэл сургалтад хамрагдаагүй байна. Италид 15-24 насны иргэдийн 20 хувь нь нийгмээс тусгаарлагдсан байгаа бол энэ үзүүлэлт Испанид 18 хувь, Их Британид 15 хувьтай байна.

Нийгмийн аюулгүй байдлын урсгал

Европт нүүрлээд буй дүрвэгсдийн хямралын уршигаар халамжийн асуудал улам тогтворгүй болж байна. Тухайлбал, 5.5 сая ажиллах хүчинтэй Швед улс 2014-2020 онд ойролцоогоор хагас сая цагаач хүлээн авахаар байгаа юм. Өнөөдөр, хэлний бэлтгэл курс, насанд хүрэгчдэд зориулсан ерөнхий боловсролын хөтөлбөр, цагаач хүүхдүүдийн эцэг, эхэд олгох чөлөө, халамжийн тусламж, орон сууцжуулах хөтөлбөр болон хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрүүдийн хослолын тусламжтайгаар олон хүн төрийн хөтөлбөрүүд дунд сэлгүүцсээр олон жилийг үдэж байна. Хөдөлмөр эрхлээгүй хүмүүст орон даяар аль ч мэргэжлээр ажил хайхыг санал болгодог ч цагаачид ихэнх тохиолдолд хөдөлмөрийн зах зээл сул хөдөө газар халамжийн олон төрлийн хөтөлбөр “хэсэн” амьдарч буй.

Нийгмийн халамжийн урсгал болон боловсрол, хүүхдийн асран хамгаалал, сургалтын салбар дахь санхүүжилтийг

нэмэгдүүлэх, мөн хувь хүний орлогын албан татварыг бууруулах нь дээрх хувьсгалын бодлогын хэрэгжилтийн нэг байна.



Хувьсгал ба Төвбанкууд

Технологи мөн мөнгөний бодлогод үр нөлөө үзүүлдэг. Үнийн тогтвортой байдлыг хадгалан үлдэхийн тулд нэг сагс хэрэглээний бараа бүтээгдэхүүний дундаж ханш аажмаар өсөх, ядаж л өндөр чанар бүхий бүтээгдэхүүний цаад хандлагыг баланслах нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй. Төвбанкууд хэрэглээний үнийн дундаж өсөлтийг жилд 1-4 хувьд (хөгжиж буй эдийн засгуудад инфляцийн ялимгүй өндөр үзүүлэлттэй) ойртуулахыг зорьдог.

Жижиглэнгийн худалдааг цахимд шилжүүлснээр хэрэглэгчийн үнийн индекст сөрөг нөлөө үзүүлнэ. Цахим талбарт тэргүүлж байгаа Швед улсад ийм зүйл электроникийн болон бусад салбарт нөлөөлөөд эхэлсэн. Тодруулбал, “Delivery hero”, “Mathem”, “Stayfresh”, “Linas Matkasse” гэх мэт онлайн худалдаалагчид хүнсний худалдааны уламжлалт аргыг “идэж” байна.

Цахим худалдааны үйл ажиллагааны зардал уламжлалт хэлбэрээс харьцангуй бага. Хямд өртөгтэй хувилбаруудаас урган гарах өрсөлдөөн нэмэгдэж байгаа нь үнэ ханшийн хүчийг сулруулж байна.

Миний дүгнэж буйгаар Төвбанкуудад үзүүлэх нөлөөгөөр инфляци буурах юм. Мөн нөөц бололцоог хэрэглэгчийн үнэд нийцүүлэн дамжуулахад урт хугацаа шаардана. Ажилгүйдлийн түвшин бага, орлого ахиухан болж үнийн индекст шахалт үүсгэхэд хэрэглэгчид онлайн худалдаа руу шилжих замаар хариу үйлдэл үзүүлэх магадлал өндөр байна.

Валютын ханшийн сулралаас үүдэх нөлөөлөл түүхэн бүтцээс бага болж мэднэ. Онолын үүднээс авч үзвэл тогтмол бууралт хэрэглэгчийн үнэд бүрэн шингэнэ. Цахим эринд мөнгөн тэмдэгтийн сулрал ашгийн бууралт хурдасч байгааг илэрхийлж болно. Хэрэв бид саяхны ам.долларын ханшийн уналтын нөлөөлөл зарим хөгжиж

буй эдийн засгуудын инфляцид хэр хязгаарлагдмал байсныг харвал, энэ нь бас нэг үндсэн хүчин зүйл байж мэдэх.

Бүтээмжийн таамаглал

Үйлдвэрлэлийн IV хувьсгал бүтээмжийг нэмэгдүүлж болно. Хэрэв санхүүжилт болон хөдөлмөрийн харилцаа шилжилт харуулж чадвал ажилтан бүрт илүү их хөрөнгө зарцуулж байна, улмаар бүтээмж улам нэмэгдэнэ гэж үзэж болохоор. Энэ нь сүүлийн жилүүдэд бидний харж байсан үйлдвэрлэлийн өсөлтийн удаашралын эсрэг ойлголт. Гэвч зарим утгаараа бүтээмжийн өсөлт удаашрах нь нөөц ашиглалт бага байгаатай холбоотой байдаг. Ерөнхийдөө бол нөөц ашиглалт, бүтээмж хоёрын хооронд хүчтэй хамаарал бий. (ашиглаж буй үед тоног төхөөрөмж илүү үр дүнтэй) Хөгжингүй эдийн засгууд үйлдвэрлэлийн хасах дүнтэй явсаар ирсэн. Одоо энэ бүхэн өөрчлөгдөж технологийн хөгжил, бага бүтээмж харилцан уялдаатай гэсэн дүр зургийг гаргаж ирж байна.

Мөнгөний бодлогын хүрээнд хийх хамгийн том дүгнэлт бол бодлогын хүү урт хугацаанд тун бага байх боломжтой. Хоцрогдсон үзэлтэй Төвбанкууд болон макро эдийн засагчид инфляцийн эрсдэлийг хэт дэвэргэх хандлагатай байдаг. Төв банкууд хэрэглэгчийн үнийн индекс таамаглаж байснаас доогуур үзүүлэлттэй гарахад залруулах гэж оролддог.

Ийм үйл явдлын эсрэг Холбооны нөөцийн банк 2016 оны индексийн улирлын өсөлтүүдийг дагахгүй болов уу. Шведийг дахин жишээлбэл, инфляци хэт бага байх эрсдэл бий. Өндөр өсөлт, хөдөлмөрийн хүчтэй зах зээл болон үндсэн хөрөнгийн үнийн өсөлт тохиоход “Riksbank” бодлогын хүүгээ алгуурхан өсгөх цаг болсон хэмээн дүгнэсэн. Үүний дараагаар бий болсон хэт бага инфляци болон дефляцийн эрсдэл инфляцийн чиг хандлагыг хэт өндөр үнэлснээс үүдсэн.

Холбооны нөөцийн банк арванхоёрдугаар сард бодлогын хүүгээ өсгөх тодорхой шалтгаантай байсан. Одоо тэд анхааралтай байж урагш алхахаасаа өмнө бодит инфляци бий болохыг хүлээх хэрэгтэй. Харилцаа өөрчлөх нь бодлогын асар том алдаа гаргаснаас хавьгүй дээр.

Үйлдвэрлэлийн IV хувьсгал айсуу. Бид эдийн засгийн бодлогод үзүүлэх нөлөөллүүдийг одоо л ойлгож эхэлж байна. Сангийн сайдууд төдийгүй Төвбанкуудын ерөнхийлөгчид суралцах ёстой огцом эргэлт дээр ирээд байна. ■

Эх сурвалж: WEF

Дэлхийн эдийн засгийн чуулган

Ч.Ганхуяг: Давост хийнэ гэж ярьсан юм аа ирээд хэрэгжүүлдэггүй

Ц.ЭЛБЭГСАЙХАН

-Жил бүрийн нэгдүгээр сард Швейцарийн Давос хотод дэлхийн нэр нөлөө бүхий хүмүүс чуулж, хэлэлцдэг. Энэ жилийн хувьд юуны тухай хэлэлцэв. Ямар хурлуудад оролцсон бэ?

-Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалтыг үндэслэгч Клаус Шваб гуай "Аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгал" ном гаргаснаа оролцогчдод танилцуулсан. Энэ хүрээнд гол асуудлуудыг хөндсөн. Хүн төрөлхтөн цахилгаан хэрэглэж, уурын хөдөлгүүр хэрэглэснээс хойш компьютер, гар утас гэх мэтчилэн технологийн хөгжил биднийг дахин нэг том өөрлөлтийн өмнө иржээ. Хүн төрөлхтөн ядуурал, өлсгөлөнгөөсөө салж чадаагүй, баян ядуугийн ялгаа арилаагүй үед бүх зүйл автоматжиж байна. Тиймээс дөрөв дэх аж үйлдвэрийн хувьсгалын дүнд хүмүүс ажилгүй болох магадлалтай. Учир нь илүү бүтээмжтэй робот хүнийг орлоно. Роботууд бүх зүйлийг хийснээр нийгмийн дундаж анги үгүй болно. Тэр бүх хүмүүс ажилгүй болох сөрөг талтай.

Дэлхийн хүн амын өсөлт дэлхийн дулаарал, улс орнуудад болж буй эдийн засаг, нийгмийн хямрал, дундад Азид болж буй мөргөлдөөн ярианы гол сэдэв болсон. Миний хувьд албан ёсны чуулга уулзалтад оролцоогүй. Гэхдээ дэлхийн залуу манлайлагчдын форумд оролцож санал солилцсон. Мөн "Монголын үдэш" арга хэмжээнд оролцоод ирлээ.

-Та жил бүр Давост очсоноор юу олж авдаг вэ?

-Би өөрөө залуу манлайлагчдын форумд байдаг. Энэ нь тэдний зохион байгуулдаг арга хэмжээнд оролцож, уулзалдаж, бас нэг Монголын нэр нүүр болохыг хичээж явдаг. Жил бүрийн чуулганаар оролцож буй хүмүүс нь баяжиж, шинэ санаанууд өвөртөлж ирдэг. Тэндээс тодорхой дүгнэлтийг хийж болдог.

-Дөрөв дэх хувьсгалын үед ажилгүйдлээс аврагдах ямар гарц бий бол. Ирсэн зочид, оролцогчдын хувьд энэ асуудалд ямар шийдэл санал



болгов, ямар хүмүүс ирсэн бэ?

-Хүмүүс оюуны хөдөлмөр хийж сайхан амьдрах боломж бий гэдгийг дэлхийн удирдагчид хэлж байна. Эдийн засгийн форумын сайн тал нь дэлхийн шилдэг удирдагчдыг нэг дор цуглуулдагаараа онцлогтой. Энэ жилийн онцлох хүн гэвэл Канадын залуу Ерөнхий сайд Жастан Трудо байлаа. Бусад нь бол яахав өнөө л ирдэг хүмүүс байсан.

-Дэлхийн чиг хандлага хаашаа явж байна?

-Дэлхий дээр болж буй бүхий л зүйлс маш их савлагаатай болчихлоо. Хятадад Шанхайн хөрөнгийн бирж савлахад л Нью-Йоркийн хөрөнгийн бирж арилжаагаа зогсоож байх жишээтэй. Хятадын удирдагч Си Жинпиний авлигатай хийж буй тэмцэл нь ихээхэн хэмжээний мөнгө хятадаас гаргахад хүргэлээ. Энэ нь өөрөө Хятадад эргэлдэж буй мөнгөнд нөлөөлж, нээлттэй эдийн засаг руу шилждэг байдлыг хааж эхэлсэн учир эдийн засгийн өсөлтийн хувь нь зургаа руу орж байна. Эдийн засгийн энэ үйл явц нь дэлхийн бусад аж үйлдвэржсэн

орнуудад нөлөө үзүүлж байгааг дэлхийн томоохон эдийн засагчид анхааралтай ажиглаж байна. Мөн Хятадын геополитикийн асуудлыг хөндөж байсан. Тухайлбал, Хятад Африкийн зарим орны өрийн асуудлыг шийдэж байгаа хэлбэрээс эхлээд Тайваньд гэхэд Хятадтай ойр дотно харилцаатай байхыг эсэргүүцдэг сөрөг хүчний намынх нь эмэгтэй ерөнхийлөгчөөр сонгогдсон. Энэ нь геополитик, эдийн засгийн дараагийн алхмуудад нь сөргөөр нөлөөж эхэллээ.

Манай орны хувьд хоёр хөршөө л сайн харах хэрэгтэй. Нэг талаасаа болгоомжлол, нөгөө талаас бидний байнгын боломж. Харамсалтай нь бид боломжуудаа ашиглах тал дээр дэндүү хойрго ханддаг.

-Дэлхийн эдийн засгийн чуулганд Монгол Улс оролцох нь ямар ач холбогдолтой юм бэ. Үр дүн нь хэр мэдрэгдэж байна?

-Дэлхийн хамгийн дээд шийдвэр гаргах түвшинд Монголыг танилцуулдаг. Монгол Улс тэнд бодлогоо танилцуулж, тэр хүмүүсийн бодлыг сонсдог. Хамгийн ▶

► гол нь дэлхий нийт аль чигт явах нь вэ гэдэг ойлголт авч дотооддоо бодлогоо зөв тодорхойлох боломж олгодгоороо ач холбогдолтой.

-Монгол Улс энэ боломжийг хэр ашиглаж байна вэ. Эргээд бодлогоо зөв тодорхойлж чадаж байна уу?

-Тэнд сонссоноо энд ирээд хэрэгжүүлдэг холбоос тасарчихсан. Тэнд хийнэ гэж ярьсан юмаа ирээд хийдэггүй. Үүнд олон шалтгаан байгаа. Ухаан нь хүрдэггүй, сэтгэл нь дутдаг. Эсвэл аль аль нь байгаад хийе, ажил хэрэг болгоё гэхээр улс төржилт орж саад, гацаа тавих асуудал бас зөндөө л бий.

Хэт үндсэрхэг үзлийг эдийн засагт бий болгож, Монголд нэг талаас фашизм, нөгөө талаас коммунизмыг байгуулахыг санаархагчид олон байна. Өөрсдөө ч үүнийгээ ойлгохгүй яваа. Тэд ядуу, айдастай амьдарч байгаа ард иргэдэд таалагдахын тулд, тэдний саналыг нь авахын тулд популизм хийж байна. Хийнэ, хэрэгжүүлнэ дээ гэж тэндээс бодож ирснийг нь тэд популизмаараа энд нурааж байдаг.

-Тэр холбоог сайжруулахын тулд юу хийх хэрэгтэй вэ?

-Монголын эдийн засгийн чуулга уулзалт ирэх гуравдугаар сарын 30, 31-нд болно. Бид саналаа салбар хуралдаануудад нэлээн сайн тусгаж өгсөн байгаа. Ер нь бол Дэлхийн эдийн засгийн форумаас Монголын хөгжлийн гурван хувилбарыг гаргаж өгсөн. Түүнийг одоо боловсруулж байгаа “Үндэсний хөгжлийн стратегийн бодлого”-той уялдуулж түүнийг дээр дооргүй хүлээн зөвшөөрч, сурталчлах ажлыг сайн хийх хэрэгтэй. Хамгийн гол нь тэр бодлогоо тууштай хэрэгжүүлэх тал дээр хамтарч ажиллах ёстой.

-Магадгүй Дэлхийн эдийн засгийн чуулганд оролцдог баг, бүрэлдэхүүнийг илүү томруулах хэрэгтэй юм болов уу. Хэрэв тэгвэл буцаж ирээд ажил хэрэг болгох, түүнийгээ хамгаалах боломж нэмэгдэх ч юм бил үү?

-Би Ерөнхий сайд яваасай гэж их мөрөөддөг. Ц.Элбэгдорж Ерөнхийлөгч улс орноо сурталчлах ажлаа их сайн хийж байгаа. Харин бодлого тодорхойлж, гүйцэтгэж байгаа хүн нь Ерөнхий сайд. С.Батболд сайдыг нэг удаа авч явах гэж оролдсон. Харамсалтай нь тухайн үед энд огцруулах санал өргөн барьснаас болоод явж чадаагүй.

Би Ерөнхий сайд яваасай гэж их мөрөөддөг. Бодлого тодорхойлж, гүйцэтгэж байгаа хүн нь Ерөнхий сайд

-Засгийн газар тогтворгүй байгаа нь Монгол Улсын нэр хүндэд нөлөөлж байгаа хүчин зүйл. Ч.Сайханбилэг Ерөнхий сайдыг огцруулах асуудал яригдаж байна. Энэ тухайд та ямар бодолтой байна?

-Муу ажиллаж байгаа Засгийн газрыг огцруулах хэрэгтэй гэдэгтэй 100 хувь санал нэг байна. Өнөөдөр Монголд болж бүтэж байгаа цор ганц төслийг муухай төсөл гэж хэлж байгаад 20 хүн тэр өргөх бичигт гарын үсэг зурсанд би харамсаж байгаа юм. Миний хамт ажиллаж байсан сайд маань хүртэл тэдний дунд байгаад их харамссан.

Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалтын үеэр Ерөнхий сайдыг огцруулах асуудал өргөн барьсан нь сөргөөр нөлөөж байгаа нь хангалттай мэдрэгдлээ. Засгийн газар бонд босгох гээд гадны банкируудтай уулзаад явж байхад ийм зүйл болсноороо гацааж орхилоо. Монголын нэг хүн 14 мянган ам.долларын өртэй боллоо гэх зэрэг этгээд тоо ярьж байна. “Рио Тинто”-гийн өөртөө авсан зээлийг хүчээр бидний нуруун дээр авч ирж үүрүүлэх маягаар тайлбарлах хэрэггүй. Энэ бол “Рио Тинто”-гийн л өр. Шангри Лаг барихад Керри групп, MCS зээл авсан бол тэдний л өр.

Улс өртэй байгаа нь үнэн. Гэхдээ тооцоо судалгаа хийгээд хариуцлагатай зарцуулах ёстой. Өмнөх Чингис, Самурай бонд шиг бэлнээр тарааж дараа нь бие биенийгээ шоронд хорьдог аргаар зарцуулж хэрхэвч болохгүй.

-Монголчууд гадны хөрөнгө оруулагчдын итгэлийг олох гэж хамгийн их царай алдсан улс гэж яригдсан тухай бүгд ярьж байна. Үнэхээр тийм байсан юм болов уу?

-Англи хэл мэддэггүй популистууд буруу мэдээлэл тарааж байна. Би МАН-ын гишүүн. Харин Давост очоод би монгол хүн. Үүнд ямар ч улстөр байхгүй. Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж уламжлал ёсоор “Монголын үдэш” арга хэмжээг зохион байгуулсан. Арга хэмжээ маш сайн болж орохыг хүссэн хүмүүсийн дараалал үүссэн байсан. Орж чадаагүй нь зохион байгуулагчдаас гуйж байлаа. “Монголын үдэш” Давост хамгийн нэр хүндтэй арга хэмжээнүүдийн нэг болсон. Сэтгүүлч Олаф Герсеман бичихдээ “Монгол Улс хөрөнгө оруулагчдын итгэлийг эргэж олохын төлөө хамгийн их

мэрийж байгаа орон” гэсэн.

Монголын эдийн засгийн форумаас энэ арга хэмжээний эхлэлийг тавьж байсан. Уг арга хэмжээг улам цар хүрээтэй болгож, Монгол Улс бол гуйлгачин гэдэг имижээс салгаж дэлхийн хурдтай хөгжиж буй соёлт хүн төрөлхтний нэг мөн гэдгийг харуулсан арга хэмжээ болсон. “Монголын үдэш” арга хэмжээ чуулга уулзалтын хамгийн хүндтэй арга хэмжээнүүдийн нэг болж чадсан. Монголын бизнесийн байгууллагууд төртэйгөө хамтраад улам өргөжүүлээд явуулаасай гэж хүсдэг.

-Сонгуулийн жил тохиож байна. Та УИХ-ын гишүүн С.Ганбаатар, Г.Уянга нарыг эсэргүүцэж байгаагаа болон Засгийн газрын талаар байр сууриа илэрхийлсэн. Нэр дэвших үү?

-Сонгуульд нэр дэвшихгүй гэдгээ өмнө нь хэлсэн байгаа. Нэр дэвших үгүйгээс үл хамаараад өөрийн үзэл бодлоо хэлнэ. Улстөр хийж байхдаа ч таалагдахын төлөө байгаагүй. Популистуудаас ялгаатай нь тэр. Популистууд зөвхөн хүний сонсьё гэж бодож байгааг л ярьж оноо цуглуулдаг. Цаанаа өөрөө юунд итгэж байна, тэр нь болох бүтэхгүй нь хамаагүй, сонгогдохын төлөө л ярьдаг, амладаг. Би сонгогдохын төлөө, таалагдахын төлөө үг хэлээ тохируулж чадахгүй. Би СЕО клубын ерөнхийлөгчөөр ажиллаж байна. Эдийн засгийн нийтлэг эрх ашгийг хамгаалах үүрэгтэй. СЕО клубт томоохон компаниуд нэгдсэн. Бас Улаанбаатар хотын худалдааны танхимд хамаарагддаг. Энэ танхимд жижиг, дундаасаа эхлээд том бизнесмэнүүд нийлж эдийн засаг, бизнесийн нийтлэг эрх ашгийг хамгаалъя гэдэг зорилгоор нэгдсэн. Хотын удирдлагууд ч дэмжсэн.

Тэгэхээр өнөөдөр Ч.Сайханбилэгийг огцруулах үгүйдээ гол нь биш. Огцруулахдаа Монгол Улсад итгэл үзүүлж хамгийн том санхүүжилтийг гадны банкууд амлаад оруулж ирж байгаа төслийг гацаах гэж оролдож байгаа гэдэг утгаар нь бид эсэргүүцэж байна. Яагаад вэ гэвэл, өнгөрсөн дөрвөн жил бидний хувьд маш хүнд байсан. Өөрсдөө татвараа төлөх гэж, ажлын байраа хадгалах гэж, гэр бүлээ тэжээх гэж бүсээ чангалж, үсээ цайлгаж, шөнө нойргүй хонож байж өдийг хүргэсэн. Өнөөдөр биднийг дахиад 4-5 жил тэс гээд ангал руу түлхэх эрх хэнд ч байхгүй. Бүх бизнесүүд ингэж харж байна.

Татвар төлж, цалин тавьж, өнөөдөр хөдөлж урагшилж байгаа бүх зүйлийг бизнесийнхэн бүтээж байгаа. ■

Монголын эдийн засгийн чуулган 2016

Б.ЛАКШМИ: Засаглалын тогтворгүй байдал хөрөнгө оруулалт, бизнесийн хөгжилд саад болдог



Ц.ЭЛБЭГ

“Монголын эдийн засгийн чуулган 2016” ирэх гуравдугаар сарын 30-31-нд болох юм. Энэ жилийн чуулга уулзалтаар ямар сэдвүүдийг хөндөх талаар “Монголын эдийн засгийн форум” ТББ ба “Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв”-ийн захирал Б.Лакшимитай ярилцлаа.

-Энэ жилийн “Монголын эдийн засгийн чуулган” ямар уриатай байх вэ?

-Монголын эдийн засгийн чуулган энэ жил гуравдугаар сарын 30-31-нд болно. “Сургамж, сорилт, шийдэл” гэсэн уриатай зохион байгуулахаар төлөвлөж байна. Бидэнд алдаж оносон зүйл их бий, ашиглаж чадаагүй боломж ч их бий. Энэ бүхнээ эргэж харж, чиг хандлагаа тодорхойлох талаар ярилцах болно.

-Энэ удаагийн чуулганы онцлог юу байх бол. Ерөнхий агуулгын хувьд ямар өөрчлөлт гарах вэ?

-Агуулгын хувьд уриандаа захирагдаж сэдэв бүрийг сургамжтай зүйл юу байв, өмнө ямар сорилт тулгарч байна, түүнийг хэрхэн шийдэж болох вэ, юу хийх ёстой вэ гэдэг талаас авч үзнэ. Ирээдүйг 100 хувь мэдэх боломжгүй. Гэхдээ бид алдаанаасаа сургамж авч дахин давтахгүй байх ёстой. Макроэдийн засгийн хувьд өнгөрсөн бүх хугацаанд үргэлж мөчлөг дагасан бодлого хэрэгжүүлж ирсэн. Эдийн засгийн өндөр идэвхижлийн жилүүдэд мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлсэн бол өнөөдрийн нөхцөл байдлаас сэргийлж болох байсан. Тиймээс өнөөдрийг хүртэл алдаж оносон зүйлээ ярилцаж, дүгнэх хэрэгтэй байна. Ирээдүйн төр, улсын удирдлагууд тэр алдааг ахиж битгий гаргаасай гэж хүсч байгаа юм.

-Ямар хүмүүс илтгэл тавих бол. Салбар хуралдаан хэлэлцүүлгийн сэдвүүд тодорхой болсон уу?

-Сэдвүүдийн талаар ярилцаж байна. Бэлтгэл ажлууд нэлээд эрчимтэй явж байгаа. Салбар хуралдаануудыг ямар сэдвээр, яаж зохион байгуулах талаар хамтран ажилладаг байгууллагуудаасаа санал авч байна. Одоохонд яг тийм сэдвээр илтгэл тавина гэж хэлэхэд эрт байна. Мэдээж жил бүр хэлэлцэж ирсэн үндсэн гэж хэлж болох сэдвүүдээр хуралдаан зохион байгуулна. Нөгөө талаас сэдвүүдийг цомхон оновчтой сонгох шаардлагатай. Энэ жилийн хувьд хөндөлгүй өнгөрч болохгүй байх гэсэн нэг сэдэв нь сонгуультай холбоотой төрийн зохион байгуулалт, засаглалын асуудал. Он гарснаар төрийн байгууллагуудын бүтэц зохион байгуулалтад ихээхэн өөрчлөлт орсон. Сонгуулийн дараа шинэ Засгийн газар байгуулагдахад ахин өөрчлөгдөх магадлал их. Иймд тогтворгүй байдал бий болох магадлал өндөр байна. Энэ бол гадаадын хөрөнгө оруулалт орж ирэхэд хамгийн их саад болдог хүчин зүйл.

Мөн бид ямар нэг салбарыг онцолж авч үздэггүй. Хэдийгээр уул уурхайн салбар уналттай байгаа ч гэсэн хүссэн хүсээгүй манай улс уул уурхайгаас хамааралтай байсаар ирсэн. Дэлхийн зах зээл дээр түүхий эдийн үнийн уналтаас болоод бууралт гарч байгаа ч менежментийн хүрээнд асуудлыг хэлэлцэж, гарц шийдэл олох боломжтой. Тиймээс боломжит бүхий л салбарыг хамруулж, хэлэлцүүлэг өрнүүлэхийг эрмэлзэж байна.

-Шинэлэг, шинээр хийхээр төлөвлөсөн ажил юу байна?

-Шинээр төлөвлөсөн ажил гэвэл бид АСЕМ-ын үеэр үйлчлэх хоолны амталгааг зохион байгуулах гэж байна. Тогооч нарын улсын аварга шалгаруулах уралдаан гэж болдог. Энэ уралдаанаар шалгарсан 35 тогоочоор АСЕМ-ын зочдод барих хоолны амталгаа хийлгэнэ. Дээд хэмжээний уулзалтын үеэр ирэх зочдын хоолны үйлчилгээ чанарт анхаарч байгаа хэрэг.

-Дэлхийн эдийн засгийн чуулган саяхан болж өнгөрсөн. Дэлхийн чиг хандлага хаашаа чиглэж байна вэ?

-Дэлхийн эдийн засгийн форумаар олон асуудлыг хөнддөг. Энэ жил эрсдлүүдийг их чухалчилж авч хэлэлцлээ. Тухайлбал, терроризм дэлхийн эдийн засагт тулгамдсан асуудлуудын нэг болж байна. Ялангуяа аялал жуулчлалын салбарт хүчтэй мэдрэгдэж буй. Ойрхи дорнодын дайнаас улбаалаад Египетийн хамгийн их жуулчин тагтаг хойд бүсийн жуулчлал багассан. Арваннэгдүгээр сард Парист болсон аймшигт халдлагын улмаас хүмүүс гэрээсээ ч гарахаас эмээдэг болсон байна. Үүнээс болоод арванхоёрдугаар сард болдог зул сар, шинэ жилийн нийт худалдаа тийм ч амжилттай байсангүй.

Түүнчлэн ОХУ-ын эдийн засгийн нөхцөл байдал, уул уурхайн түүхийн ▶

**Терроризм
дэлхийн эдийн
засагт тулгамдсан
асуудлуудын нэг
болж байна**

▶ эдийн үнийн уналт, эрэлт нийлүүлэлтийн талаар хөндөж ярьсан. Гол уриа үг нь “Аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгал” байлаа. Аж үйлдвэрийн дөрөв дэх дэвшил гэдэг нь инноваци, технологийн шийдэл байх болно гэдэг үзэл санаа дэвшүүлсэн.

-Дэлхий аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгал болох тухай ярьж байна. Гэтэл Монголын хувьд хаана нь явна вэ?

-Том дүр зургаар харвал аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгал Ази тивд их хүчтэй өрнөнө. Азид хөгжиж буй олон орон бий, сүүлийн үед үйлдвэржилт эрчимтэй явагдаж байгаа. Түүний үр нөлөө нь Монгол Улсад мэдрэгдэнэ.

-Аж үйлдвэрийн дараагийн хувьсгалын үр дүнд хүний хөдөлмөрийг технологи орлоно гэж буй. Монголд аж үйлдвэрийг хөгжүүлэх нь ажлын байрыг дэмжих ач холбогдолтой. Гэтэл технологи нь түрүүлээд хөгжчихөөр яах вэ?

-Технологийн салбар ажлын байртай холбоотой л доо. Манай улсын хувьд авч үзвэл хүн ам цөөтэй, хөдөлмөрлөх хүч цөөнтэй. Тиймээс хүчтэй нөлөө үзүүлэхгүй. Нөгөө талаас энэ хувьсгал нь технологийн хөгжил учир тэр технологийг бий болгох түүхий эд нь манайд бий нь сайн зүйл. Өөрөөр хэлбэл эргээд л уул уурхай руу орох шаардлагатай болж байгаа учраас нэг талын боломж гэж харж болох юм.

-Судлаачийн хувьд энэ жил эдийн засагт ямар өөрчлөлт гарна гэж харж байна?

-Өөрчлөлт гарна гэж хэлэхэд хэцүү юм. Гадаад орчин маань нэлээд хүндхэн байна. Тиймээс хүндхэн жил үргэлжлэх болов уу. Нөгөө талаас дотоод орчин ч бас тогтворгүй байгаа учир хөрөнгө оруулалт буурах хандлагатай байна.

-Та мөн Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв удирдлагийг бид мэднэ. Танай байгууллага аймгуудын өрсөлдөх чадварын тайланг гаргадаг. Энэ тайлан хэзээ гарах бол?

-Анх өрсөлдөх чадварын талаар 2010 оны МЭЗЧ дээр яригдаж түүнээс хойш энэ сэдвийг хэд хэдэн удаагийн эдийн засгийн чуулган дээр хэлэлцсэн. Үүний үр дүнд бид аймгуудын өрсөлдөх чадварын тайланг гаргаж, мөн орон нутгийн өрсөлдөх чадварын чуулган хийж эхлээд байна. Мөн Монгол Улс Дэлхийн өрсөлдөх чадварын тайланд ордог болсон. Энэ нь бид өөрсдийгөө дэлхийн хэмжүүрээр хэмжиж

эхэлсэн гэсэн үг. Аймгуудын өрсөлдөх чадварын тайлангийн хувьд судалгааны асуулгыг авч дууссан. Одоогоор дүгнэх ажил ид явж байна. Уламжлал ёсоор хэвлэгдэж хэрэглэгчдэд хүрнэ. Энэ тайлан гардаг болсноор аймгууд хоорондоо өрсөлдөж, эрэмбээ ахиулахын тулд дараа жил юун дээр анхаарах, аль талаараа илүү байгаа, мөн бусдаасаа юуг суралцах гээд олон давуу талтай. Тус тайланд ордог үзүүлэлтийг аймаг тус бүрээр гаргасан <http://aimagindex.mn/> цахим хуудсыг хөгжүүлсэн.

-Улсын өрсөлдөх чадварын хувьд энэ жил өөрчлөлт гарсан болов уу?

-Монгол Улсын өрсөлдөх чадварын үзүүлэлт одоохондоо гараагүй байна. Гэхдээ нэг их ахиц гарахгүй болов уу. Яагаад гэхээр Монгол Улсын өрсөлдөх чадварыг хамгийн их хойш тагдаг зүйл нь дэд бүтэц. Бусад хөгжиж буй болон хөгжингүй орнуудтай харьцуулахад дэд бүтцэд төдийлөн өөрчлөлт ороогүй. Тийм болохоор эрэмбэ ахих ч юмуу сайн өөрчлөлт гарахгүй байх.

-Ярилцсанд баярлалаа. ■

Макро эдийн засаг

Ипотекийн үнэ цэнэ

Ц.БУЯН

Үнэ хямдрах нь сайн бас муу. Чухамдаа та хэн бэ гэдгээс хамаарна. Хэрэв та худалдагч бол энэ сайн зүйл мэдээж биш. Харин худалдан авагч бол бага зардлаар ахиуг олох боломж. Гэхдээ эцэст нь би чи гэхээс гадна “бид” болон “тэд” гэдэг ойлголт бийг бас санах нь зүйтэй.

Инфляци буурчээ. Өнгөрсөн жилд 1.9 хувь болсон нь 2009 оноос хойш бий болсон хамгийн бага дүн. Махны үнийн хямдрал хамгийн бодитой мэдрэгдэж байгаа нь. Хоёр жилийн өмнө 10 мянган төгрөгөөр үхрийн мах нэг кг авдаг байсан

бол өнөөдөр хоёр кг-ийг авч болно. Өөрөөр хэлбэл төгрөгийн худалдан авах чадвар ийн сайжирчээ. Шатахуун импортлогч компаниуд түрүүчээсээ үнээ хямдруулаад эхэллээ. Бүх юмны үнэ хямдарч, инфляци буурч байгаагийн шалтгааныг тайлбарлах хоёр хүчин зүйл бий.

Эхнийх нь мөнгөний бодлого. Монголбанк өнгөрсөн гурван жилд үнэ тогтворжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлж мөнгөний бодлогод уламжлалт бус арга хэрэгсэл ашигласан. Үр дүнгийн тухайд маргаж мэтгээд байх зүйл өнөөдөр үгүй ▶



ФОТОГ Б.БЯМБА-ОЧИР

► ажээ. Нөгөө нь эрэлт багассан, иргэд худалдаж авахгүй байгаа явдал. Үүнийг иргэдийн худалдан авах чадвар муудсан гэж ойлгох, тайлбарлах нь буруу аж. Өмнө дурдсанчлан худалдан авах чадвар эсрэгээрээ өссөн байна. Бид юм худалдан авах мөнгөгүй болсноо “худалдан авах чадваргүй боллоо” гэж хэлж байгаа бол эдийн засгийн ухаанд тус өгүүлбэр эсрэгээрээ байгаа мөнгөөрөө юу ч авч чадахгүй байхыг илэрхийлнэ. Ийм нэгэн ойлголтын зөрүүнээс болоод иргэдийн худалдан авах чадвар буурав уу гэхээр өссөн юм шиг, тийм гэхэд буурсан юм шиг парадокс бий болжээ.


Гэхдээ буруу л томъёолоод буйгаас биш иргэдийн худалдан авалт инфляцид нөлөөлсөн бодитой хүчин зүйл. Харин үүнийг эрэлт талаас тайлбарлах нь зохимжтой байна. Ялангуяа ипотекийн гүйцэтгэсэн үүрэг их бий. Гурав хүрэхгүй жилийн хугацаанд 80 гаруй мянган өрх ипотекийн зээлд хамрагджээ. Энэ нь дундаж давхаргын 20-иод хувь болох бөгөөд тийм тооны өрх сарын хэрэглээний зардлынхаа тэн хагасыг танаж байгааг илэрхийлнэ. Нөгөө талаас харвал иргэдийн сонголт өөрчлөгдөж, хэрэглээ илүү цэгцтэй болж ирсэн байна. Хэрэгцээнээсээ илүү, шаардлагагүй худалдан авалт хийхээ больж, амьдралын баталгааг хангах нэг дугаарын хэрэгцээ болсон орон байрандаа хөрөнгө оруулах сонголт хийх болж. Өөрөөр хэлбэл худалдан авах чадвар буураагүй, зөвхөн эрэлт өөрчлөгдсөн хэрэг. Нэмэгдэхүүний байрыг солиход тайлбарладаг математикийн хууль шиг л ажээ.

2009-2012 онд эдийн засаг 40.2 хувиар тэлсэн байхад өрхийн хэрэглээ бодит байдалд 10 хувиар л өссөнийг эдийн засагч Г.Рагчаасүрэнгийн судалгаа харуулж байна. Хамгийн чинээлэг өрхийн хэрэглээ 21.7 хувиар өсчээ. 20-30 хувийн зөрүүг жилийн 16 хувь (2012 оны дөрөвдүгээр сар) хүрч цойлсон инфляци идэж орхисон хэрэг.

Монгол Улсын нийт айл өрхийн хэмжээнд авч үзвэл 10 орчим хувь нь ипотекийн зээлд хамрагджээ. Энэ тоо хэрэглээний сагс дахь бараа бүтээгдэхүүний эрэлтэд тийм ч жинтэй нөлөө үзүүлэх хэмжээнд, эсвэл өнөөдрийн инфляцийн түвшинд тайлбар болно гэж хэлэхэд итгэл үнэмшил төрөхөөргүй юм. Гэхдээ энэ тооны цаана хэчнээн өрх ипотекийн урьдчилгаа бий болгох зорилгоор хуримтлуулж байгааг тооцох аргагүй. Ямартай ч зээлд хамрагдаж орон сууцтай болсон 80 мянган бодит жишээ

Бид юм худалдан авах мөнгөгүй болсноо “худалдан авах чадваргүй боллоо” гэж хэлж байгаа бол эдийн засгийн ухаанд тус өгүүлбэр эсрэгээрээ байгаа мөнгөөрөө юу ч авч чадахгүй байхыг илэрхийлнэ

2009-2012 онд эдийн засгийн өсөлт ба өрхийн хэрэглээний өсөлт /өссөн дүнгээр/



бий. Тэдний адил орон сууцтай болохыг зорьж буй нь ч нэлээд бий болов уу. Статистик мэдээгээр 2013 оноос хойш иргэдийн хадгаламж 2012 оноос хойш 1.3 их наяд төгрөгөөр өссөн байна.

Инфляци нам дор байх нь олон талын ашигтай. Үүний нэг нь зээлийн хүү буурах үзэгдэл. Яг энэ үндэслэлээр ипотекийн зээлийн хүүг бууруулах боломж бүрдээд буй. Ипотекийн зээл найман хувийн хүүнд шилжих үед төв банкны бодлогын хүү 10.5 хувь, улсын инфляци 10 орчим хувьтай байв. Харин өнөөдөр бодлогын хүү 12 (өнгөрсөн оны арванхоёрдугаар сарын 22-нд нэг хувиар бууруулснаар), инфляци 1.9 хувь болжээ. Энэ нөхцөлд орон сууцны урт хугацаат зээлийн хүүг тав болгож бууруулах боломжтой гэж буй. Ийнхүү зээлийн хүү буурснаар иргэдийн хүүнд төлөх зардал 30 гаруй хувиар буурна. Энэ нь орон сууцтай болох өртөг буурч байгаагаас өөрцгүй. Дээрээс нь дундаж орлоготой өрх дотроо 1.2 сая төгрөгийн орлоготой нь л зээлд хамрагдах босготой байсныг 0.9 болгож бууруулах боломжийг таван хувийн хүү олгож байгаа юм. Эцэстээ ипотекийн тогтолцоо эдийн засгийг сахилга батжуулаад зогсохгүй, цаашид тогтвортой үргэлжлэх, илүү олон өрх айл хамрагдах боломжийг өөртөө нээсэн байх нь.

Зээлийн хүү инфляциас тийн хамаарч буй бол яагаад хоёр хувь болтол бууруулж болохгүй гэж. Тийм боломж урт хугацаанд бий болохыг үгүйсгэхгүй. Ипотекийн зээл олголт өсөх тусам инфляцийг бага түвшинд тогмол барих хөшүүрэг болох бөгөөд энэ нь хүүг өсгөхгүй байх,

улмаар бууруулах дам хүчин зүйл болж чадах билээ. Инфляци цаашдаа өсч оны эцэст зургаан хувь хүрэх хандлагатай байгаа юм. Цаашид гадаад, дотоод хүчин зүйлийн нөлөөгөөр эдийн засагт “шинэ тэнцвэр” бий болж, инфляцийг 5-7 хувьд тогтоон барих боломж бүрдэж байгаа нь уг зээлийн хүүг бууруулах суурь нөхцөл болж байгаа аж.

Ганц ипотека ч бус. Бусад зээлийн хүүг ч бууруулахаа Монголбанкны Ерөнхийлөгч мэдэгдсэн. Гэхдээ эхний шатанд хуримтлалыг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх, экспортыг дэмжих зээлийн хүүг бууруулна хэмээсэн. Хөдөө аж ахуй, хүнсний болон боловсруулах үйлдвэрлэлийн салбарт давуу байдал бий болох нь. Харин хэрэглээний зээлийн хүүгийн хувьд инфляци үүсгэх үр дагавартай учир нэг их яарахгүй байгаа аж.

Эцэст нь найман хувь бидэнд юуг үлдээв. Үүнийг мэдэхийн тулд урсгал дансны тэнцлийг харах хэрэгтэй. Эдийн засаг хоёр оронтой тоонд өсч, гадаадын хөрөнгө оруулалт Монгол руу цутгаж байх үед импорт 99 хувиар өсч (2011 он), урсгал дансны алдагдал 3.3 тэрбум ам.доллар (2012 он). Харин өнгөрсөн жил уг алдагдал 396 сая ам.доллар (эхний 10 сарын урьдчилсан гүйцэтгэл) болж буурчээ. Энгийнээр бол, хөрөнгө оруулалтыг хасаад бидний гадагш өгсөн болон гаднаас авсан нь хэдэн жилийн өмнөхтэй харьцуулахад бараг тэнцэж ирээд байна. Энд дурдагдсан тэрбумаас сая ам.долларт хүрсэн зөрүү нь бидний өөртөө авч үлдсэн зүйл буюу хуримтлал. Харин тэдний хувьд алдагдсан орлого юм. ■

14 хоногийн сэдэв

АСЕМ-аар “амьсгалахаас” ӨМНӨ



Г.ОРХОН

2016 он Монгол Улсын хувьд чухал жил. Учир нь ирэх долдугаар сарын 15-16-нд манай улс Ази, Европын дээд хэмжээний 11 дэх уулзалтыг эх орондоо зохион байгуулна. Энэ тухай бид өнгөрсөн оны турш ярьж ирсэн бол хоёрхон сарын дараа Улаанбаатар хот АСЕМ-аар “амьсгалж” эхлэх нь.

АСЕМ-ийн уулзалтын бэлтгэл ажлын хүрээнд зургаан ажлын хэсэг ажиллаж байгаа бөгөөд уулзалтын дагалдах хурлууд ирэх дөрөвдүгээр сараас эхлэх тов гарчээ. Дөрөвдүгээр сарын 21-22-нд Ази, Европын парламентын есдүгээр уулзалт болох бол залгуулан Сангийн сайд нарын уулзалт, Бизнес форум зэрэг томоохон хурал АСЕМ-тай холбоотой болно.

Д/Д	Хурлын нэр	Хугацаа
1.	Ази-Европын парламентын түншлэлийн есдүгээр уулзалт	4 сарын 21-22-нд
2.	АСЕМ-ийн Ахлах албан тушаалтнуудын уулзалт	5 сарын 12-13-нд
3.	АСЕМ-ийн Сангийн сайд нарын 12 дугаар уулзалт	6 сарын 9-10-нд
4.	Ази-Европын хүнсний аюулгүй байдал, фермерийн сургалт	6 сарын 20-21-нд
5.	Ази-Европын иргэний нийгмийн 11 дүгээр чуулга уулзалт	7 сарын 1-2-нд
6.	АСЕМ-ийн Загвар чуулган 2016	7 сарын 6-7-нд
7.	АСЕМ-ийн Ахлах албан тушаалтнуудын уулзалт	7 сарын 12-14-нд
8.	Ази, Европын Бизнесийн 15 дугаар чуулга уулзалт	7 сарын 13-14-нд

Тиймээс АСЕМ-аар “амьсгалахаас” өмнө хийх бэлтгэл ажлаас гадна дагалдах хурлуудад яаравчлан бэлтгэх шаардлага бидэнд тулгарч байгаа юм. Бэлтгэл ажилд төдийгүй, хурлыг зохион байгуулахад Монгол Улсад дэмжигч туслах орон, олон улсын байгууллахад нэлээд бийг АСЕМ-ийн Бэлтгэл ажлын албаны ахлах албан тушаалтан, Швейцарь улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Л.Оргил хэлсэн. Тухайлбал, Европын Комиссын зүгээс АСЕМ-ийн уулзалтыг зохион байгуулахад бүхий л талаар дэмжлэг үзүүлэхээ Монгол Улсын Ерөнхийлөгчид амлаад буй. Ахлах ажилтнуудын хурлын зардлыг Европын холбоо, Залуу лидерүүдийн дээд хэмжээний уулзалтад оролцогчдын зардлыг Ази, Европын сан, 50 гаруй орноос ирэх оюутнуудын зардлыг Швейцарь улс даахаар болжээ. Мөн Европын холбооны дэмжлэгтэйгээр манай улсын зургаан орчуулагч Бельгийн Брюссель хотод таван сарын сургалтад хамрагдаж байгаа. ▶



► Уулзалтын бэлтгэл ажлын хүрээнд Хөдөлмөрийн яам АСЕМ-ийн ажлын хэсэгтэй байгуулсан хамтран ажиллах санамж бичиг үзэглэж, 47 зочид буудалд ажиллах 3200 хүнийг бүртгэж сургалтад хамруулахаар болсон. Энэ дагуу зочид буудлууд хүмүүсээ авч, хэлний сургалт явуулж эхлээд байна.

Мөн дээд хэмжээний уулзалтад зориулж эхний ээлжинд тусгай тоноглол бүхий 350 автомашин импортлохоор болоод буй. Эдгээрийг хувийн хэвшлийнхэн оруулж ирэх бөгөөд импортоор оруулж ирэх автомашиныг гаалийн, нэмэгдсэн өртгийн болон онцгой албан татваруудаас чөлөөлөх юм. Одоогоор автомашинуудыг оруулж ирэх талаар Монголд автомашин импортлогч томоохон компаниудтай хэлэлцээ хийж байгааг Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг мэдэгдсэн. Харин төр компаниудын оруулж ирэх автомашиныг татвараас чөлөөлж байгаа учир түрээсийн төлбөрт ямар нэгэн төлбөр төлөхгүй. Энэ нь төсвийн орлого блон зардлага талд ямар нэгэн өөрчлөл гарахгүй гэдгийг Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогт онцолсон.

Гэхдээ улсын эдийн засгийн байдал хүнд, төсөв мөнгө тарчиг буй үед төрөөс зардал гаргахгүйгээр шийдэх боломж бийг иргэд цахим ертөнцөөр илэрхийлж, жиргээчид л гэхэд “АСЕМ-д туслая” аяныг өрнүүлэв. Тухайлбал, “АСЕМ-д зориулж 350 автомашин шинээр авч татвараас чөлөөлж ашиглана гэсэн. Тэр мөнгөөрөө хэдэн цэцэрлэг барьчих. Бидэнд дипломат арга хэмжээнд тохиромжтой 350 байтугай машин байна. Хоёр өдөр улсдаа үнэгүй үйлчлэхдээ баяртай байх болно...” гэх зэргээр өөрсдөд буй боломжоо илэрхийлжээ. Үүнээс АСЕМ-ийн уулзалтад санаа зовних хийгээд бэлтгэл ажилд туслах хүсэлтэй хүн олон бийг харж болох юм.

АСЕМ-ийн бэлтгэл хангах ажлын хэсгийнхэн хурлын үеэр ирэх төлөөлөгчдийг байрлуулах 47 зочид буудлыг захиалгын нэгдсэн системд хамруулахаар ажиллаж байгаа аж. Түүнчлэн түнш зочид буудлуудын хоол хүнсний стандартыг ХХААЯ-ны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газартай хамтран баталж, үндэсний нэрийн хоол гаргах аж. Тус уулзалтаар үндэсний ёс заншил, соёлыг түлхүү сурталчилах юм.

Энэ онд АСЕМ-ийн 20 жилийн ой тохиож буй тул зохион байгуулагч оронд ирэх хариуцлага өндөрсөж буйг албаныхан онцолж байна. Уг ойд зориулан манай улс хүндэтгэлийн тоглолт зохион байгуулахаас гадна “Монгол Шуудан” компанийн Маркийн газартай хамтран АСЕМ-ийн 20 жилийн ойн хүрээнд хоёр номинал бүхий хэлхээ марк гаргахаар болжээ.

Монгол Улсын хувьд тус уулзалтыг амжилттай зохион байгуулснаар олон улсын тавцанд манай орныг дэмждэг улсуудын тоо нэмэгдэх нь гарцаагүй гэж үзэн 2022 онд болох НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн сонгуульд нэрээ дэвшүүлээд байгаа аж. Нөгөөтэйгүүр, АСЕМ-ийн хүрээнд ажил хэргийн аялал жуулчлал дөрвөөс долдугаар сарын турш үргэлжлэх нь. Ингэснээр Улаанбаатар хотын зочид буудал, үзвэр үйлчилгээ, худалдааны газрууд, компаниудын орлого нэмэгдэж, шинэ түнштэй болох бизнесийн урт, дунд, богино хугацааны гэрээ хэлцэл үзэглэх боломжууд гарч ирнэ гэж албаныхан үзэж байна. Мөн уг уулзалтын ачаар сүүлийн жилүүдэд хумигдаад буй гадаадын хөрөнгө оруулалтын урсгал нэмэгдэх хүлээлт бий.

АСЕМ-ийн гишүүн орнуудад бөмбөрцгийн нийт хүн амын 63 хувь нь амьдарч, дэлхийн ДНБ-ий 60 хувийг үйлдвэрлэж байна. Гэхдээ хоёр тивийг холбосон худалдааны сүлжээ өнөөг хүртэл бий болоогүй байгаад талууд шүүмжлэлтэй ханддаг. Энэ мэт асуудлаа АСЕМ-ийн гишүүн 50 гаруй орны төрийн өндөрлөгүүд дээд хэмжээний уулзалтаараа хэлэлцдэг жамтай. ■

Үйлдвэржилт

ХОТЫН ЖИНС



Фотог Б.Бямба-Очир

Хотын жинс брэнд улам өргөжиж байна

Г.ОРХОН

Их хотын дэгжин залуус үндэсний хэв маяг бүхий жинсэн хувцсаар давтагдашгүй загварлаг төрхийг бүрдүүлдэг болоод удаагүй. Тэдний сэтгэлийг гижигдэж, халаасаа хоослохоос үл буцам байдалд оруулан шохоорхлыг нь татаж буй брэнд “Urban jeans”. Олны сонирхлыг ингэж ихэд татаж буй тус брэндийг бойжуулж, өлгийдөн авдаг үйлдвэртэй сурвалжлагч миний үзэг танилцсан нь энэ.

“Urban jeans” брэндийн уг гарал “Денимон” ХХК, суугуул нутаг нь Хан-Уул дүүргийн урд байрлах арьс ширний нэгдлийн хашаан дотор бий. Гаднаас нь харсан хэн ч дотор нь үйлдвэрлэл ид өрнөж яваа гэж төсөөлөх байтугай, хажуугаар өнгөрсөн хэр баргийн хүн тоож харахааргүй навсгар байшинд “Urban Jeans” болон түүний “ах, дүүс” төрж байна.

Тэдний хувьд өдгөө нэг бэрхшээл бий гэнэ. Энэ бол тус сурвалжлагын эхэнд дурдсан байрны асуудал, түүнээс үүдэлтэй ажиллах орчин. “Денимон” компанийнхан мэргэжлийн хяналтын байцаагчдаас удаа дараа сануулга авчээ. Учир нь тус үйлдвэрийн байр цайны газрын зориулттай тул зай орчны стандартыг хангадаггүй байна

Гэхдээ анх хоёр гуравхан оёдолчин, хэдхэн машинтайгаар орон сууцны байрны подволд жинс оёж эхэлсэн бол өнөөдөр 100 гаруй ажилтантай үйлдвэр болж өргөжөөд байгаа нь энэ. “Денимон” компанийнхан өнгөрсөн онд борлуулалтаа 2.8 дахин өсгөж чаджээ. Хямралын үед ашигтай ажиллаж үйлдвэрлэлээ өргөжүүлж чадсан тэдний нууц ердөө энгийн. Шаргуу хөдөлмөр, зардал үл харамласан маркетинг. Мөн Засгийн газрын хөнгөлөлттэй зээл тэдэнд санхүүгийн томоохон хөшүүрэг болж өгчээ. Тус компанийнхан 2014 онд Чингис бондоос 600 сая төгрөгийн санхүүжилт авсан юм. Улмаар тэд үйлдвэр хийгээд брэндээ өргөжүүлж, үйлдвэрийн бүрэн хүчин чадлаараа буюу өдгөө сардаа 10 мянга орчим жинсэн хувцас үйлдвэрлэж явна. Үндсэн түүхий эд болох ►

▶ “деним” гэх материалыг Солонгосоос, товч, цахилгаан тэргүүтэй туслах материалаа урд хөршөөс татаж авдаг байна.

Загвар зохион бүтээгчдийн өрөөний баруунтай байрлах “Денимон” компанийн захирлын өрөөг зорих замд таарсан ажилтан бүр найрсаг инээмсэглэл, залуу насаар гоёсон байлаа. Учир нь чадварлаг залуу хамт олноор эдний баг бүрджээ.

Тус компани 2015 оны байдлаар улсад 350 сая орчим төгрөгийг тагвар, нийгмийн даатгалын шимтгэл хэлбэрээр төвлөрүүлж, Улаанбаатар хотод ес, орон нутагт 10 салбар нэрийн дэлгүүр нээн ажиллуулж байна. Харин 2016-2017 онд дотоодын жинсэн хувцасны хэрэгцээний 30 хувийг дангаар хангах зорилт тавин ажиллаж байгаа аж.

Хөнгөн үйлдвэрлэл ялангуяа, оёдлын салбар уналтад орсон энэ үед тэд ийн амжилттай ажиллаж чадсаныг салбарын яам үнэлэн Аж үйлдвэрийн салбарын тэргүүн дээр шагналын алдар зүүлгээд удаагүй. “Анх дүүгийнхээ байр савыг заран байж жижиг подволд оёдлын цехээ нээсэн. Оёж болж байгаа юм. Дараа нь угааж боловсруулах нарийн технологи бий. Үүнийг эзэмшихэд нэлээд хэцүү, шантрах үе байсан ч чадгалаа авна гэж зүтгэсэн. Хэдэн ч жил цалингүй ажиллачихав. Дүү бид хоёр сүүлийн хоёр жил л цалин авч байна” хэмээн “Денимон” ХХК-ийн захирал Д.Тунгалаг яриу. Мөн тэрбээр “Аж үйлдвэрийн салбар яамтай болсноор хууль дүрэм бодлогын баримт бичгийн боловсруулахад нэгдсэн яамтай байх, үйлдвэрлэгчид ч төр захиргааны байгууллагуудтай яамаар дамжуулан харьцахад амар болсон” гэснийг энд тэмдэглэе.

Тэд дэлхийд түгээмэл биш технологийг таван жилийн турш судалж сүүлийн хоёр гурван жилд дэлхийн түвшинд хүрэхээр жинс үйлдвэрлэж чаддаг болоод байгаа аж. Нэг жинсэн өмд л гэхэд ойролцоогоор 100 орчим дамжлага дамжин нэгээс хоёр хоногт үйлдвэрээс гарч, хэрэглэгч та бид өмсөхөд бэлэн болдог байна. Жинсэн хувцсыг үйлдвэрлэхэд ийм их ажиллагаа шаарддаг бөгөөд монголчуудад илүү тохиромжтой өмсгөл бүхий жийнс зөвхөн “Urban Jeans” гэдэг нь хэрэглэгчдийн сэтгэл ханамжаар батлагдаад буй. Учир тус компанийнхан монгол хүний антом дээр судалгаа хийсний дүнд бидэнд илүү тохиромжтой жинс үйлдвэрлэж буй. Ургын хувьд л гэхэд нэг размераас гурван өөр урттайгаар үйлдвэрлэдэг нь тэдний давуу тал.

Зөвхөн жинс гэлтгүй үндэсний хэв маягтай деним материалтай хувцас үйлдвэрлэдэг болсныг энд онцлоё. Цаашид хувцасны бүх төрлийг үйлдвэрлэн “Urban” брэндийн дүү нарыг төрүүлэх нь тэдний ойрын зорилго гэнэ. Харин үнийн тухайд Д.Тунгалаг “Урд хөршийн бараа, бүтээгдэхүүнтэй өрсөлдөхөд бэрхшээлтэй байгаа нэг зүйл нь лангууны бизнес эрхэлдэг хүмүүс бага татвараар бараагаа оруулж ирж байна. Гэтэл бид материалаа оруулж ирэхээс эхлээд бүхий л шатандаа улсад төлөх ёстой бүх татварыг төлснийхөө дараа урдаас орж ирж байгаа жинстэй үнийн хувьд өрсөлдөнө гэдэг хүндрэлтэй. Гэсэн ч өрсөлдөж чадаж байна. Хүн болгон төлөх ёстой татвараа шударга төлвөл жинхэнэ шударга өрсөлдөөн бий болно” хэмээсэн.

Тэдний хувьд өдгөө нэг бэрхшээл бий гэнэ. Энэ бол тус сурвалжлагын эхэнд дурдсан байрны асуудал, түүнээс үүдэлтэй ажиллах орчин. “Денимон” компанийнхан мэргэжлийн хяналтын байцаагчдаас удаа дараа сануулга авчээ. Учир нь тус үйлдвэрийн байр цайны газрын зориулттай тул зай орчны стандартыг хангадаггүй байна. Наад зах нь угаалгын цехийн хэсэгт угаалгын машинуудыг хананаас 1.5 метрийн зайд байрлуулах ёстой атал эднийх ханандаа шахаад байрлуулжээ. Үйлдвэрийн ажилчдын хэлж буйгаар ингэж тавихгүй бол өнөөх хэдэн машин нь багтдаггүй аж. Ер нь ганц “Денимон” гэлтгүй хөл дээрээ босох



Жинсэн хувцасны үндсэн түүхий эд болох “деним” гэх хөвөн даавуун материалыг эсгэж буй нь



“Денимон” компанийн үйлдвэр бүрэн хүчин чадлаараа буюу сардаа 10 мянга орчим жинсэн хувцас үйлдвэрлэж байна



“Urban Jeans” брэндийн дүү нар үйлдвэрийн угаалгын хэсэгт

гэж яваа дотоодын олон үйлдвэр хүссэн байрандаа үйлдвэрлэл эрхэлж чаддаггүй нь нууц биш. Гэхдээ тус компанийнхан одоо байгаа байрныхаа дэргэдэх арай том талбайтай байр руу буурь сэлгэх гэнэ.

Дэлхийн загварын чиг хандлага өнгөрсөн үе рүү эргэж байгаа ч хуучин цагийн “босоо жинс”-ийг халж, нимгэн, сунадаг жинс трэнд болж байгааг загварынхан онцолж буй. “Urban Jeans” брэнд ч мөн ийм шинж төрхөөр залууст танигдсан. Цаашид тус үйлдвэрийн үйлчин бүсгүйчүүд “деним” материалаар илүү олон төрлийн хувцас үйлдвэрлэж, Хотын жинс брэндээ өргөжүүлэх гэнэ. ■



Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хэсэг

Монгол

- 66 Санхүүгийн зах, 2016 онд
- 67 Эргэн ирэх цаг
- 69 Гурвалжин
- 70 Мацаг бариулчихгүй л бол
- 73 Гариг дэлхийгээ аврах эрин үеийнхэн
- 76 Ганц л салбар
- 77 Тохируулын станц
- 82 Бээжинд 4, Лондонд 5, Риод ...?
- 83 Устгагч
- 84 Хоёр дахь үнээ
- 85 Монголын үр чадвар дэлхий рүү
- 86 Авлигын түвшин 3 сая
- 87 Хонгилын үзүүрт гэрэл
- 90 Бонсай хайчлах цаг
- 91 Боломжийг ашиглах жил
- 93 Сусловын хүүхдүүд



Дампуурсныг сэргээгч
Түүний бизнесийн түүх унасныг босгож, дампуурсныг сэргээснээр өрнөнө, хуудас 74



Монгол-Төвийг сахих



Стандарт бол зах зээлд гарах гарц



Өмнөх ба дараах 25 жил



Бид баян улс уу, ядуу улс уу



Байж болох бүхнийг шүү

2016 оны Парламентийн сонгуулийн гол өрсөлдөөн хоёр Энхболдын тэргүүлсэн намуудын хооронд болно, хуудас 63



Улаанбаатарын төрх

Газраа байраар солих уу, хашаандаа хаус барих уу, хуудас 65

The Economist-ийн хэсэг



Удирдагчид

Нэгэн либералийн гаслан
Радикал төв үзэлтнүүд дуу хоолойгоо хүргэх цаг ирлээ
Том нь томрох цагаар-
Том амбицийг магтан дуулая

Британи

Сөрсөн ноёрхол
Торичууд хуваагдмал гэхдээ давамгай хэвээр
Гурван эцэг эхтэй хүүхдүүд
Гайхамшигт шинэ ертөнц дэх нялхас

Европ

Путины дарамт
Гадаад дахь адал явдлын дараа дотоод дахь тогтворгүй байдал

АНУ

Цагаан ордон хүртэлх зам
Хэрцгийг бас үнэтэй кампанит ажил
Обамагийн сүүлийн хугацаа
Бадрангуйгаар дуусгаж чадах уу

Хоёр Америк

Улс төрд медаль үгүй
Бразилийн Олимпын жил дээрх сүүдрүүд
Ёроолоос хөндийрөхгүй өсөлт
Латин Америкийн тойм
Ази
Сонгохгүйг хичээж байна
Хятад Америкийн дунд хавчуулагдсан нь
Бүс тойрсон сонгууль
Хятад хүчин зүйл

Хятад

Мандаж буй нарууд
Хятадын шинээр гарч ирж буй хотууд
Дундарч буй хаант улс
Эдийн засгийн зовнил намжина
Эдийн засгийн зураглал
Илүү гүн шинэчлэлийн тухайд Ли Кэцян



Ойрхи Дорнод

Өрсөлдөгчид болон нөхөрлөл
Саудын Араб болон Иран

Африк

Жинхэнэ эвэр хэнд хэрэгтэй гэж?
Хулгайн анчдыг ялан дийлэх сайхан арга

Олон улс

Дээрэнгүй эрчүүд
Удирдагчдын шинэ хэв маяг



Ирээдүйг төсөөлсөн бодлууд


Таамаглалыг хэмжих нь
Филип Тетлок болон Дан Гарднер оноогоо хадгалах нь
Том мэдээллийн санг ашиглахуй
Хал Вариан болон Мартин Флеминг одоогийн таамаг

Дэлхийг тоогоор

128 81 улсын урьдчилсан таамаг
140 14 салбарын урьдчилсан таамаг

Бизнес

Түгшүүрийн цагаан хэрэм
Доогуур өсөлттэй Хятадтай зохицон амьдрах нь
Том Ах менежмент
Гүйцэтгэлийн үнэлгээ баяртай



Санхүү

Зах зээлүүдийн хувьд жирийн жил биш
Онцгой үүлэрхэг төлөвүүд
10 тэрбум ам.долларын клуб
"Fintech" бол жинхэнэ бизнес



Шинжлэх ухаан, технологи

Эрхтэн төстийн жил
Лабораторт биеийн хэсгүүдийг өсгөж байна

Соёл

Энэтхэг ба дэлхий нийт
Хоёр урсгалт зам

Эмгэнэл

Алдагдсан үсгийн төлөөх гуниглал
Ерөнхийболовсролын шалгалтаас хасагдаж буй үгс



“Дэлхий 2016” сэтгүүл Монголд

Эдийн засаг, бизнес-ийн чиглэлийн англи, монгол хэл дээрх “Mongolian Economy” сэтгүүл 173 жилийн түүхийг бүтээсэн, дэлхийн тэргүүлэх сэтгүүл “The Economist”-ийн жилийн “The World in 2016” дугаарыг тусгай зөвшөөрлийн хүрээнд хийж, уншигчдадаа хүргээд байна. Бид уг сэтгүүлийн анхлан хэвлэгдэж хүмүүст хүрсний 30 дахь жилийн тэгш ойн үеэр нь Монгол Улсад гаргаж байгаадаа баяртай байна. Эл үйл явдал 2011 оноос англи-монгол хос хэл дээр хэвлэгдэж эхэлсэн манай “Mongolian Economy” сэтгүүлийн ч гэсэн таван жилийн ойн үеэр тохиосныг тэмдэглэхэд таатай байна.

“The Economist” сэтгүүл өөрийн гэсэн олон брэндингтэй. Тэдгээрийн нэг томоохон нь айсуу жилийн дэлхийн чиг хандлагыг угтан таамагладаг дэлхийн тухай дугаар юм. 1987 оноос эхлэн гарсан энэ сэтгүүл өдгөө дэлхийн 50 гаруй оронд тухайн орных нь хэлээр гардаг. Өөрөөр хэлбэл, “The Economist” өөрчлөгдөн буй дэлхийн ирээдүйг 30 дахь жилээ таамаглаж байгаа гэсэн үг. Зүгээр ч нэг төлөв гаргаад орхих биш, энэ сэтгүүлд өгүүлсэн төлөвийнх нь 90 хувь биелдэг гэдгийг уг сэтгүүлийн зүгээс баталсан. Тийм ч учраас цэнхэр

гаригийн өнцөг булан бүрийн мянга мянган уншигчид нь эргэн ирдэг тухай “Дэлхий 2016” сэтгүүлийн эрхлэгч Даниел Франклин онцлон тэмдэглэжээ. Тухайлбал, “Дэлхий 1987”-д Роналд Рейганы АНУ болон Михайл Гробачевын ЗХУ-ын харилцаа зөвлрөхийг таамаглаж байсан бол 30 дахь удаагийн дугаартаа түрэмгий ОХУ болон сүрийг бадруулах БНХАУ-ын талаар хөндөж санаа зовиносон бөгөөд 30 жилийн өмнө дууддаг ч байгаагүй цахим худалдаа, санхүүгийн технологи болон гурван эцэг эхтэй хүүхдүүд зэрэг сэдвийг судалсан байх жишээтэй.

Мөн тус сэтгүүлд 2016 оныг гурван үгээр: зовлон зүдгүүр, эмэгтэйчүүд болон ялалт гэж дүгнэжээ. Яагаад гэдгийг нь бидний хичээн байж гаргасан “Дэлхий 2016” дугаараас дэлгэрэнгүй уншаарай.

Бид тусгай зөвшөөрөл эзэмшигч болж дэлхийн нэр нөлөө бүхий олон зуун жилийн түүхийг бүтээсэн сэтгүүлийн өндөр стандартыг дагаж мөрдөж, дэлхийтэй хөл нийлүүлсэндээ баяртай байна. Гэхдээ амаргүй шалгуур байсан ч хэр чадлаараа хичээж, Монголын хэвлэл мэдээллийн зах зээлд шинэ стандарт, шинэ мэдлэг, шинэ соёлыг авч ирсэн гэдэгтэй эргэлзэхгүй байна. Манайх жил бүр энэхүү тусгай дугаарыг

гаргах учраас өөрийн гэсэн уншигчдыг ч бэлтгэх учиртай.

“Дэлхий 2016” сэтгүүлийн дэлхийн улс төр, эдийн засгийн 2016 оны нөхцөл байдлыг таамагласан гайхалтай нийтлэлүүд таны сонирхлыг лавтайяа татна.

Мөн манай “Mongolian Economy” сэтгүүлийн сэтгүүлчдийн болон Монголын салбар бүрийн шилдэг мэргэжилтнүүдийн бичсэн 2016 оны талаарх нийтлэлүүд танд мэдлэг, мэдээлэл өгнө гэдэгт бүрэн итгэлтэй байна.

Дэлхийн тэргүүлэх эдийн засгийн “The Economist” сэтгүүлийн тусгай дугаар “The World in 2016” дугаарын агуулгын бүтцийг товчлон хүргэвэл:

- 18 бүлэг тив, их гүрнээр нь ангилсан,
- 146 нийтлэл,
- 81 улсын тухай онцлох мэдээлэл, эдийн засгийн үзүүлэлтүүд,
- 13 салбарын тухай мэдээлэл, төлөв
- 2 цагалбар, Дэлхийн ба Монголын онцлох үйл явдлуудаас бүрдсэн

Энэ бүх мэдээллийг багтаасан бөгөөд бүтэн жилийн туршид таны ширээн дээр байхад хуучрахгүй мөн таныг уйдаахгүй харин ч нээж унших бүр оюуныг тань ундаалах болно. ■

Төлөв

Дэлхий 2016 онд: 7.3 тэрбум хүн, 197 үндэстэн, 1 гариг

Б.ЭНХЦЭЦЭГ

Ирээдүй юуг агуулж байгаа бол гэж та боддог уу? 2016 онд ямар мөч дэлхийг нэгтгэж, ямар мөч дэлхийг салгах вэ? Ямар хүмүүс, газрууд мөн төлөвлөгөөнүүдийг анхааралтай ажиглах ёстой вэ? Ирээдүйг тодорхойлох үйл явдлыг болохоос нь өмнө “Дэлхий 2016” хөтөч дугаараас урьдчилж мэдэж болох юм. “Дэлхий 2016” хөтөч дугаар доорх үйл явдлуудыг ирэх онд дэлхийг тодорхойлно гэж үзжээ.

Бразилийн Рио Де Жанерод наймдугаар сард 31 дэх Олимп дэлхийг нэгтгэнэ. Олон улсын өрсөлдөөн олны анхаарлыг булаахуйц нэн сонирхолтой байх нь дамжиггүй. Гэхдээ аль улс медалийн жагсаалтыг тэргүүлэх вэ.

Ноён оргилын төлөө хүчтэй тэмцэх нэг улс нь БНХАУ юм. Хятадын Олимпийн сургуулилын төвүүдтэй барууны хэвлэл мэдээлэл танилцаж, сурвалжлах эрх авна гэдэг тун ховор тохиол. Медалийн жагсаалтад тэргүүлэхэд бүх спортын төрөл хамаарна. Тиймээс Хятадууд бүх төрөлд амжилт гаргахын төлөө шаргуу хөдөлмөрлөж байгаа. Хятадуудад Риогийн Олимпт америкчуудыг медалийн тавцангаас түлхэж унагах төлөвлөгөөтэй. Тэд хөнгөн атлетикийн төрлүүдэд төдийлэн медаль горилохгүй. Харин бусад өөрсдийн хүч бололцоог шавхаж чадах талбаруудад хүчээ сойхоор зэхэж буй. Учир нь тэд америкчуудыг биеийн хөгжлийн хувьд хамаагүй илүү гэж боддог ба харин хятадуудын сайн тал нь техник гэж үздэг. Тухайлбал, хөнгөн атлетикийн төрөлд л гэхэд одоогоор 51.000 тамирчинг үндэсний болоод бүсийн хэмжээнд бэлтгэж байна. Цаашлаад 400.000 хүүхэд орон нутгийн атлетикийн сургуулиудад сурч байна. Эдгээр сургууль хүүхдүүдийг зургаан насанд нь элсүүлдэг. Тус спортын төрлөөр Олимпт оролцох авьяас чадалтай эсэх нь бэлтгэл хийж эхэлснээс хойш 2-3 жилийн дараагаас мэдэгдэж эхэлдэг гэж тэд үздэг. Өндөр жин, булчингийн масс, биеийн хэлбэрийн үзүүлэлтүүдээр дүгнэх нь шинжлэх ухааны үндэслэл бүхий арга

юм. Хятадын тэргүүлэгчдийн төлөвлөгөөний дагуу жил бүр дасгалжуулагчид олон зуун хот суурин, тосгодоор зочилж, олон мянган хүүхдийг тодорхой шалгууруудаар шалгадаг. Нэгдүгээрт, Биеийн хэлбэр, хоёрдугаарт ур чадвар, гуравдугаарт сэтгэлзүйн байдал чухал гэж хятад дасгалжуулагчид хэлж байна.

Хятад зөвхөн 2013 онд л гэхэд Олимпийн бэлтгэлийнхээ дэд бүтцэд нэг тэрбум ам.долларыг зарцуулсан нь дэлхийн аль ч улсын зарцуулалтаас хавьгүй өндөр дүн юм. Шүүмжлэгчид энэ төрлийн эрчимт бэлтгэлийн хөтөлбөрүүд хүүхэдтэй зүй бусаар харьцаж байгаатай адил хэмээн мэтгэдэг. Харин дасгалжуулагчид эдгээр хүүхдийг энэ сургуульд сурснаар бусдаас илүү сайн боловсрол эзэмшиж, боломжуудыг эдэлж байгаа гэж хэлж байна. Эдгээр хүүхдүүд Олимпт явах магадлал статистикийн үүднээс харвал маш бага. Хөнгөн атлетикийн олонтамирчин насаараа зүтгээд ч амжилт олохгүй байх нь бий. Гэвч тэд бэртэл гэмтлээс зайлсхийж, үндэсний багт орж чадвал шагнал нь тухайн тамирчны амьдралыг орвонгоор нь өөрчлөхөөр том. Алтан медалийн эздэд ихэвчлэн засгийн газарт өндөр албан тушаал санал болгож, шагналын мөнгө хэмээн 200 мянган ам.доллар өгдөг. Гэхдээ Олимпийн медаль хямдхан үнээр олддоггүй. Хөнгөн атлетикийн тамирчин 23 настай Гауле “Бид их жаахан байхаасаа л бэлтгэл хийсээр өдийг хүрсэн тул миний амьдралын хамгийн том золиос бол хүүхэд нас. Би телевиз үзээд би хүмүүс ямар ухаантай, ямар их мэдлэгтэй байдаг юм бэ гэж боддог. Бидэн шиг хүмүүс зөвхөн тооцоололд найддаг. Нийгэмд амиа борлуулаад явна гэдэг хэцүү” гэв.

2016 онд харанхуй цаг үеүд ч мөн байх болно. Исламийн террорист халдлагууд Европ, Африк, Ойрхи Дорнод тэргүүтэй олон газарт байнгын үзэгдэл мэт тохиолдох нь ихэслээ. Гэвч үүний зэрэгцээ ахиад 1.5 сая гаруй цагаач иргэн Европын энэ жилийг тодорхойлно. Харин энэ зуур Америкт хэвлэл мэдээлэл,



цэнхэр дэлгэцүүдийг Ерөнхийлөгчийн сонгууль эзэлнэ.

Чөлөөт зах зээлийн удирдагч болох тулаанд хэвлэл мэдээллийнхэн зөвхөн сонгуулийн кампанит ажлын хэдэн зурагт хуудас, статистик тоо үзүүлээд зогсохгүй. Хэдийгээр өдгөө хэн ерөнхийлөгч болох нь тодорхойгүй байгаа ч таамаглаж болно. Үүнийг “супер таамаглагчид” гэж нэрлэгддэг хүмүүс хамгийн бодитой гаргаж ирдэг гэдэг. Тэд засгийн газруудын тагнуулын албан дахь шинжээчдээс 30 хувиар илүү оновчтой таамаг гаргадаг. Дэлхийн тэргүүлэх таамаглагчдын нэг Канадын иргэн Тим Минто тухайлбал Америкийн Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчид тодорхой болонгуут Ерөнхийлөгч хэн болох таамага гаргана. Дараагийн том таамаг бол Риогийн медалийн тавцанд аль улс хамгийн олон медаль горилох вэ гэдэг юм. Түүний хэлж байгаагаар бол Хятад 2008 оны Олимпт медалийнхаа тоогоор тэргүүлсэн бол 2012 онд тус улс уг байр сууриа алдсан. Харин Оросын хувьд Америктай хүзүү холбон явж ирсэн ч жил жилээр хүч нь суларч байгаа. Мөн цагийн бүсийг нь харвал Америктай ойролцоо буюу зөрүү багатай учир АНУ-д давуу тал болно. Нөгөө талаас Хятадын хүн ам Америк улсынхаас дөрөв дахин их. Ингээд харахаар Хятад болон Америкийн Олимпт гаргах амжилт нэн ойрхон байх болов уу даа. Гэхдээ Америк медалийн жагсаалтаараа тэргүүлэх магадлал 60 хувиас давж буй гэдгийг хэлье.

Дэлхийн олон орон Америкийн сонгуульд анхаарлаа хандуулж байх зуур цаг агаар судлаачид дэлхий өмнө нь үзэгдэж байгаагүй тийм хүчтэй el nino нөлөөнд орно гэж таамаглаж байна. Дэлхийг аль хэдийнэ балбаад эхэлсэн эсрэг тэсрэг цаг агаар бол дөнгөж эхлэл нь. Азиас Номхон далай хүртэл уур амьсгалын өөрчлөлтийн энэхүү үзэгдлийн нөлөө хэдэн сараар ▶

► мэдрэгдэх бөгөөд **Төв Америкт ургац авах боломжгүй болж олон сая хүн ус, хүнсний гачигдалд орж мэдэх юм.** Харин хамгийн хүчтэй нөлөө амсах орон бол Африкийн Малави улс гэж үзэж байгаа бөгөөд тэр аяараа ган гачигт нэрвэгдэнэ гэж үзэж байна.

2016 онд хамгийн их анхаарал хандуулах гэж буй байгаль орчны асуудлуудын нэгийг дэлхий тэр аяараа харахан анзаараа ч үгүй байгаа. Ойролцоогоор **найман сая хуванцар хог хаягдал жил бүр манай дэлхийн далайн ус руу ордог гэх тооцоо бий.** Түүний дийлэнх нь далайн доогуурх хөдөлгөөнт урсгалыг даган хөвдөг. Дэлхий даяараа хөнөөлт нөлөөллийн талаар удахгүй ойлгож эхлэнэ. 2016 оны зун олны хараанд төдийлэн өртөөгүй нэгэн баг энэ асуудлыг залруулах оролдлого хийнэ. Нидерландын жижиг хотод өмнө нь хийгдэж байгаагүй **далай цэвэр үйл ажиллагаанд бэлдэн туршилтууд хийж байна.** Энэхүү төслийг санаачлагч нь 21 настай Баяан Слат юм. Иймэрхүү хуванцар хог хаягдлын нөлөө нь далайн амьдралд тусгалаа олж буй нь аймшигтай. Дор хаяж нэг сая далайн шувуу мөн ойролцоогоор 100.000 далайн хөхтөн амьтан жил бүр энэхүү хог хаягдлаас

ирнэ. Эцэст нь ургийн гажиг, үргүйдэл болон хавдрын эрсдлийг нэмэгдүүлнэ. Хэдийгээр Баяан аврагч шиг харагддаггүй залуу хүү ч гэсэн ямар ч улсын хариуцлага хүлээгээгүй олон улсын усны төлөө тэрбээр дээрх сорилтыг барьж аваад байна. Түүний хэгийн зорилго дэлхийн эргэн тойрноос санхүүжилт татаж, шинжлэх ухаан, инженерингийн салбарын олон удирдагчдын дэмжлэгийг аваад буй билээ. **Түүний баг хог хаягдлыг тогтоон барьж авдаг хаалтыг зохион бүтээсэн.** 2016 оны зун түүний баг Японы далайн эргийн хэсэг рүү явж бүтээлийнхээ анхны хувилбарыг далайн усанд тавина. Уг далай цэвэрлэх хаалт нь 2016 онд хоёр километр урттай байх ч 2020 онд 100 гаруй км урттай болох тооцоог хийсэн. Уг цуглуулсан хогийг дахин боловсруулах газрууд руу аваачна. Баяаны тооцооллоор **Номхон далайн хойд хэсгээрх хогийн 40 хувийг цуглуулж чадна** гэж үзэж буй. Баяан “Энэ зууны далайн цэвэрлэгээ нь технологи хэрхэн нөхцөл байдлыг сайжруулж болох тэмдэг болно гэж найдаж байна” гэв.

2016 оны эцэс гэхэд манай дэлхий дээр **найман тэрбум гар утасны холболтууд** бий болж, дэлхийн дөрвөн хүн тутмын

тохирох өмсгөлийг зүүнгүүт өөр нэгэн дижитал виртуаль ертөнцөд аваачиж, үнэхээр тэр газар байгаа мэдрэмжийг хүнд өгдөг. VR нь нь төдийлэн шинэ зүйл биш л дээ. Уг санааг 30 жилийн өмнө бодож олсон ч тухайн үедээ бүтэлгүйтсэн байдаг. Гэвч технологийн хөгжлийн олгож буй боломжоос үүдэн мэдрэгдэх байдал илүү хүчтэй, бодит байж чадаж буй. Өндөр нарийвчлалтай дэлгэц, хүчтэй процессортой гар утас ч гэсэн VR төхөөрөмж болдог болчихсон. **Энэхүү технологийг кино, сэтгүүлзүй, виртуаль дэлгүүр хэсэлт болон архитектур зэрэг олон салбарт хэрэглэж эхэлж байна.** VR төхөөрөмж технологийн мэргэжилтнүүдийн гараас хүмүүсийн өдөр тутмын хэрэглээ рүү шилжихээр зэхэж байна. 2016 онд энэ нь эмнэлгийн салбарт хүртэл хэрэглэж эхэлнэ. Лос Анжелес хотноо VR эрүүл мэндийн үйлчилгээгээр дамжуулан зожигрол өвчний нөхцөлд орсон өвчтнүүдийн нийгэмших чадварыг сайжруулахаар ажиллаж байна. 2016 онд илүү олон сэтгэлзүйчид VR-ийг ашиглан жолоо барихаас, өндрөөс айдаг гэх зэрэг эмгэгтэй хүмүүсийг эмчлэх оролдлого хийнэ. Тухайлбал, дайны бүсүүд рүү томилолтоор

яваад халагдаад ирсэн ч одоо хүртэл тухайн үеийн мэдрэмжээс салж чадахгүй, сэтгэл санааны түгшүүр мэдэрсээр байгаа **гэмтлийн дараах стресстэй хүмүүст энэхүү аргаар эмчилгээ хийж байна.**

2016 онд бидний амьдрал өмнө нь байгаагүйгээр виртуаль болж магадгүй. Гэхдээ дэлхий мөн өмнө нь байгаагүйгээрээ **илүү тэгш бус болно.** Анх удаа дэлхийн хүн амын хамгийн баян нэг хувь ба үлдсэн 99 хувийн баялгийн хувь хэмжээний зөрүү илүү том болно. Мөн 2016 оны дөрөвдүгээр сарын 23-нд дэлхийн баян ядуу бүх хүнд хүрч чадсан алдарт зохиолчийг магтан дуулна. Түүний

бүтээлүүд 100 гаруй улсад тархсан. 2016 бол **Уилльям Шекспир нас барснаас хойш 400 жил** болж буй он. Тиймээс алдарт зохиолчийн өлгий нутаг төдийгүй олон улс түүний дурсгалыг хүндэтгэх нь дамжиггүй.

Магадгүй зарим зүйлд цаг хугацаа гэж байдаггүй байж мэдэх. Гэвч 2016 онд дэлхийн хувьд тодорхой байдал гэдэг биднээс хамгийн хол, цөөхөн үзэгдэх зүйл байх болов уу. ■



үүдэн үхэж байгаагаас харвал ховордсон амьтдын амьдралыг улам ч ихээр хутганы ирэн дээр авчир буй.

“Хэрвээ бид одоо л цэвэрлэж эхлэхгүй юм бол эдгээр хог хаягдал бүүр жижиг хэсгүүдэд хуваагдаж өчүүхэн болж, цэвэрлэх боломжгүй болно” хэмээн Баян Слат хэлж байна. Эдгээр нэн жижиг хаягдлыг загас залгиад ирэхээр, бидний хүнсний хэрэглээнд далайгаас хорт химийн элементүүд тэднээс дамжиж

нэг нь ухаалаг утастай болно. Гэвч 2016 онд анхаарал илүүтэй **виртуаль бодит байдал** хэмээх нэгэн шинэ технологи руу чиглэнэ. Дэлхийн тэргүүлэх технологийн компаниуд Виртуаль бодит байдал /VR/ технологийн зах зээл дэх өөрсдийн байр суурийн төлөө хүчтэй тэмцэлдэх болно. Энэ төрлийн бүтээгдэхүүнүүд нь жилд **3.8 тэрбум ам. долларын орлого бий болгоно** гэх тооцоолол бий. Товчхондоо тус технологийг тайлбарлавал толгойдоо

Тэдний тухай

“Эргэлзэх бүртээ The Economist-ыг хүлээдэг”



Их Британийн нийслэл Лондон хотноо төвтэй The Economist нь долоо хоног тутам хэвлэгдэн гардаг сонин юм. Анх уг сонин 1843 оны есдүгээр сард үүсгэн байгуулагч Шотландын бизнесмэн, эдийн засагч Жэймс Вилсоны санаачлагаар хэвлэн нийтлэгдэж байжээ. Хэдийгээр сэтгүүлийн загвартай гардаг ч яагаад сэтгүүл биш харин сонин гэж өөрсдийгөө нэрлэдэг учир нь анализ болон сэтгэгдлүүдээ гадна долоо хоног тутамд болж буй улс төр, эдийн засгийн талаарх хамгийн чухал үйл явдлыг авч хэлэлцдэгт оршиж буй аж. Уг сонины нийтлэл долоо хоног бүрийн Пүрэв гарагт дэлхийн зургаан оронд Англи хэл дээр нэгэн зэрэг хэвлэгдэн гардаг юм. Харин хэвлэгдэн гарсны дараагаар дэлхийн хамгийн томоохон хотуудад төд удалгүй борлуулагдаж эхэлдэг.

Дэлхий даяарх уншигчид бүгд ижил агуулгыг хүлээн авдаг. Харин сурталчилгаануудын хувьд ялгаатай. Мөн булангуудын дараалал, заримдаа нүүр хуудас өөр байдаг. Эдгээрийг эс тооцбол доторх үг үсэг нь бүгд ижил. Зөвхөн Их Британийн уншигчид л хэдэн хуудас Британийн талаарх нэмэлт материалууд авдаг аж.

Нийтлэлүүд нь яагаад зохиогчийн нэргүй байдаг вэ? Хэдийгээр The Economist-г олон гар бичдэг ч бүгд хамтдаа

нэгдсэн дуу хоолой болж чаддаг. Долоо хоног тутмын уулзалтаар редакцийн бүх гишүүд оролцдог ба лидерүүдийнхээ талаар хэлэлцэж, мэтгэлцэхэд ч нээлттэй. Сэтгүүлчид нийтлэлүүд дээр хамтран ажиллах нь элбэг. Мөн зарим нийтлэлд нэлээд их засвар орох нь ч бий. Гэвч нэргүй байдаг гол шалтгаан нь хэн бичсэн гэдгээс илүүтэй юу бичсэн нь чухал гэх итгэл үнэмшилтэй холбоотой. 1938-1956 он хүртэл ерөнхий эрхлэгчээр ажилласан Жоффри Кравтэр “зохиогчийн нэргүй байх нь эрхлэгчийг эзэн биш харин өөрөөс нь хамаагүй илүү ямар нэг зүйлийн төлөө зүтгэх зарц гэдгийг нь ойлгуулж өгдөг. Үүнийг та хүсвэл өвөг дээдсээ хүндлэх үзэл гэж хэлж болох ч энэ нь сонинд оюун санааны болон зарчмын гайхмаар мөчийг бий болгодог” хэмээн тайлбарласан байдаг.

Хэн “The Economist”-ийг эзэмшдэг вэ? “Pearson” компанийн охин компани болох “Financial Times” 1928 оноос The Economist-ийн тал хувьцааг эзэмшиж болсон. Үлдсэн нь хараат бус хувьцааг эзэмшигчдэд ногдог бөгөөд тэдэн дунд тус сонины олон ажилтан багтдаг аж. Эрхлэгчийн хараат бус байдлыг итгэмжлэгдсэн Төлөөлөн удирдах зөвлөл баталгаажуулдаг. ТУЗ албан ёсоор эрхлэгчийг томилдог бөгөөд эрхлэгчийг зөвхөн тэдний зөвшөөрлөөр л ажлаас чөлөөлж болдог.

The Economist чөлөөт худалдаа болон чөлөөт зах зээлээс өөр юунд итгэдэг вэ? The Economist өөрийгөө радикалуудын нэг гэж үзэхийг эрмэлздэг. Хэт төвийн үзэл баримтлал нь үргэлж л тус сонины түүхэн байр суурь байсаар ирсэн” хэмээн Кравтерийн 1955 онд хэлсэн нь одоо ч өөрчлөгдөөгүй үнэн. The Economist өөрсдийгөө эрх мэдэл, ихэрхэл болон урьдчилан таамаглахад амархан байдлын эсрэг талд байдаг гэж үздэг. Жишээлбэл, тус сэтгүүл Рональд Рейгэн болон Маргарет Тетчер зэрэг консерватив үзэлтнүүдийг араас нь түлхэж байсан удаа бий. Мөн Вьетнамын дайнд Америкчуудыг дэмжсэн. Гэвч мөн Харолд Вильсон болон Билл Клинтон болон либерал олон шалтгааныг хөхиулж байсан: эртнээс цаазын ялыг эсэргүүцэхийн зэрэгцээ ял шийтгэлд шинэчлэл хийх, колончлолын халах талыг барьсаар ирсэн. Мөн саяхны жишээ дурьдахад ижил хүйстнүүдийн гэрлэлт болон галт зэвсгийн хяналт зэргийг дэмжсэнээс харахад уг сонины урьдчилан тааварлашгүй байдал, эрх мэдлийн эсрэг байр суурийг тодорхой харуулж буй.

The Economist нь энгийн үг хэллэг ашиглахыг илүүд үздэг бөгөөд тус сэтгүүлийн 19-р зууны хамгийн алдартай эрхлэгч Уолтер Бажуг “Харилцан ариа мэт энгийн ойлгомтой, зураглал сайтай, санахад амар бич” гэж хэлж байжээ. Энэ нь өдийг хүртэл тус сонины бичлэгийн хэв маяг болон хадгалагдан ирсэн

Уг сонин анх 1843 онд үүсгэн байгуулагдсанаас хойш өнөөг хүртэл үүсгэн байгуулагч Жэймс Вилсоны зарчмыг баримтлан ажиллаж байгаа аж. Шотландын жижиг тосгон Хавикийн малгай үйлдвэрлэгч Жэймс Вилсон чөлөөт худалдаа, интернационализмд итгэдэг мөн Засгийн газраас зах зээлийн харилцаанд аль болох бага оролцох ёстой гэдэг нэгэн байв. “The Economist”-ийг үүсгэн байгуулах сэдлийг Вилсонд төрүүлсэн дотоодын улаан буудай үйлдвэрлэгчдийн эрх ашгийг хамгаалах зорилготой “Corn Laws” буюу Улаан буудайн хууль 1846 онд хүчингүй болсон ч тус сонин өөрийн 19-р зууны сонгодог либерал үзэл санааг хаялгүйгээр цааш үргэлжлүүлж, үлдэж чадсан юм.

Улаан буудайн хууль нь улаан буудайн импортоос татвар авч хязгаарлаж байсан учир талхыг үнэтэй болгож, өлсгөлөн газар авч Их Британийн ашиггүй байдал үүсгэсэн. Вилсоны бодлоор чөлөөт худалдаа нь хүн бүрт ашигтай санагдаж байж. Тэрээр “The Economist”-ийн төлөвлөгөөнд бичихдээ: “Хэрэв бид өргөн хүрээнд бодож, өөрсдийн худалдааны харилцаагаа нийт арлууд болон ▶

▶ тивүүдэд харвал соёл иргэншлийн гэрэл гэгээ ховор боловч үүрийн гэгээ мэт эхлэл дээрээ байна. Бид чөлөөт худалдаа болон чөлөөт харилцаа дэлхий даяарх соёл иргэншил болон ёс суртахууныг өргөтгөж, тэр бүдэгхэн гэрлийг тод болгоно гэж итгэж байна. Тиймээ тэр ч утгаараа боолчлолыг үгүй болгох юм” гэжээ. Тиймээс Вилсоны санаа бодол ёс суртахуунтай, соён гэгээрүүлсэн боловч дүрмийг баримталсан биш байлаа. Тэрээр “Өөрсдийн сэтгэл зүрхэнд хөтлөгдөхгүйн тулд л үүнээс өмнө бодол гэж байдаг” гэж хэлж байсан удаатай. Түүний Адам Смитэд итгэдэг гол шалтгаан нь үл үзэгдэх гараар дамжин зах зээл ашиг хайж буй хувь хүмүүст өгөөжөө өгдөг гэж боддогт оршиж (тэрээр өөрөө тэдний нэг байсан) байв. Нийгэм ч тэр адил. Тэрээр өөрөө үйлдвэрлэгч байсан тул ялангуяа бизнесийнхэнд нөлөөлөхийг хүсэж байсан аж. Тэр ч утгаараа тэрээр түүний цаасан дээр буулгасан бүх дүгнэлт болон саналыг баримтаар шалгахыг шаарддаг байсан юм. Ийм ч учраас сонинг The Economist гэж нэрлэсэн. Мөн тус сэтгүүл том, том зургуудаас илүү оновчтой өнгөлөг зураг ялангуяа хошин зураг, агуулгын нэгдлийг голчилдог.

Оюун ухааны хувьд Вилсон The Economist-ийн хамгийн шилдэг эрхлэгч байсангүй. Харин энэ цол хэргэм түүний хүргэн, сонины гурав дахь эрхлэгчээр 1861-1877 он хүртэл ажилсан Уолтер Бэжетэд оноогдох ёстой болов уу. Бэжет нь банкир байсан ч тэрбээр улс төрийн өгүүллүүд ялангуяа Их Британийн Үндсэн хуулийн талаар нийтлэлээрээ илүү тод дурсагддаг. Тэрээр эзэн хаан нь ард иргэдийн сэтгэл хөдлөл, хүндэтгэл бишрэлийг хадгалах үүрэгтэй “нэр” төдий Үндсэн хуулийн хэсгүүдийн л тэргүүн хэмээж харин ерөнхий сайдыг “үр дүнтэй” ажлуудыг даргалдаг жинхэнэ тэргүүн гэжээ. Энэ ялгааг өнөөдөр ч гэсэн үргэлж дурьддаг.

Тус сонины хамрах хүрээг улс төр лүү тэлж өргөжүүлсэн хүн бол Бэжет байсан аж. The Economist АНУ-ыг хэзээд сонирхож ирсэн бол энэхүү сонирхлыг маш ихээр бэхжүүлсэн хүн бол мөн л тэр байв. “The Economist-ийн зорилго нь хамрах хүрээнийхээ сэдвүүдэд гэрэл тусгах юм” хэмээн үздэг байсан Бэжетийн эрхлэгч хийх хугацаанд тус сонины нөлөө нэмэгдсэн юм. Британийн Гадаад хэрэг хариуцсан нарийн бичиг Лорд Гранвил эргэлзэх бүртээ The Economist-ийн дараагийн дугаар уг сэдвээр юу гэх бол гэж хүлээдэг байсан гэжээ. Бэжетийг сүүлд биширдэг болсон хүмүүсийн нэг бол 1913-аас 1921 он хүртэл АНУ-ын

ерөнхийлөгчөөр ажилласан Вудро Вилсон байсан юм.

Гэвч тус сонин дахин өөр нэг гайхалтай эрхлэгчтэй болохын тулд бараг хагас зуун жил хүлээх хэрэгтэй байжээ. Тэр хүн нь 1922 онд эрхлэгч болсон Уолтер Лайтон байсан аж. The Economist-ийн түүхч Рут Дадли Эдвардс хэлэхдээ хэдийгээр Лайтоны шүүмжлэгчид сонинг бага зэрэг хөлдүү болгосон гэдэг байсан ч түүний ачаар тус сонинг гадаадын эрх мэдэлтнүүд төдийгүй энгийн нэгэн айл ч өргөнөөр уншихаар болгосон гэдэг. Гэвч Лайтоныг залгамжлагч Жоффри Кротерт ирсэн хэмжээний шүүмжлэлтэй харьцуулбал дээрх шүүмжлэл үнэндээ биш байв. Тэрээр магадгүй Бэжетээс хойшхи The Economist-ийн хамгийн аугаа эрхлэгч байсан. Түүний оруулсан хувь нэмэр гэвэл гадаад харилцаа, ялангуяа АНУ болон бизнестэй холбоотой хамрах хүрээг сайжруулахад байжээ. Сонины нэр хүнд энэ үед өмнө хэзээ ч байгаагүйгээрээ өндөрт гарсан юм.

The Economist бичих сэдэв болон хэвлэлтийн хэмжээний хувьд анхнаасаа л ирээдүйгээ харж өргөн хүрээнд хилийн чанадыг харж байсан. 1840 онд хүртэл уг сонин Европ болон АНУ-д уншигчидтай байсан. 1938 он гэхэд борлуулалтын талыг гадаадад хийж байсан ч дэлхийн дайны улмаас удаан үргэлжлээгүй юм. 1941 оны арванхоёрдугаар сард Япон Сувдан Эрэгт дөнгөж халдсаны дараагаар Кравтер дан ганц АНУ-ын харилцаанд зориулсан булан эхлүүлсэн нь шинэлэг байлаа. “Америкийн судалгаа” (1997 оноос АНУ хэмээн өөрчилсөн) буланг Кравтер Америкчуудад чиглэсэн бус харин Британийн уншигчид өөрсдийн шинэ холбоотныхоо талаар илүүг мэдэх хэрэгтэй гэдэгт итгэж байсны улмаас бий болгожээ. Энэ нь аяндаа АНУ-д дагагчдийг бий болгож 1970 оноос эхлэн АНУ дахь эргэлтийн ахиу өсөлтийн суурь болсон юм.

Үүсгэн байгуулагдсанаас хойш дийлэнх хугацаанд The Economist бага дүнтэй хэвлэлтийн тоондоо сэтгэл хангалуун

Төрөл:	7 хоног тутмын мэдээний сэтгүүл
Хэлбэр:	Сэтгүүл
Эзэмшигч:	The Economist групп
Үүсгэн байгуулагч:	Жеймс Уилсон
Эрхлэгч:	Занни Минтон Беддос
Үүсгэн байгуулагдсан он:	1843 оны 9-р сар
Улс төрийн баримжаа:	Сонгодог либерализм, төвийг баримталдаг
Төв байр:	Их Британи, Лондон хор Уэстминстер
Эргэлт:	4,594,866 (цаасан хэвлэл) 2,738,348 (дигитал)
Цахим хуудас:	www.economist.com

байсан. Бэжет эрхлэгч ажлаа өгөхөд эргэлт 3,700 байсан бол 1920 он гэхэд 6,000 болж өсчээ. Дэлхийн хоёрдугаар дайны дараагаар 18,000-аас хурдтай өсч, Кравтерийг ажлаа хүлээлгэн өгөхөд дөнгөж 55,000 болж байсан бөгөөд 1970 он хүртэл 100,000 хүрээгүй юм. Өнөөдөр уг сонингийн хэвлэлтийн тоо 1.4 саяас илүү давсан бөгөөд үүний тавны дөрвийг Их Британиас гаднах эргэлт эзэлж буй юм. АНУ дахь эргэлт нийт эргэлтийн бараг тэн хагасыг бүрдүүлдэг аж.

1990-ээд онд тус сэтгүүлийн эрхлэгчийн албыг хашиж байсан одоо Английн төв банкны гүйцэтгэх даргын албыг хашиж буй Руперт Пэннан-Рэа “Манай сонин Баасан гаригийн сонин гэж хэлж болно, дундаас дээш орлоготой, дундаж оюун санаанаас дээгүүр мэдлэгтэй боловч байнга юм унших завгүй хүмүүс манай сонинг уншиж өөрсдийн бодлыг манай сонины нийтлэлтэй харьцуулж оюунаа уралдуулдаг юм. Бид дэлхийн тухай дэлхийд ярьж, үзэл бодол, санал дүгнэлтээр мэргэжилтнүүдийг ятгаж, цаашлаад сонирхогчдод хүрэхийг зорьдог” гэж хэлж байв. Ийм уншигчидтай, ийм зорилттой учир The Economist-д Их Британид эргэлтээ нэмэхэд маш хүнд байсан. 1960-70 аад оны үед Их Британийн өдөр тутмын сонинууд долоо хоног тутмын хэвлэлүүдийн онцлог давуу тал байсан тайлбарласан, баталж нотолсон, дүгнэлт, судалгаатай нийтлэлүүдийг ихээр оруулах болсон нь долоо хоног тутмынханд хүндээр туссан юм. The Economist өөрийн интернационализм болон гадаад борлуулалт дээр тулгуурлаж үүнийг давж гарч чадсан бөгөөд амжилт олсон.

Бизнес болон эдийн засгийн асуудлыг хамарсан нь тус сонинд асар ихээр тус болсон юм. Вилсон уйтгартай ч гэсэн статистик хүртэл хамгийн гүн бөгөөд сэтгэл хөдөлгөм сонирхлыг төрүүлж чадна хэмээн итгэж байжээ. Өнөөг хүртэл Баруун германы канцлер асан Хельмут Шмидт зэрэг уншигчид үүнтэй санал нийлдэг. Гэвч ихэнх уншигч The Economist-ийг ганц зорилгоор авдаггүй бөгөөд сүүлийн жилүүдэд Европ, Ази, Латин Америк, олон улсын асуудлууд болон шинжлэх ухаан болон технологид зориулсан буланг нэмсэн. Мөн ном, урлаг, санхүүгийн зах зээл гэх мэтээр мөн булангуудаа тэлээд байна.

The Economist Newspaper Limited нь The Economist Group-ын охин компани бөгөөд тус групп жил бүр хэвлэн гаргадаг The “World in- Дэлхий” брэнд, Intelligent Life, European Voice болон Roll Call зэрэг сард хоёр удаа хэвлэгдэн гардаг сэтгүүлүүдийг эзэмшдэг юм. ■

Форум

Өнгөө өөрчлөх хотын худалдан авалт

Г.ОРХОН

Өдрөөс өдөрт өнгө засч “шилэн” болж буй Улаанбаатар хот өнгөрсөн онд эдийн засгийн хувьд хямраагүй аж. Хотын захиргааныхан 2015 оны орлогын төлөвлөгөөг 12.5 хувиар давуулан биелүүлсэн нь үүнийг нотолж байгаа юм. Гэсэн ч тэд өнөөдөр хувийн хэвшлийнхэнд өртэй сууна.

Чуулганы нээлтийн үеэр нийслэл түншлэгчдийнхээ эрх ашгийг үргэлж хамгаална гэдгийг хотын дарга дуулгасан. Учир нь хотын худалдан авалтад төр болон хувийн хэвшил эн тэнцүү эрхтэй байх ёстой. Гэвч өнөөдөр төр хувийн хэвшлийнхээр ажил хийлгэснийхээ дараа хөрөнгийн асуудлаа шийдвэрлэхгүй



Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлчихвэл олон улсын зах зээлд ногоон гэрлээр гарах боломж бий

Нийслэлийн энэ оны худалдан авалт эхлэхээс өмнө энэ жил хийх худалдан авалтаа хувийн хэвшлийнхэнд зарлалаа. Тодруулбал, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Худалдааны танхимтай хамтран “Улаанбаатар худалдан авалт-2016” бизнес чуулганыг өнгөрсөн сарын 20-нд зохион байгуулав. Тэд бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчдад энэ онд хэрэгжүүлэх бүтээн байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөр, тендерүүдээ танилцуулж, эдгээрт хувийн хэвшлийнхэн хэрхэн оролцох талаар нар шингэтэл ярилцсан юм.

уудаг тал бий. Үүнээс шалтгаалан хувийн хэвшлийнхэн хохирол хүлээдэг байдал газар авчээ.

Тухайлбал, хотод ажил хийж өгсөн аж ахуйн нэгжүүдийн он дамжин хийсэн, төлбөрийг нь хотоос авах ёстой 90 орчим тэрбум төгрөгийн ажил байгаа аж. Үүнээс хүлээлгэн өгсөн нь 27 тэрбум төгрөгийнх. Гэвч Нийслэлийн орлого болох 149 тэрбум төгрөг Төрийн нэгдсэн сан руу орчихсон тул улсын ажил хийсэн компаниуд өнөөдөр мөнгөө хүлээн сууна. Уг нь Нийслэлд дээрх төлбөрийг төлөх бололцоо бий нь дээрх орлогоос харагдаж байгаа юм. Тэд Сангийн яамнаас хотын

орлогыг авахыг шаардаж байгаа бөгөөд компаниудын 90 орчим тэрбум төгрөгийн өрийг бүрэн барагдуулна гэдгийг Э.Бат-Үүл амлаадхав.

Нийслэлийн хувьд ийм байдал огт гаргаж болохгүйг үүрэг болгосон тул бизнесийнхэн айх хэрэггүйг тэрбээр нэмж хэлсэн. Нийслэлийн худалдан авалт хийх гэрээг хотын Худалдааны танхимын дэргэдэх Арбитрт бүртгэж байгаа бөгөөд хэрэв гомдол гарвал аж ахуйн нэгжүүд тус арбитрт хандах боломжтой болжээ. Түүнчлэн тэд олон улсын арбитрт ч гомдол гаргаж, асуудлаа шийдүүлэх эрх бий. Харин нийслэлийн худалдан авалттай холбоотой хүнд суртал, санхүүжилтийн шилжүүлэлтээс шалтгаалан аж ахуйн нэгжүүд алдагдал хүлэвэл тэр хариуцлагыг хот хүлээх аж.

Хотын хөгжил, эдийн засгийн идэвхжилтэд хувийн хэвшлийн санаачилга, хөрөнгө оруулалт чухал. Тэр дундаа, ногоон болохыг зорьж, хөгжлийг эрэлхийлж яваа Улаанбаатар хотод хувийн хэвшлийнхний “ногоон” санаачилга бүхий төсөл чухал байгаа аж. Үүнийг тэд дэмжинэ гэдгээ чуулганы үеэр дуулгасан. Тодруулбал, хувийн хэвшлийнхний санал болгож буй төсөлд орчин үеийн дэвшилтэт байхаас гадна байгаль орчинд ээлтэй, эрчим хүчний бага зарцуулалттай “ногоон” технологи байх зарчмыг тавьж байгаа аж.

Нийслэл энэ онд 427 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийнэ. Үүнээс хотын төсвөөр 203.5 тэрбум, Хөгжлийн банкнаас нийслэлд хэрэгжүүлэх төслүүдэд 120 тэрбум төгрөг, орон нутаг болон улсын төсвөөр 103.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийх аж. Одоогийн байдлаар харьяа байгууллага, дүүрэг, иргэдээс нийт 847 тэрбум төгрөгийн бүтээн байгуулалтын ажил хийх 530 санал ирүүлээд буй. Хот эхний ээлжинд 203.5 тэрбум төгрөгийн 80 орчим төслийг хэрэгжүүлэхээр болж.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 203.5 тэрбум төгрөгийн ажлуудыг гүйцэтгэнэ. Үүнд:

Хот байгуулалтын салбар	59.3 тэрбум төгрөг
Авто замын салбар	55.1 тэрбум төгрөг
Нийгмийн салбар	31.5 тэрбум төгрөг

Үүнээс боловсролын салбарт 53 цэцэрлэг, 26 сургууль, 42 бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилга барьж, 10 цэцэрлэг, 12 сургуулийн их засварын ▶

▶ ажлыг 24.8 тэрбум төгрөгөөр хийнэ. Харин эрүүл мэндийн салбарт 2.1 тэрбум төгрөгөөр Баянзүрх, Баянгол дүүрэгт 100 ортой эрүүл мэндийн төв, Чингэлтэй, Баянгол дүүрэгт 200 ортой хүүхдийн эмнэлэг, Чингэлтэй дүүрэгт Түргэн тусламжийн төвийн салбар пункт, Баянзүрх дүүрэгт 100 ортой амаржих газар барьж, түргэн туламжийн 10 автомашин худалдаж авахаар төлөвлөжээ.

Хөрөнгө оруулалт, салбараар, тэрбум төгрөг

Инженерийн дэд бүтэц	12.9
Нийтийн тээврийн салбар	11.3
Хот тохижилтын салбарт	7.5
Төр захиргааны салбар	6.1
Бусад	19.1

Хот эдгээр бүтээн байгуулалтын ажлаа хувийн хэвшилтэй хамтран хийнэ. Нийслэлийн Засаг даргын Санхүү, эдийн засгийн асуудал хариуцсан орлогч Н.Батаа энэ жилийн хувьд олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээл, тусламж ч багагүй бийг дуулгасан. Тухайлбал, энэ онд Монгол Улсын түүхэнд анх удаа Засгийн газрын баталгаагүйгээр Улаанбаатар хотод 24.8 сая еврогийн хөнгөлөлттэй зээлийг Европын хөрөнгө оруулалтын банкнаас олгохоор болжээ. Энэ хүрээнд Эмээлт-Аргалантын аж үйлдвэрийн шинэ парк, мөн 30 мянган шоо метр бохир ус цэвэрлэх хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн ажлыг

хийх юм байна. Мөн дараагийн ээлжинд хог боловсруулах төслийг ч эхлүүлэхээр болжээ.

Нийслэлийн зүгээс энэ оны хөрөнгө оруулалтыг нийгэм, зам, дэд бүтэц, байгаль орчин гээд шаардлагатай салбаруудад чиглүүлнэ. Ер нь цаашид хотын захиргааныхан төсвөөс мөнгө гаргаж, байшин барилга барих бус хувийн хэвшлээ дэмжиж ажиллахыг зорьж байгаа аж. Тодруулбал, хувийн хэвшлийнхэн өөрсдийн хөрөнгө оруулалтаар хотын дэд төвүүдийг барьчихвал тухайн барилга, байгууламжийг Нийслэл зуун жилээр түрээслэх боломжтойг хотын захирагч хэлсэн. Товчхондоо энэ онд хотын худалдан авалт илүү тунгалаг болж, “ногоон” санаачлагаар өнгө сэлбэх нь. Мөн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар сургууль, цэцэрлэг, ногоон байгууламж барих зэргийг Нийслэл бүхий л талаар дэмжих аж. Өөрөөр хэлбэл, тухайн барьсан сургуулийг хэн нэгэн хувь хүний нэрэмжит болгох, газар олголтыг шийдэх зэргээр хамтран ажиллах боломжтой гэж үзжээ.

Улаанбаатар хотын худалдааны танхим байгуулагдснаас хойш аж ахуйн нэгжүүд нийслэлтэй хамтран ажиллахад харьцангуй хялбар, хүнд суртал багатай болсныг хувийн хэвшлийнхэн дуулгасан. Гэхдээ дунд шатанд гардаг хүндрэл их хэвээр байгааг тэд дахин сануулав. Энэ талаар Нийслэлийн Засаг даргын Хот байгуулалт, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан орлогч С.Очирбат

“Нийслэлийн зүгээс дунд шатанд гардаг хүндрэлийг арилгах талаар бүхий л хүчээ дайчлан ажиллаж байна. Тухайлбал, өнгөрсөн хугацаанд газар олгоход гардаг байсан хүндрэлүүдийг бүрэн шийдэж, цахим газар олголтыг эхлүүлсэн. Мөн “Дунжингарав” худалдааны төвд “Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийг байгуулсан. Тус төвийн нээлтийн өдөр л гэхэд нэг иргэн найман нэрийн барааны дэлгүүрийн зөвшөөрөл авч, 1000 төгрөгийн үйлчилгээний хураамж төлөөд л асуудлаа бүрэн шийдүүлсэн. Үйлчилгээ авсан иргэд “Үнэхээр ингээд л болчихож байгаа юм уу” гээд итгэж ядах байдалтай байсан. Цаашид ийм үйлчилгээг нэвтрүүлэх нь Нийслэлийн зорилт болно” гэв.

Чуулганд өнгөрсөн жил 800 орчим хүн оролцож байсан бол энэ удаад даруй 200 гаруй хүнээр өргөжив. Ноднин жил энэ чуулганыг анх удаа зохион байгуулсан ч худалдан авалт хийх компаниуд тодорхой болж, тендер зарлагдсаны дараа болсон учраас төдийлэн зорилгодоо хүрч чадаагүй гэдэг. Харин энэ удаа нийслэлийн хөрөнгө оруулалтыг чухам аль салбарт, хэрхэн үр өгөөжтэй зарцуулах вэ гэдгийг чуулганаар тодорхой болгохыг зорив. Ингэж төр, хөрөнгө оруулалт, худалдан авалтаа ил зарладаг болсноор төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа дээшилнэ гэж үзэж буй. Гол нь төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа сайжирснаар зөвхөн дотоодын зах зээл бус, олон улсад өрсөлдөхүйц үр дүнтэй төсөл, хөтөлбөр боловсруулах орчин бүрдэнэ хэмээн Нийслэлийн Засаг дарга Э.Бат-Үүл энэ үеэр онцолсон. Тэрбээр “2030 он хүртэл Улаанбаатар хотыг хөгжүүлэх төлөвлөгөөгөөр 18-20 тэрбум ам.доллар шаардлагатай. Энэ хөрөнгийг хувийн хэвшилтэй хамтрахгүй бол нийслэл дангаараа бүрдүүлэх боломжгүй. Нэгдүгээрт, төр хувийн хэвшил хамтрахын ач холбогдол үүнд оршино. Хоёрдугаарт, төр, хувийн хэвшил хамтраад олон улсын зах зээл дээр гаргах боломж байна. Учир нь 100 тэрбум ам.долларын болзолтой ногоон технологи бий болгох төслийг олон улсын дунд зарладаг. Олон улсын томоохон байгууллагын зүгээс энэ төслийг боловсруулахад хамгийн боломжтой бүсийн нэгээр Монгол Улсыг нэрлэдэг. Гагцхүү Монгол Улс хувийн хэвшилтэйгээ хамтын ажиллагаа дутмаг байдгаас шалгарч чаддаггүй” гэв. Ер нь манай улс төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлчихвэл олон улсын зах зээлд ногоон гэрлээр гарах боломж бийг албаныхан онцолж байлаа. ■

Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хийгдэх худалдан авалтууд , 2016

95119,7

- Хот төлөвлөлт, барилгажуулалт, шинээр дэд бүтэц бий болгох

10168,3

- Нийслэлийн удирдлагыг хэрэгжүүлэх

51092,2

- Үерийн хамгаалалтыг зохион байгуулах

87592,9

- Шинээр авто зам, гүүр барих, өргөтгөх, шинэчлэх, засвар арчлалт хийх

37395,1

- Нийслэлийн өмчийн барилга байгууламжийн их засвар, шинээр өмч бий болгох хөрөнгө оруулалт

2917,6

- Ус хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж бий болгох

11349,5

- Нийтийн тээврийн үйлчилгээ

11124,7

- Том хэмжээний тохижилт

23834,2

- Нийгмийн асрамж халамжийн үйлчилгээ үзүүлэх, зохион байгуулах

3707,2

- Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээ

1000

- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх

7219,2

- Өндөр хүчдэлийн болон цахилгаан шугам, дэд өртөөний ашиглалт, хэвийн үйл ажиллагааг хангах

Сэтгүүл зүй

Хэвлэлийн зөвлөл бол ардчиллын мөн чанарын илэрхийлэл юм

И.ОТГОНЖАРГАЛ

Монголд Хэвлэл мэдээллийн зөвлөл байгуулагдаад нэг жил болох хугацаанд гаднаас нэг бус сургагч багш авчирж, Зөвлөлийн гишүүдэдээ сургалт зохион байгуулаад буй юм. Тэдний нэг нь Босни Херцеговины Хэвлэл мэдээллийн зөвлөлийн дарга, олон улсын сургагч багш Лилиана Зуравос манайд өнгөрсөн оны арваннэг, арванхоёрдугаар сард ирж хэвлэл мэдээллийн хэрэгслийн өөрийн зохицуулалтын хуралд оролцож, сургалт хийсэн. Энэ үеэр түүнтэй Монголд хэвлэлийн зөвлөлийг хэрхэн зөв төлөвшүүлж, хөгжүүлж авч явах талаар ярилцлаа. Тэрбээр хэвлэл мэдээллийн байгууллагын өөрийн зохицуулалтын талаар арвин туршлага, мэдлэгтэйгээс гадна үүнийг дэлхийн олон оронд хөгжүүлэхийн төлөө хүч оюунаа дайчилж яваа юм билээ.

-Монголд хэвлэлийн зөвлөл байгуулагдаад, танаас хоёр дахь удаагийн сургалтаа авлаа. Та энэ талаар ямар сэтгэгдэлтэй байна вэ?

-Энэ бол миний хувьд нэр төрийн хэрэг. Би Монголд дөрөв дэх удаагаа ирж байна. Анх гурван жилийн өмнө ирэхэд хэвлэл мэдээллийн зөвлөл байгуулах тухай яриа явж байсан. Одоо байгуулчихсан, үйл ажиллагааг нь жигдрүүлэх гээд ажиллаж байгаа нь том амжилт юм.

-Анх таныг гурван жилийн өмнө ирэхэд энэ талаар ямар яриа байсан бэ?

-Фредрих Эбертийн сан, Монголын хэвлэлийн хүрээлэн хамтран зохион байгуулсан үйл ажиллагаанд ирж байсан. Хэвлэл мэдээллийн эзэд, сэтгүүлчид салбарын төлөөлөгчид хамтарч хэвлэл мэдээллийн салбарт өөрийн зохицуулалт гэдэг зүйлийг хэрхэн бүрдүүлэх вэ, бүрдүүлэх хэрэгцээ шаардага байгаа тухай хамгийн анх удаа цуглаж ярилцаж байсан. Тухайн үед гурван өдрийн үйл ажиллагаа болсон. Хоёр өдөр нь хэвлэл мэдээллийн эзэд болон байгууллагад хандсан хөтөлбөр нэг өдөр сэтгүүлчдэд зориулсан арга хэмжээ нийт 50 гаруй



хүнийг хамран зохион байгуулсан. Өнөөдөр энэ ажлын үр дүн гарчихсан байхыг харах таатай байна.

Хоёр дахь удаагаа Монголд ирэхэд бас арай өөр болчихсон байсан. Мэргэжлийн холбоод болон хэвлэлийн зөвлөлийн клубын үйл ажиллагаа идэвхжсэн байсан. Хэвлэл мэдээллийн томоохон байгууллагын төлөөлүүд Хэвлэл мэдээллийн зөвлөл гэдэг байгууллага Монголд байгуулагдах юм байна гэдгийг хүлээн зөвшөөрчихсөн үе байсан. Энэ үйл явдлаас хэдхэн сарын дараа Хэвлэл мэдээллийн зөвлөл байгуулагдсан байсан.

Гурав дахь удаагаа 2015 оны арваннэгдүгээр сард ирсэн. Ингэж ирэхдээ Хэвлэл мэдээллийн зөвлөлийн Удирдах зөвлөлийн гишүүдэд сургалт хийж, тус зөвлөлийн хоёр Ёс зүйн хорооныхонтой уулзаж, өргөдөл гомдол хэлэлцэн шийдвэрлэх үйл явцтай танилцсан. Мөн энэ үеэр хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын талаар хамгийн анхны нээлттэй хэлэлцүүлгийг хийсэн.

-Монголын хэвлэл мэдээллийн зөвлөл гэдэг байгууллагын төлөвшил, ирээдүйг та хэрхэн харж байна вэ?

-Монголын хэвлэл мэдээллийн зөвлөл зөв зам дээрээ явж байна. Тус зөвлөлийн удирдлагуудын хувьд салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн нэлээд сайн баг бүрджээ гэж би ажигласан. Мөн салбарын гишүүдийн зүгээс дэмжлэг байна гэж үзэж байна. Мэдээж цаашаа хэвлэлийн өөрийн зохицуулалтын талаарх мэдээллийг түгээж байр сууриа эзэлж хөгжүүлэхийн тулд асар их ажил хийнэ. Монголын хэвлэлийн зөвлөлийг бүх ажлыг хийж, тулгарах сорилт бэрхшээлийг даван туулж чадна гэдэгт би итгэлтэй байна. Яагаад гэвэл хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт гэдэг зүйл нэг талыг барьсан биш, мэргэжлийн сэтгүүлчид, хэвлэлийн байгууллагын эзэд

болон олон нийтийн эрх ашгийг тэгш хамарсан зүйл байдгаараа онцлогтой. Өөрөөр хэлбэл, зөвхөн мэргэжлийнхнийг биш хэрэглэгчдийг давхар хамгаална гэсэн үг. Хэвлэлийн эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөөх байгууллага юм. Зөвлөлийн зүгээс салбарынхнаасаа хариуцлагатай бөгөөд мэргэжлийн бүтээгдэхүүнийг шаарддаг. Нөгөө талаас энэ байгууллага олон нийтийн буюу иргэдийн эрх ашгийг хамгаална.

-Хэвлэлийн зөвлөл зөвхөн салбарынхныгаа биш иргэд, олон нийтийн эрх ашгийг хамгаална гэж та ярилаа. Энэ талаар тодруулж хэлэхгүй юү?

-Юунаас хамгаалаад байгаа вэ гэхээр хариуцлагагүй, зүй бус худал мэдээллээс олон нийтийг хамгаалах байгууллага. Энэ ч утгаараа иргэд худал хуурмаг, сенсааци үүсгэсэн, хөөстэй зүй бус, ёс суртахуунгүй мэдээллүүд гарсан тохиолдолд хэнд хандахаа мэддэг, асуудлыг шийдүүлдэг газартай болж байна гэсэн үг. Энэ бол маш том зүйл.

Тэгэхээр Хэвлэлийн зөвлөл хэвлэл мэдээллийн байгууллага болон түүний ▶

▶ эцсийн хэрэглэгчид болох уншигчдыг хооронд нь эвлэрүүлэн зуучлах гүүрийн үүрэг гүйцэтгэдэг. Нэг зүйлийг сайтар анхаарах хэрэгтэй. Хэвлэлийн зөвлөл иргэдээс гомдол хүлээж авснаараа сэтгүүлчдийн эсрэг тэднийг хяхаж хавчих үйл ажиллагаа явуулах зорилготой биш. Харин ч эсрэгээрээ гомдол хүлээж авч хүмүүс тэр мэргэжлийн байгууллагын бүтээгдэхүүнийг уншиж танилцаж байдаг. Хоёрдугаарт, зөв мэргэжлийн мэдээллийг өгөхийг шаардаж байгаа нэг арга зам болж байна.

-Хэвлэлийн зөвлөлтэй болсноороо сэтгүүлчид, хэвлэлийнхэнд ямар давуу тал үүсэх вэ. Манай монголчуудад шүүх засаглалыг илүүд үзэх хандлага байдаг л даа.

-Хэвлэлийн салбарын өөрийн зохицуулалт гэдэг аливаа асуудлыг салбарынхаа хэмжээнд аль болох эвлэрч хоорондоо зохицож шийдэхийг хэлж байна. Аливаа сэтгүүлч гаргасан алдаа дутагдлынхаа төлөө заавал өөр газар дуудагдах биш, харин дотооддоо шийдээд уучлал хүсэх, залруулга гаргах, дахин мэдээллэх гэх мэтээр аль боломжоороо хялбар аргаар шийдчих боломжийг л гаргаж өгч байгаа юм. Ингэснээрээ сэтгүүлчид маань илүү мэргэжлийн, төлөвшсөн байдлаар асуудалд хандаж хариуцлага хүлээх боломжтой болж байгаа юм. Зарим нь би алдаа гаргаснаа хүлээн зөвшөөрчихвөл намайг мэргэжлийн биш муу гээд ойлгочих болов уу ч гэж бодож болно. Энэ бол тийм биш. Сэтгүүлч ч гэсэн хүн. Ямар ч хүн ажлаа хийх явцдаа алдаа гаргадаг. Гаргасан алдаагаа ухаарч ойлгох, залруулах гэдэг бол зүгээр жам ёсны л асуудал. Гол нь алдаагаа олон нийтийн эрх ашгийн төлөө л хүлээн зөвшөөрч залруулах учиртай.

Монголын хэвлэлийн зөвлөл ёс зүйн зарчмаа маш сайн боловсруулж гаргаж чадсан байна. Мэргэжлийн сэтгүүлчид энэ ёс зүйн зарчмыг заавал дагаж мөрдөх ёстой. Яагаад гэвэл мэргэжлийн ёс зүйн код гэдэг эргээд сэтгүүлчийг л хамгаалах зорилготой байдаг. Хэрвээ сэтгүүлч хүн хууль дүрэм ёс зүйгээ мөрдөөд л бүтээгдэхүүн гаргаж чадах юм бол хэн ч тэр хүнийг өөрийнх нь хийгээгүй зүйлийн төлөө гүтгэх, хэрэгт хийх, буруутгах үндэслэл үүсэхгүй. Манай Боснид ч гэсэн энэ ёс зүйн код ажил хийхэд чөдөр тушаа болж байна гэж ярьдаг. Гэтэл тийм биш. Ёс зүйн код харин ч сэтгүүлчийг ямар нэгэн алдаа дутагдал гаргаж, хэрэг төвөгт холбогдохоос хамгаалж байгаа юм.

Хэвлэлийн зөвлөл, шүүхийн бай-

гууллагад хандах хоёрын ялгааны тухай та их зөв асуулт асуулаа. Хэвлэлийн зөвлөлийн эвлэрүүлэн зуучлах үйлчилгээг шүүх засаглалтай харьцуулахад харьцангуй зөөлөн байдаг. Нөгөө талаас хэвлэлийн зөвлөл мэргэжлийн сэтгүүл зүй хийгээд ёс зүйг хөгжүүлэх гээд маш чухал үүргийг гүйцэтгэж байна. Энд хамгийн чухал нь ёс зүйн код байгаа.

-Буруугаа хүлээн зөвшөөрч залруулга гаргаснаараа ч юм уу, эсвэл гомдолд зөөлөн хариу үйлдэл үзүүлснээр асуудал шийдэгдчихгүй. Шийдэгдлээ гэж үзэхэд нэг л дутуу санагдаад байгаа мэт ойлголт хүмүүст төрөхийг үгүйсгэхгүй. Энэ нь магадгүй манай өмнө байсан социалист нийгэмтэй холбоотой байж ч болох. Заавал хэн нэгнийг шийтгүүлж байж санаа нь амардаг. Тэгэхээр Хэвлэлийн зөвлөл иргэдийн итгэл үнэмшлийг хэрхэн төрүүлэх вэ?

-Ямар ч улсад анх хэвлэлийн зөвлөл байгуулагдах эхэн үед ийм зүйл ажиглагддаг. Ялунгуяа социалист дэглэмээс ардчилал руу дөнгөж шилжиж орсон орнуудын хувьд энэ бол энгийн үзэгдэл. Ийм орнуудад сэтгүүлчид нэгэнт л надад шийтгэл байхгүй юм бол ямар нэмэр байгаа, яагаад заавал би ийм стандарт хэм хэмжээг дагах ёстой юм гэж боддог. Энэ нийгэм бол арай өөр. Бид мэргэжлийн байх ёстой учраас л мэргэжлийн ёс зүйг дагах учиртай гэсэн сэтгэлгээ суух ёстой.

Надад ч ийм асуулт ирдэг. Харин би тэднээс “Чамайг өглөө ажилдаа ирэхэд редактор чинь за өнөөдөр ажилдаа мэргэжлийн байна шүү гээд гурав алгадаад, хэрвээ мэргэжлийн байж чадахгүй бол орой дахиад гурав алгадна шүү гэсэн юм яагаад заавал хүсээд байгаа юм бэ. Эсвэл тийм байлгамаар байгаа юм уу” гэж асуудаг. Заавал яагаад өшиглүүлж байж ажиллах ёстой гэж. Мэргэжлийн байгаагүйн төлөө шийтгэлтэй орчин байвал юу болох вэ. Тэгэхээр гэм шийтгэл гэхээсээ илүү бидний мэргэжлийн бус үйлдэлийн үр дагавраас болж хүмүүст ямар хэмжээний хохирол учирч болох вэ гэдгийг урьдчилж харж байх хэрэгтэй. Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудын эрхэлж буй ажил хүнд итгэл үнэмшил төрүүлэх маш хүчтэй зэвсэг учраас хариуцлагатай хандаж, үнэн бодит мэдээллийг өгөх ёстой. Тийм ч учраас сэтгүүл зүй гэдэг зүгээрч нэг мэргэжил биш илгээлт юм. Тэр нь юуны төлөө илгээлт вэ гэхээр үнэний төлөөх. Бидний туйлын зорилго бол

ямагт олон нийтийн эрх ашиг сонирхлын талд зогсож, түүнд үйлчлэх ёстой. Сэтгүүлчид мөнгөтэй хүн, нам эвсэл, улс төр, групп, компанийн гар хөл болох ёсгүй. Тэр ашиг сонирхолд үйлчилдэг маркетингийн зориулалтын хуудасууд, тусгай цагууд хуваарилагдчихсан байдаг. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөгүйгээр ардчиллыг бий болгох болмжгүй, мөн ардчилал хариуцлагатай, бие даасан хэвлэл мэдээлэлгүйгээр оршин тогтнох боломжгүй. Ийм учраас Хэвлэл мэдээллийн зөвлөл ардчиллын үнэт зүйлийг бий болгох, хангах, ардчиллын утга мөн чанарыг хадгалахад маш чухал үүрэгтэй юм. Хэвлэлийн зөвлөлийн өмнөө барьж байгаа ёс зүйн зарчим мэргэжлийн редакторууд, сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагын эзэд ямар хариуцлагатай ажил хийж байгаа вэ гэдгээ ойлгож ухамсарлах тэр боломжийг бас олгодог.

-Сэтгүүл зүй мэргэжлийн байхад хамгийн чухал нь ёс зүйн код байдаг. Энэ нь сэтгүүлчдэд юу өгдөг вэ?

-Монголын хэвлэлийн зөвлөлийг би ёс зүйн кодоо маш сайн гаргасан байна гэж хэлсэн. Ёс зүйн код нь сэтгүүлч, хэвлэлийн эзэд, редакторуудын хувьд өмнө нь мэддэг байсан зүйлээс өөр шинэ зүйл бол биш. Илүү нарийн, дэвшилттэй хувилбар болсон байгаа. Хэвлэлийн зөвлөлөөс үүнийг гаргана гэдэг нь байгууллагуудад бид үүнийг баримтална гэсэн албан ёсны тунхаглалыг гаргаж өгч байгаа гэсэн үг. Зөвхөн мэргэжлийн салбарынханд хамаатай биш, олон нийтэд ч хамааралтай. Ямар зүйлийг ёс зүй гэх вэ гэдгийг мэдүүлээд, ямар мэдээг ёс зүйтэй, ямыг нь ёс зүйгүй вэ гэх байдлаар олон нийтийн мэдлэг мэдээллийг дээшлүүлж байгаа юм. Ингэснээрээ иргэдийн зүгээс ч гэсэн ёс зүйгүй байна гэдэг тал дээр санал бодлоо зөв илэрхийлэх боломжийг нь нээж өгч байгаа.

Сүүлийн үед манай Боснигийн Хэвлэлийн зөвлөлд ирж байгаа гомдол ямар байдалтай болж байна вэ гэхээр “... Хүндэт редакци,... хүндэт редактороо, танай хэвлэлийн байгууллагаас гаргасан энэ мэдээлэл чинь таны мэргэжлийн ёс зүйн зарчмын энэ энэ заалтуудыг зөрчиж байна” гэж ирдэг болсон. Мэргэжлийн болж байгаа. Ийм гомдол хүлээн авсан байгууллага өөрийн эрхгүй юмаа эргэж харахаас аргагүй байдалд орох жишээтэй. Уншигч сонсогчид нь өөрсдөөс нь илүү мэргэжлийн ёс зүйн кодыг мэддэг болсон байна гэсэн үг. Энэ нь тухайн редакци бид үүнийгээ засахгүй бол хэрэглэгчээ ▶

▶ алдах юм байна гэж ухамсарлах хэмжээнд хүргэж байна.

Хэвлэл мэдээллийн зөвлөл хэвлэлийн салбарыг хараад, атгаад сууж байдаг мафийн толгойлогч шиг аюултай байгууллага бол биш. Аливаа асуудалд саармаг буюу дундын байр сууринаас хандаж аль нэг тал руу хэвийсэн бус салбарын мэргэжилтнүүд болон хэрэглэгч хоорондын харилцан ойлголцоог бий болгож цаашид хамтарч хөгжүүлэх зорилготой байгууллага. Иргэд, сэтгүүлчид хамтраад сэтгүүл зүйн салбарын мэргэжлийн хэм хэмжээг дээшлүүлэх зорилготой. Хамтдаа тэмцэнэ гэсэн үг. Олон нийт бол хэвлэл мэдээллийн хэрэгсэл эрх чөлөөгөө олж аваагүй цагт ард иргэдийн хувьд эрх чөлөө байхгүй юмаа гэдгийг маш сайн ойлгох хэрэгтэй. Нөгөө талаас сэтгүүлчдийн хувьд хариуцлагатай, үнэн зөв мэдээллийг өгөх боломжгүй орчин байвал ард түмэн хохирно гэдгийг ухамсарлах ёстой. Тиймээс манай хэвлэлийн зөвлөл “Иргэд болон сэтгүүлчид хамтдаа үнэний төлөө тэмцэцгээ” гэсэн уриа үгийг ашигладаг. Энэ үгийг мөн Монголд ч гэсэн ашиглаж болно. Тэгэхээр бие даасан, үйл ажиллагаа нь тогтмолжсон хэвлэл мэдээллийн зөвлөлтэй байна гэдэг бол тухайн улс ардчиллыг өндөрт өргөж, ардчилал биелэлээ олсоны том нотолгоо юм.

-Хэвлэлийн зөвлөл төлөвшихөд эзэд, сэтгүүлчид яаж хамтран ажиллаж дэмжиж ажиллах вэ. Тэдний оролцоо ямар байх ёстой вэ?

-Сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн эзэд юуны өмнө Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс гаргасан ёс зүйн зарчмыг үйл ажиллагаандаа мөрдөхөө хүлээн зөвшөөрөх ёстой. Харин Хэвлэлийн зөвлөлөөс ёс зүйг хэрэгжүүлж байгаагийнх нь хариуд “Энэ байгууллага ёс зүйг дээдэлж, баримталдаг байгууллага шүү гэдэг лого өгч, брэндингийг нь маш сайн хийж өгөх хэрэгтэй. Ингэснээрээ тухайн байгууллагад өөрт нь ч гэсэн давуу тал бий болох боломжтой.

Мөн хэвлэл мэдээллийн байгууллагууд өөрсдөд нь хаягласан санал гомдлыг хүлээн аваад, хүлцэл өчиж, залруулга хийх байдлаар зохих хариу үйлдэл үзүүлснээрээ тухайн хэвлэл мэдээллийн байгууллага уншигч, сонсогчдоо хүндэтгэдэг төдийгүй алдаа дутагдлаа хүлээн зөвшөөрөх чадвартай, хариуцлагатай байгууллага гэдгээ илэрхийлж байгаа юм. Ингэснээрээ мэдээлэл түгээгч байгууллага болон хэрэглэгчдийн

дунд илүү бат бэх хамтын ажиллагаа бий болох давуу талтай.

Мөн хэвлэлийн зөвлөлтэй болсноор хэвлэлийн байгууллагууд алдаа дутагдлаа засах, тулгарч байгаа асуудлаа хамтарч шийдвэрлэх мэргэжлийн түнш байгууллагатай болж байна гэсэн үг.

Хэвлэлийн байгууллагууд, эзэд Хэвлэл мэдээллийн зөвлөлийнхөө наанадаж үйл ажиллагаа явуулах наад захын санхүүгийн дэмжлэг үзүүлэх нь чухал. Хэвлэл мэдээллийн зөвлөл гэдэг бол өөрийн зохицуулалтын салашгүй бөгөөд хамгийн органик хэсэг. Энэ хэсгийн үйл ажиллагааг дэмжих нь хэвлэл мэдээллийн эздийн үүрэг.

Хөгжингүй орнуудад бол хэвлэл мэдээллийн зөвлөлд үйл ажиллагааг томоохон хэвлэл мэдээллийн байгууллагууд дэмждэг. Өөрсдийнх нь эрх ашгийн төлөө гэдгийг ухамсарладаг учраас ямар ч асуудалгүйгээр дэмжлэг үзүүлдэг. Хөгжил буурай орнууд болон ардчилал шинээр оршин тогтнож буй улсад бид хэвлэл мэдээллийн зөвлөлийг дэмжих боломжгүй гэж хэлэх тохиолдол байдаг. Энэ тохиолдолд заавал мөнгө санхүүгээр биш ч гэсэн өөрсдийн үйл

ажиллагааныхаа чиглэлээр тодорхой хэмжээний зар сурталчилгаа байрлуулах ч юм уу, мэдээлэл гаргах буюу ёс зүйн зарчмуудыг олон нийтэд хүргэх байдлаар дэмжлэг үзүүлэх боломжтой. Нөгөө талаасаа сэтгүүл зүйг хөгжүүлэхийн төлөө мэргэжлийн салбарын талаар аль болох зөв ойлголт өгч, ёс зүй гэдгийг олон нийтэд сурталчилан таниулах ёстой юм.

-Олон улсын туршлагаас харахад төр засгийн байгууллагууд Хэвлэлийн зөвлөлийг дэмжиж хамтрах тал дээр ямар байвал зохилтой вэ?

-Маш сайхан асуулт байна. Зарим улсад хэвлэлийн эрх чөлөөг төр засгаас дэмжих сонирхол байдаг. Энэ нь нэг талаасаа сэтгүүл зүйн эрх чөлөө гэдэг утгаар нөгөө талаас иргэдийн хэвлэн нийтлэх, үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хангаж нэлээд сайн дэмжлэг үзүүлдэг төр засаг байна. ХБНГУ гэхэд зарим тохиолдолд Хэвлэлийн зөвлөлийн үйл ажиллагааны нийт төсвийн 48 хүртэл хувийг төрөөс гаргадаг. Герман энэ тал дээр хамгийн үлгэр жишээ улс. Ардчилал шинээр хөгжиж байгаа улсуудын хувьд энэ асуудал бэрхшээлтэй. Ийм орнуудад ▶

Монголын хэвлэлийн зөвлөл нэг нас хүрлээ

Монголын хэвлэл мэдээллийн салбарт өөрийн зохицуулалтын байгууллагыг аливаа ашиг сонирхлоос ангид, олон улсын жишгийн дагуу мэргэжлийн түвшинд байгуулахаар сэтгүүлч, ажил олгогч, судлаач, эвсэл холбоод болон төрийн бус байгууллага санал нэгдэн байгуулсан. Өнгөрсөн оны нэгдүгээр сарын 28-нд хэвлэл мэдээллийн салбарынхан Монголын хэвлэл мэдээллийн зөвлөлийг үүсгэн байгуулах чуулганаа хийж, дүрмээ батлан, Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмаа тунхагласан тэмдэглэлт үйл явдал болсон билээ.

Монголын хэвлэлийн зөвлөл удирдах зөвлөлийн 15 гишүүнтэй бөгөөд тус бүр 15 гишүүнтэй Сонин, сэтгүүл, сайт /ССС/-ын болон Радио телевизийн гэсэн тус бүр 15 гишүүнтэй, хоёр ёс зүйн хороотой. Нийт 45 хүний бүрэлдэхүүнтэй ажилладаг. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд Хэвлэл мэдээллийн зөвлөл үйл ажиллагаагаа амжилттай эхэлж, одоогоор иргэдээс 10 гаруй гомдол хүлээн авч,

хэлэлцэн шийдвэрлээд байна.

Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын нийгмийн өмнө хүлээх хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх зорилгоор сэтгүүлчид мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээгээ мөрдөж ажиллахад нь дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй энэ байгууллага нь өнгөрсөн сарын 28-нд нэг жилийн хугацаанд хийсэн ажлаа оролцогч талуудад танилцууллаа. Жилийн хугацаанд хэвлэлийн зөвлөлийн үйл ажиллагааг салбарынхандаа ойлгуулж таниулах, Хэвлэлийн зөвлөлийн удирдлага, гишүүдийнхээ мэдлэг мэдээллийг дээшлүүлэх сургалт хийж, оны өмнөхөн ХБНГУ-д хоёр ёс зүйн хорооны гишүүд, ажлын албаныхан туршлага судалж амжсан байна.

Мөн дотооддоо мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагатай хамтран ажиллахын сацуу ХБНГУ-ын DW академи, Фредрих-Эвертийн сан зэрэг гаднын байгууллагуудтай нягт хамтран ажиллаж буй юм. ■

▶ хэвлэл мэдээллийн зөвлөл төрөөс мөнгө авлаа гэхэд эргээд төрийн хараат байдлаа алдах вий гэсэн болгоомжлол бол байдаг. Нөгөө талаас зарим улсын төр засаг хэвлэл мэдээллийн тусгаар тогтнол сэтгүүл зүйн эрх чөлөөг дэмжих нь өөрсдийн үүрэг гэж огт харахгүй байх тохиолдол ч бий. Гэхдээ эрг орой хэзээ нэгэн цагт Хэвлэлийн зөвлөл гэдэг байгууллага төр засгаас нийт төсвийнхөө тодорхой хувийг гаргуулах ёстой. Яагаад гэвэл энэ нь эргээд хариуцлагатай сэтгүүл зүй хэвлэлийн эрх чөлөө дээрээс нь ардчиллын үнэт зүйлсийн нэг тулгуур хүчин зүйл болохын хувьд энэ зорилгын төлөө төрөөс заавал тодорхой хэмжээнд дэмжлэг байх ёстой. Ингэхдээ төрөөс хэвлэл мэдээллийн зөвлөлийн бие даасан байдал хараат бус байдалд нь халдаж, дарамт шахалт үзүүлж болохгүй. Нөгөө талаасаа хэвлэл мэдээллийн зөвлөл гэдэг байгууллагын хувьд төртэйгээ анхнаасаа зөв хамтарч ажиллаж сурах нь чухал. Яагаад гэвэл энэ байгууллага төрийн эсрэг биш. Тэгээд ч төрөөс гаргаж байгаа мөнгө төрийн мөнгө биш, татвар төлөгчдийн мөнгө байдаг. Тийм болохоор татварын мөнгийг иргэдийн хэвлэлийн эрх чөлөөгөөр хангагдах эрхийн төлөө ашиглах нь зүйтэй.

-Сүүлийн үед хэвлэл мэдээллийн зөвлөлийн олон улсын чиг хандлагад ямархуу өөрчлөлт байна вэ?

-Хэвлэлийн зөвлөлийн өөрийн зохицуулалт гэдэг зүйл 100 жилийн өмнөөс Скандиновын орнуудаас үүсэлтэй. Энэ жил хэвлэл мэдээллийн салбарын өөрийн зохицуулалт бий болсны 100 жилийн ойг Швейцар улсад гэмдэглэх гэж байна. Германд 60 жилийн өмнө байгуулагдсан. Норвегт бол бараг 100 жил болж байна. Их Британи, Эстони зэрэг улс мөн он удаан жилийн түүхтэй. Харин коммунист болон социалист дэглэмтэй байж байгаад шинэхэн ардчилал руу шилжсэн улсуудын хувьд бол Босни Херцеговины анхдагчдын нэг. Манай улсад Хэвлэл мэдээллийн зөвлөл байгуулагдаад 15 жилийн нүүр үзэж байна. Мөн Македон, Серби зэрэг 30 гаруй оронд арав гаруй жил болж байгаа. Дэлхий даяар хэвлэл мэдээллийн зөвлөлийн тоо өдөр ирэх тусам олширч байна. Хуучин ЗХУ-ын гишүүн байсан ОХУ, Азарбажен, Гүрж, Армен гэх мэт

оронд ч байгуулагдлаа.

Ази Номхон далайн бүсэд ч гэсэн томоохон дэвшил өөрчлөлтүүд гарч байна. Жишээлбэл, Монголд Хэвлэл мэдээллийн зөвлөл байгуулагдлаа. Мөн хэдхэн сарын өмнө Мьянмар улсад Сонин хэвлэлийн зөвлөл байгуулагдаад байна. Тайландад мөн адил. Эрх чөлөөг нийгэм хараат бус ардчиллыг хөгжүүлэхийг хүсэж байгаа бол Хэвлэл мэдээллийн зөвлөл гэдэг байгууллагын болон хэвлэл мэдээллийн салбарын үүрэг оролцоо маш чухал.



Хэвлэлийн зөвлөлийн УЗГ-ийн сургалт

-Энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж, дуу хоолой болдог олон улсын байгууллага хэр олон бэ?

Олон улсад одоогийн байдлаар өөрийн зохицуулалтын гурван холбоо үйл ажиллагаа явуулж байна. Нэг нь Европын холбооны бие даасан хэвлэл мэдээллийн зөвлөлүүдийн холбоо. Хоёр дахь нь ЗХУ-ын гишүүн байсан орнуудын хэвлэл мэдээллийн зөвлөлийн холбоо гэж бий. Бид баруун Балканы бүс нутгийн өөрийн зохицуулалтын холбоо гэж байгуулсан. Ази Номхон далайн бүсийн сэтгүүл зүйн өөрийн зохицуулалтын холбоог байгуулъя гэсэн яриа гарч байгаа. Энэ зүйлийн талаар би ирэх жилүүдэд илүү ярих байх гэж бодож байна.

-Хэвлэл мэдээллийн зөвлөл танай оронд 15 жилийн түүхтэй. Та өөрийн орны хэвлэлийн зөвлөлийг олон жилийн турш удирдаж, авч яваа хүний хувьд өнгөрсөн хугацааны ололт амжилт хийгээд бахархах түүх нь юу байдаг вэ?

-Бахархах зүйл маш олон бий. Энэ бол богинохон хугацаа. Ярилцлагын эхэнд дурдсанчлан манай хэвлэлийн зөвлөлийг анх байгуулагдаж байхад хүмүүс бас эргэлзэж тээнгэлзсэн итгэл үнэмшил муутай байсан. 15 жилийн дараа харахад

хэвлэл мэдээллийн салбарынхан, иргэд, улс орон манай зөвлөлийг бидний анд нөхөр, журмын нөхөд хардаг болсон. Өөрөөр хэлбэл, мэргэжлийн сэтгүүл зүйг хөгжүүлэхээр явдаг гэсэн тэр итгэл үнэмшил тогтсон байгааг би харж байна. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэд ч гэсэн хэвлэлийн зөвлөлийн шүүхээр шийдүүлэхгүйгээр хийгээд байгаа ажил бидний цаг, мөнгийг хэмнэж байна гэдгийг ойлгодог болсон. Сэтгүүлчид ч гэсэн өөрсдийгөө өмгөөлүүлэх, асуудалд хэрхэн хандах талаар зөвлөгөө мэдээлэл авч байна. Тухайлбал, бэлгийн цөөнхийн асуудал зэрэг хоёр талаас нь харж болох эмзэг сэдвүүд дээр ч гэсэн аль талаас нь харвал зүгээр вэ, яаж энэ асуудлыг мэдээлэх вэ гэдэг дээр биднээс заавар зөвлөгөө авдаг. Хэвлэл мэдээллийнхэн маань ч гэсэн иргэдээс ирүүлж байгаа санал гомдолд хариу үйлдэл үзүүлээд даджээ. Бидний хийсэн олон сургалт семинарын үр дүнд их сургуулиуд болон ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт хэвлэл мэдээллийн салбарын өөрийн зохицуулалтын талаар ойлголт өгөх хичээлүүд ордог. Аливаа зүйлийг эхлэхдээ анхнаас нь мэргэжлийн байж, зөв эхлүүлбэл цааш хадгалж авч явахад амар хялбар байдаг.

-Та хэвлэлийн зөвлөлийн талаар хэчнээн оронд явж сургалт хийж байна вэ?

-Балканы орнуудад хэвлэл мэдээллийн зөвлөл байгуулах талаар ажиллаж байсан. Серби, Косова, Македон, Монти Нигро, Молдав, Мьянмар зэрэг улсад хамтарч ажилласан. Найм дахь орон нь Монгол болж байна. Харвот болон Унгар улсад ажилласан. Хармсалтай нь Харвот хоёр ч удаа хэвлэлийн зөвлөл байгуулах гээд үзсэн боловч бүтэлгүйтсэн. Гэхдээ болно гэдэгт би итгэдэг. Унгар Европын холбооны улс ч гэсэн одоо болтол хэвлэл мэдээллийн зөвлөл хараахан байгуулж чадаагүй. 2016 онд болчих байх гэж найдаж байгаа, өөрсдөө ч гэсэн ийм амлалт өгсөн.

Харвотод хэвлэлийн зөвлөл байгуулах гээд амжилтгүй болсон шалтгаан нь юу байсан бэ?

-Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэд нь ихэвчлэн ходинг, группийнхэн байдаг учраас дэмжлэг авч чадахгүй байгаа. Бусад улсын хувьд амжилттай болсон. ■



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР



НАЙРСАГ
УЛААНБААТАР

Улаанбаатар

НАЙРСАГ УЛААНБААТАР 2016 ХУАНЛИ



1

Да	Мя	Лх	Пу	Ба	Бя	Ня
					1	2 3
4	5	6	7	8	9	10
11	12	13	14	15	16	17
18	19	20	21	22	23	24
25	26	27	28	29	30	31

2

Да	Мя	Лх	Пу	Ба	Бя	Ня
1	2	3	4	5	6	7
8	9	10	11	12	13	14
15	16	17	18	19	20	21
22	23	24	25	26	27	28
29						

3

Да	Мя	Лх	Пу	Ба	Бя	Ня
1	2	3	4	5	6	7
8	9	10	11	12	13	14
15	16	17	18	19	20	21
22	23	24	25	26	27	28
29	30	31				

4

Да	Мя	Лх	Пу	Ба	Бя	Ня
					1	2 3
4	5	6	7	8	9	10
11	12	13	14	15	16	17
18	19	20	21	22	23	24
25	26	27	28	29	30	

5

Да	Мя	Лх	Пу	Ба	Бя	Ня
30	31					1
2	3	4	5	6	7	8
9	10	11	12	13	14	15
16	17	18	19	20	21	22
23	24	25	26	27	28	29

6

Да	Мя	Лх	Пу	Ба	Бя	Ня
					1	2 3
4	5	6	7	8	9	10
11	12	13	14	15	16	17
18	19	20	21	22	23	24
25	26	27	28	29	30	

7

Да	Мя	Лх	Пу	Ба	Бя	Ня
					1	2 3
4	5	6	7	8	9	10
11	12	13	14	15	16	17
18	19	20	21	22	23	24
25	26	27	28	29	30	31

2016.02.06
"УЛААНБААТАРЫН ӨВЛИЙН
НААДАМ"

2016.03.26-04.10
"Дэлхийн Цирк Монголд"
олон улсын цирк

2016.05.15-05.21
"ГЭГЭЭН МУЭА" театр урлагийн
наадам

2016.06.04
"УЛААНБААТАР" олон улсын
марафон - бүх нийтийн гүйлт

2016.07.02
"BEST OF CLASSICS" сонгодог
урлагийн үлдэц

8

Да	Мя	Лх	Пу	Ба	Бя	Ня
1	2	3	4	5	6	7
8	9	10	11	12	13	14
15	16	17	18	19	20	21
22	23	24	25	26	27	28
29	30	31				



2016.05.20-21
"УЛААНБААТАР BOOK FAIR"
номын баяр

2016.06.04-05
"УЛААНБААТАР" аялал
жуулчлалын үзэсгэлэн

2016.07.10
"УЧИРТАЙ ГУРВАН ТОЛГОЙ" дуурь

2016.08.06
500 лам ном хурал

2016.08.06-07
"ДАНШИГ" НААДАМ-ХҮРЭЭ ЦАМ"
цагийн соёлын наадам

2016.08.06
"УУЛ УСНЫ ДОМОГ" монгол
нугаралт фестиваль

2016.08.07
"ЭВЛЭХ УЯНГА БЮУУ ЕР БУСЫН
ЭРЧИМ" этно музейл

2016.08.13-14
"UB FOOD" фестиваль

2016.08.15-20
"МОНО ХУЖГИЙН НААДАМ"

9

Да	Мя	Лх	Пу	Ба	Бя	Ня
					1	2 3 4
5	6	7	8	9	10	11
12	13	14	15	16	17	18
19	20	21	22	23	24	25
26	27	28	29	30		

10

Да	Мя	Лх	Пу	Ба	Бя	Ня
31						1 2
3	4	5	6	7	8	9
10	11	12	13	14	15	16
17	18	19	20	21	22	23
24	25	26	27	28	29	30

11

Да	Мя	Лх	Пу	Ба	Бя	Ня
					1	2 3 4
7	8	9	10	11	12	13
14	15	16	17	18	19	20
21	22	23	24	25	26	27
28	29	30				

12

Да	Мя	Лх	Пу	Ба	Бя	Ня
					1	2 3 4
5	6	7	8	9	10	11
12	13	14	15	16	17	18
19	20	21	22	23	24	25
26	27	28	29	30	31	

2016.06.18
"UB DANCE" фестиваль

2016.06.24-06.26
"PLAY TIME" олон улсын амьд
хөгжмийн наадам

2016.07.11
"УЛААНБААТАРЫН ҮДЭШ" рок, поп
олдын тоглолт

2016.07.12
"SILENCE WHITE" электро
хөгжмийн наадам

2016.07.12
"ТАЛЫН БУЖИГ" ФЕСТИВАЛЬ"
монгол туургатны бүжгийн их
наадам

2016.07.13
"МОРИН ХУУР ФЕСТИВАЛЬ"
морин хуурын наадам

2016.07.14
"УЛААНБААТАР SWING NIGHT"
их талын жазз олон улсын
фестиваль

2016.07.30
"АЛДРЫН ОД" урлагийн оддыг
алдаруулах тоглолт

2016.09.25-30
"UB ART AND STREET ART"
дүрслэх урлагийн өдрүүд

2016.10.11-10.15
"УЛААНБААТАР" олон улсын кино
наадам

2016.12.05-12.15
"ЦЭМБЭХЭЙ" бүжгэн жүжиг



Аялал жуулчлал

Найрсаг хот энэ онд

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2014 оны 19/24 дүгээр тогтоолоор баталсан “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрт үндсэн долоон зорилтыг тавьсан ба эдгээр зорилтын хүрээнд 2016 онд 25 багц ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа аж. Эдгээрийг багцлан уншигчиддаа хүргэж байна.

Нэгдүгээр зорилтын хүрээнд аялал жуулчлалын эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, бизнес эрхлэгчдийг дэмжих бодлого, зохицуулалтыг оновчтой болгох ажлууд хийх гэнэ. Үүнд зочид буудал, дэн буудлын стандартыг шинэчлэх, нийслэл хотын албан татварын тухай хууль батлагдсантай холбогдуулан жуулчдын тоог ор/хоногоор тооцох аргачлалд шилжих зэрэг ажил багтжээ.

Хоёрдугаар зорилтын хүрээнд гадаад дотоодын жуулчид нийслэлд аюулгүй зорчих, шаардлагатай мэдээлэл, туслалцааг шуурхай авах нөхцөлийг бүрдүүлэх ажлууд байна. Үүнд, эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээг иргэний харьяалал харгалзахгүй үзүүлэх нөхцөлийг нийслэл, дүүргийн эмнэлгүүдэд бүрдүүлэх, хотын жуулчны мэдээллийн төвүүдийг тогтвортой ажиллуулах. “Жуулчны мэдээллийн лавлах утас”-ны үйлчилгээг технологийн дэвшилд тулгуурлан сайжруулах, үйлчилгээний газруудын хаяг, байршлын мэдээллийг ГүүглМэпд 3D хэлбэрээр оруулж, иргэд жуулчид гар утас, ухаалаг төхөөрөмжөө ашиглан хялбар зорчих, ойр орчмын үйлчилгээний газруудынхаа мэдээллийг авах боломжийг бүрдүүлэх аж.

Гуравдугаар зорилтын хүрээнд жуулчид, иргэдэд зориулсан амралт, аялал жуулчлалын төвүүдийг байгуулж, алжаал тайлах тав тухын орчныг бий болгох ажлууд хийнэ гэжээ. Тухайлбал, хот орчмын явган аяллын нэг гол чиглэлийг олон улсын стандартын дагуу үлгэр жишээ тохижуулах, НИТХ-аас батлагдсан хотын аяллын гол маршрутын дагуу хийх тохижилтын ажлууд багтаж буй.

Дөрөвдүгээр зорилт буюу Улаан-

баатар хотыг аялал жуулчлалын зорих газар болгон гадаадад сурталчлах ажлын хүрээнд ХБНГУ, ОХУ, БНХАУ, Япон, Хонгконг зэрэг оронд болдог дэлхийд тэргүүлэх аялал жуулчлалын үзэсгэлэн, яармагуудад нийслэлийг сурталчлан оролцох. Мөн олон улсын нэр хүндтэй сонин, сэтгүүл, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран Улаанбаатарын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үз-мэрүүдийг сурталчлах цогц ажлууд хийх аж.

Тавдугаар зорилт буюу хотын онцлог, давуу талыг тусгасан, жуулчдын хэрэгцээнд нийцсэн аяллын бүтээгдэхүүн, шинэ үйлчилгээг гаргах ажлын хүрээнд Хүрэлтогоот дахь одон орон судлалын төвийг жуулчдад нээлттэй, аялал жуулчлалын төв болгох ажлыг эхлүүлэх гэнэ. Мөн нийтийн тээврээр зорчих болон үзвэр, үйлчилгээний газруудад багцын үнээр үйлчлүүлэх боломжтой “Жуулчин” картыг үйлчилгээнд нэвтрүүлэх, агаарын такси үйлчилгээ нэвтрүүлэх эхний шагна ажлуудыг хийх юм байна.

Зургаадугаар зорилтын хүрээнд жуулчдыг татах урлаг, спорт, олон нийтийн арга хэмжээг зохион байгуулах аж. Үндэсний их баяр наадмын үеэр жуулчдад зориулсан олон нийтийг хамарсан соёл, урлагийн долоон арга хэмжээ, бусад хугацаанд соёл урлаг, спорт, аялал жуулчлалын 20 арга хэмжээ болно. Эдгээрийн дотор “Даншиг наадам-Хүрээ цам”, Сонгодог урлагийн үдэш, төв талбайд зохиогддог цуврал фестивалиуд зэрэг 2015 оноос эхэлсэн жуулчдын сонирхлыг ихээр татаж буй арга хэмжээнүүд багтжээ.

Долоодугаар зорилт буюу бүх төрлийн үйлчилгээнд найрсаг харилцаа, хандлагыг төлөвшүүлж хотын соёлыг дэлгэрүүлэх ажлын хүрээнд өндөр хөгжилтэй орны сургалтын хөтөлбөрөөр үйлчилгээний менежментийн сургалтууд явуулж үйлчилгээний болон хотын соёлыг дэлгэрүүлэх “Инээмсэглэх Монгол”, “Соёлтой жолооч”, “Найрсаг Улаанбаатар” зэрэг нийгмийн аяныг явуулах аж. ■

Эх сурвалж: Нийслэлийн Аялал жуулчлалын газар

Хөрөнгийн зах зээл

Трендийн араас

Б.ҮҮРИЙНТУЯА

1997 онд Английн “Marillion” (үйл ажиллагаанд тус хамтлаг гардан оролцоогүй ч 2001 онд гаргасан цомог болон удаах хэд хэдэн бүтээлдээ санхүүжилт босгох энэхүү аргыг ашигласан) рок хамтлагийн аялан тоглолтыг санхүүжүүлэхээр АНУ дахь фенүүд интернэт “цуглаан” үүсгэн 60 мянган ам.доллар хуримтлуулсан нь crowdfunding буюу олон нийтийн санхүүжилтийн орчин үеийн эх үндсийг тавьжээ. Үүнээс хойш олон жил улирч буй ч энэ ойлголт төдий л дэлгэрч амжаагүй хэвээр 2014 онтой золгосон.

Олон нийтийн санхүүжилтээр хөрөнгө босгох энэхүү үйл хэрэг 2013 онд дэлхий даяар нийт 5.1 тэрбум ам.доллар босгосон байдаг. Одоогоос хоёр жилийн өмнө олон нийтийн санхүүжилт гэгдэх энэ хандлага 450 гаруй платформоор дамжиж нийтэд

Хойд Америк 145
хувийн өсөлтөөр
9.46 тэрбум
ам.доллар босгон
тэргүүлсэн бол
Европт 3.26 тэрбум
ам.доллар босгов


хүрч байсан. Тэгвэл 2014 онд эрчимтэй хөгжиж, 2013 онтой харьцуулахад 167 хувиар өсөн 16.2 тэрбум ам.доллараар үнэлэгдэх зах зээл болж чадсан. Үүнд Ази олон нийтийн санхүүжилтийн том төвүүдийн нэг болсон нь нөлөөлсөн бөгөөд санхүүжилтийн хэмжээ 320 хувиар тэлж 3.4 тэрбум ам.доллар босгосон талаар www.crowdsourcing.org цахим хуудсанд нийтэлжээ.

Шинэ биш ч саяхан түгээмэл болж ирсэн олон нийтээс санхүүжилт босгох энэ арга таван жилийн өмнө маш жижиг гэгдэж байсан бол 2015 онд тус зах зээл 34.4 тэрбум ам.долларт хүрнэ гэх таамаг дүгнэлт болж, хамрах салбарууд илүү өргөн хүрээнд тэлсэн (Massolution “The Crowdfunding Industry Report 2015”). ▶

► Ном, цомог гэх мэт бүтээлч төслийг олон нийтийн санхүүжилтээр бүтээх нь ердийн үзэгдэл болсон ч суурин газрын дэд бүтцийг шийдвэрлэх асуудалд ийнхүү хөрөнгө босгох болсон нь 2016 оны онцлог байх талаар “The Economist” сэтгүүл “The World in 2016” тусгай дугаартаа нийтэлж. Ингэхдээ иргэдийн оролцоогоо нэмэгдүүлэх шаардлага, төрийн төсвийн бууралт өөр хоорондоо сөргөлдөх болсон энэ үед ирээдүйн хотууд бүтээн байгуулалтуудаа ийн хийх болов уу гэсэн төсөөллийг дурджээ.

Олон нийтийн санхүүжилтийг үндсэн таван чигт (урамшууллын, зээлийн (өрд суурилсан P2P), нэхэмжлэх, сайн үйлсийн, үнэт цаасны) хуваадаг бол хамгийн түгээмэл дэлгэрч байгаа нь урамшууллын болон үнэт цаасны хэлбэр. Хамгийн шинэ категори гэгдэх үнэт цаасны чиглэлээр 2014 онд 2.5

Топ 5 салбар, хөрөнгө босголт
тэрбум ам.доллараар, 2014 он



Бизнес, бизнес эрхлэлтийн салбарт 2014 онд 6.7 тэрбум ам.доллар босгосон нь олон нийтийн санхүүжилтийн 41.3 хувийг эзэлж байна. Ийнхүү хамгийн эрэлттэй салбар болж байгаа юм.

“зүтгэж” байгаа. Харин саяхнаас үнэт цаасны чиглэл, хувьчлалын салбарт олон нийтээс санхүүжилт босгох цөөн хэдэн санаачлага дуулдах болсон. Оны өмнө Засгийн газрын зүүн хажууд байрлах хэвлэх үйлдвэрийн байрыг дуудлага худалдаагаар оруулахад Ард санхүүгийн нэгдлийн гүйцэтгэх захирал Ч. Ганхуяг олон нийтийн оролцоогоор хувьчлал явуулах боломжит гарц байж болохыг харуулсан. Тэгвэл Хөрөнгийн биржийн хувьчлалд мөн дээрх аргаар оролцож, хувьцаа эзэмших замаар оруулсан мөнгөн хөрөнгийнхөө үр шимийг хүртээд явах бололцоог нээх үүднээс “Новел Фанд” ХХК байгуулагдсан. Эрх зүйн хүрээнд яригдах олон асуудал байгаа ч эдгээрийг эхлэл гэж ойлгож болох юм.

Гэвч олон нийтийн санхүүгийн мэдлэг хомс, мэдээлэл түгээх аргачлал дутмаг эсвэл хязгаарлагдмал байгаагаас нийтийн идэвх сул, зарим талаар бүр байхгүй байна. Хуулийн дагуу хэрхэн явдаг тухай ч ойлголтгүй байгаа. Дэд бүтцийн салбар дахь олон нийтийн оролцоогоор хөрөнгө босгох чиглэлд Их Майдар төслийг дурдаж болох юм. Харамсалтай нь өнөө, маргаашийн талхны мөнгөө аргацааж буй иргэд олонх байгаа одоогийн нөхцөлд дээрх санаачлагууд тоотой хэдэн хүний дунд өрнөх, зорилгодоо хүрэхгүй байх, хандивлагчийн хомсдолд орох эсвэл зорилгын бус зүйлсэд ашиглагдана гэх нийтийн айдас хүлэгдэж мэдэх юм. Эдгээр нь crowdfunding-ийн дэлхий дахинаа туулах саад, тулгарах бэрхшээл болдог. Одоогоос дөрвөн жилийн өмнө элэг шилжүүлэн суулгах шаардлагатай хэмээгдэж байсан ой гарантай хүүгийн харамсалтай түүх бий. Тэрээр олны хандиваар Энэтхэг улсыг зориод ирсэн ч удалгүй өөд болсон нь цахим сүлжээгээр тарах хандивын аянуудын эцсийн дүн хэрхэх вэ гэдэг эргэлзээг төрүүлсэн. Гэсэн ч эргэлзээ удаан үргэлжлээгүй бөгөөд эмчилгээний зардал цуглуулах, эмнэлгүүдийн тасгуудыг тохижуулах, тоног төхөөрөмж хандивлах, орон гэргүй нэгнээ оочих аягатай нь залгуулах зэргээр үргэлжилсээр байна.

Харин одоо, өрөвч сэтгэлийн зэрэгцээ ухаалаг сэтгэлгээгээр олон нийтийн санхүүжилтийн бусад чиглэлд анхаарч өөрсдийн дэмээр босгосон зүйлсийнхээ үр өгөөжийг улс нийтээрээ хүртэх боломжийг бүтээх хэрэгтэй. Энэ гэхдээ зөвхөн иргэдийн гарт бус эрх баригчдын хүчин зүтгэлээр өргөжиж салбар. ■



тэрбум ам.доллар босгосон байдаг бол санхүүжилтийн өсөлтөөрөө 2016 онд хамтын хөрөнгийн үзүүлэлтийг хол “хаяхаар” байгаа юм. Түүнчлэн 2020 он гэхэд 36 тэрбум ам.доллар хүрнэ гэх таамаг гарсан. Гэсэн ч P2P 2014 онд 11.08 тэрбум ам.доллар босгосон, салбартаа ноёрхож байгааг “The Crowdfunding Industry Report 2015” тусгасан байна. Үүнд мөн л Хятадын өсөлтөөс ихээхэн үүдэлтэй Азийн P2P, P2B зээлийн зах зээлийн өсөлт нөлөөлсөн гэдгийг “Massolution”-ий үүсгэн байгуулагч,

гүйцэтгэх захирал Карл Эспости хэлжээ.

Монголд тренд хаана явна вэ?

Эрүүл мэндийн тогтолцоо сул тул иргэд элдэв өвчинд шаналан олон нийтийн сүлжээгээр уриалга гарган нэгэндээ туслах болсоныг сайн үйлсийн төлөө олон нийт мөнгө босгох чиглэл манай улсад давамгайлж байна гэж болох юм. Барууны орнуудад www.gofundme.com тэргүүтэй цахим хаягууд crowdfunding-ийн нийтэд танигдсан суваг болдог бол Монголд “Facebook” ийм үүрэгт илүү

Засаглал

ТӨХ-г татан буулгах цаг дор

Татан буулгана, буулгахгүй гэж олон жил ярьсан Төрийн өмчийн хорооны асуудал цэгцэрч, тус хороог буулгах үйл явц ид өрнөж байна. Улмаар тус хорооны чиг үүрэг Сангийн яаманд шилжих нь.

Гэсэн ч ажиллах орон тоо, төсөв нь батлагдаагүй, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудад төрийн төлөөллийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин хараахан бүрдээгүй. Эл асуудлыг цэгцлэх үүднээс Төрийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоолыг Засгийн газрын өнгөрсөн сарын 4-ний хуралдаанаар баталж, Төрийн өмчийн хороог татан буулгах ажлын хэсэг гаран ажиллаж байна.

Тус хорооны төрийн өмчийн хувьчлал, дуудлага худалдаа, бүртгэл зэрэг ажлыг хариуцсан зарим ажилтныг Сангийн яаманд шилжүүлэхээр боллоо. Тодруулбал, хорооны 50 орчим ажилтнаас зөвхөн 15-ыг нь Сангийн яам руу шилжүүлэх аж. Үлдсэн 30 хүн “лааз өшиглөх” нь. Төрийн өмчийн хороо 2012 оныг хүртэл Ерөнхий сайдын харъяанд байснаа больж УХААЯ-нд очсон удаатай. Тэр үед хорооны ажил тухайн сайдын мэдлээс ангид байсан бол өдгөө хэрхэх нь тодорхойгүй байна.

Хороог татан буулгах шийдвэр гарсны дараа буюу нэгдүгээр сарын 7, 8-нд хорооны байраар ороход сонирхсон асуултад маань хариулах нь байтугай үг дуугарах хүн олдсонгүй. Тэд үүрээ эвдүүлсэн шоргоолж шиг хаачих, хэрхэхээ мэдэхгүй бужигналдаж байв. Ингэх нь ч аргагүй. Хороог буулгах асуудал эртнээс яригдсан ч оны өмнөхөн төсөв нь батлагдаж байсан газар гэнэт буух дээрээ тулсан нь ажилтнуудад тодорхойгүй байдал үүсгэж буйг энд онцолъё. Энэ мэт байдлаар олон агентлагийг цомхотгож байгаа учир цаашид шийдвэр гаргахаас урьдаж маргаашаа харах хэрэгтэйг анхаарвал зохих биз. Хороог татан буулгах ажлын хэсгийнхэн тэднийг нэгдүгээр сарын 15-н гэхэд бүх ажлаа цэгцэлж хүлээлгэн өгөх ёстойг мэдэгджээ. Харин дарга нарынх нь өрөөний хаалгаар хоёр өдрийн турш “салхи” ч орсонгүй. Энэ нь Засгийн газрын хэрэг эрхлэх газар хорооны тамга, тэмдгийг хураан авч, дарга нарыг нь өнгөрсөн сарын 4-нд ажлаас чөлөөлсөнтэй холбоотой.

Өнөөдөр Төрийн өмчийн хорооны чиг үүргийг Сангийн яам хэрхэн, яаж хийх нь асуултын тэмдэгтэй байна. Уг нь шийдвэр гарахын өмнө бүх зүйл тодорхой болсон байх учиртай. УИХ төсөв батлахаас өмнө Төрийн өмчийн хороог 2016 оны эхний өдрөөс татан буулгана гэж байсан атлаа энэ оны төсөвт хувьчлалын орлого, ногдол ашгийн орлогыг Төрийн өмчийн хороо хариуцна гэж заасан нь төрийн шийдвэр хэр хийдэлтэйг тодхон харуулж буй.

Үүсэн байгуулагдсныхаа 20 дахь жил дээр бууж байгаа Төрийн өмчийн хороо өмнө нь ямар ч бүртгэлгүй байсан



төрийн өмчийг нэгдсэн бүртгэлтэй болгож, төрийн өмчит аж ахуйн нэгжүүд улсад ногдол ашиг төлдөггүй байсныг жил бүр төлдөг болгосон зэрэг эерэг өөрчлөлтийг хийсэн. Өнгөрсөн онд гэхэд л улсад 10 орчим тэрбум төгрөгийн ногдол ашиг төвлөрүүлж, хувьчлалаас 15.4 тэрбум төгрөг улсад оруулжээ. Мөн өнгөрсөн хугацаанд давхардсан тоогоор нийт 2000 орчим аж ахуйн нэгжийг хувьчлаад байгаа төдийгүй хувийн хэвшил ДНБ-ий 70 гаруй хувийг үйлдвэрлэдэг болсон. Энэ нь өмч хувьчлалын түүхэн үр дүн гэж үзэж болох юм.

Харин 2015 онд тус хороо ногдол ашгаа дутуу төвлөрүүлсэн гэх шүүмжлэлийг дагуулсан. Учир нь ногдол ашиг төвлөрүүлэх ёстой Хөгжлийн банк, Сангийн яам тэргүүтэй зарим аж ахуйн нэгжийг улсаас ногдол ашиг төлөх жагсаалтаас хасчээ.


Төрийн өмчийн хороо нь бүх яамдын төлөөлөл оролцон хамтын шийдвэр гаргадаг байгууллага. Энэ талаас нь харвал бодлогын яам өмч хувьчлалын ажлыг гартаа авах нь хэр зохилтой бол. Түүнчлэн цаашид 10 мянга гаруй хуулийн этгээд бүхий 20 орчим их наяд төгрөгийн хөрөнгө зөвхөн Сангийн сайдын мэдэлд очиж, нэг хүний салаагаар урсах вий хэмээн болгоомжлох хэсэг ч байна.

Угтаа төрийн өмчийг төвхнүүлэхийн тулд бизнесийн зарчмаар ажиллах нь чухал. Гэтэл бодит байдал дээр аль нэг нам, эрх мэдэлтний шахааны бизнес төрийн өмчид түшиглэн цэцэглэх нь бий. Улмаар наад зах нь компанийн тухай хуулийг хэрэгжүүлдэггүй. Энэ үүднээс үзэхэд Төрийн өмчийн хороог татан буулгах нь зөв гэж үзэх хүн ч цөөнгүй. Ер нь энэ хороо өмчлөгч нь хэн байхаас үл хамааран сайн засаглалтай, бизнесийн зарчмаар ажиллах ёстой аж. Энэ нь төрийн хөрөнгийг өсгөх зөв зам гэдгийг бизнесийнхэн хэлсэн. Монгол Улс Сингапурын “Темасек”-ийн загварыг нутагшуулах нь зөв гэдэг. Эл загвар нь төрд компанийн менежментэд хутгалдахгүй боловч эзний байр сууриа алдахгүй байх боломжийг олгосноороо онцлог. Харин өдгөө манайд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын удирдлагыг сонгоход улс төрийн хүчний оролцоо багагүй байдаг нь нууц биш.

Төрийн өмчийн хороо татан буугдах цаг дор өнөөдөр энэ тухай сөхөхөөс өөр аргагүй. ■

Улс төрийн намуудын ялгаа улам бүр арилж, сонгууль угтсан шоу газар авсаар. Хэн бүхэнд таалагдаж, ахиу санал авна гэж бодохоос сонгуульд өрсөлдөх сонирхолтнуудын нойр хулжаад эхэлжээ.

Намын санхүүжилт босгох асуудал даамжирч зарим нэгнийг “аавын хаалга” татахад ч хүргэж байх жишээтэй. Улс төрийн тогоо халуун байна.



Улс төрийг хэрхэн ойлгож, тайлбарлах вэ?

С.ЗУЛЬФИКАР

(Удирдлагын академийн Улс төр судлал, нийгмийн удирдлагын тэнхмийн эрхлэгч, доктор, дэд профессор)

Улс төр нь нийгмийн үзэгдэл болохын хувьд хүн төрөлхтний түүхтэй нас чацуу ойлголт гэж тайлбарлах нь бий. Тийм ч байж болно үгүй ч байж болно. Ямартай ч улс төр хүн төрөлхтний түүхийн бүхий л цаг үед хүмүүс нийгмийн харилцаанд оролцох, тэднийг чиглүүлэх арга хэрэгсэл болж байсан гэдэгтэй маргах зүйлгүй. Гагцхүү тухайн цаг үе, нийгмийн нөхцөл байдал, түүхэн өөрчлөлттэй зэрэгцэн харилцан адилгүй байдлаар ойлгогдож, харилцан адилгүй үйл явц, үр дүн дагуулж байв. Зарим тохиолдолд хүн төрөлхтний муу мухайн жишээ болж байсан бол зарим тохиолдолд сайн сайхан зүйлийн үр үндэс, улс орныг гэрэл гэгээтэй болгоход чиглэсэн урлаг хэмээн хэлэгдэж байжээ. Үүний учир шалтгааныг хүн төрөлхтний түүхэн хөгжлийн явцад хүмүүсийн улс төр, нийгэм, эдийн

Хүмүүс нийгмийн тогтолцооны салиггүй хэсэг болохын хувьд улс төр яах аргагүй тэдний хувь тавилан болж байдаг. Улс төрөөс тойрч гарах, татгалзах аргагүй юм. Харин улс төрд хэрхэн, яаж, оролцох вэ? Ямар арга зам, хэлбэрээр, ямар түвшинд хийх вэ? гэдэг нь асуудлын гол нь юм.

холбоотой ямарваа асуудлыг хэлэлцэж шийдэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл явцыг бүхэлд нь полис буюу одоогийн бидний ойлгож байгаагаар төрийн хэрэг буюу улс төр гэж томъёолох болжээ. Англи хэлэнд “Politics” гэсэн ойлголтоор төрийн институцууд, тэр тусмаа засгийн газрын бодлого, шийдвэр, үйл ажиллагааг бүхэлд нь ойлгоно гэсэн байна. Түрэг хэлтэй угсаатны бүлгүүд улс төрийг “Siyaset” гэсэн Араб үгээр нэрлэдэг. Энэ үг нь “сургах, хөгжүүлэх, зохион байгуулах” гэсэн утга санаа илэрхийлдэг байна. Өөрөөр хэлбэл нийгмийн тогтолцоо, түүний бүрдэл болж байгаа нэгжүүдийг зохион байгуулах, шаардлагатай бол соён гэгээрүүлэх, сургах, эцсийн зорилго нь хөгжүүлэх үйлийг агуулдаг ажээ. Тийм ч учраас улс төр, улс төрчдийг тэрхүү хариуцлагатай үүргийг хэрэгжүүлэх чадвартай сонгомол хэсэг, нийгмийн бүлэг гэж ойлгох хандлага давамгайлдаг.

Тус өгүүллийг бичигч улс төрийг түүний хэл зүйн үндэс, агуулга, хамрах хүрээ, илрэх хэлбэр, шинж чанарыг баримтлал болгон тодорхойлж, тайлбарлахын зэрэгцээ нийгмийн амьдрал дахь тодорхой асуудалд хариулт өгч болох практик үйл явцаар жишээлэн ойлгох, үнэлэх дүгнэх боломжтой гэж үзэж байгаа болно. Тухайлбал, Улсын Их Хурлын Чуулганы хуралдаанаар Монгол Улсын төсөв, төсвийн тодотгол хэлэлцэж байгаа үйл явц улс төр гэж чухам юу болохын ойлгомжтой жишээ юм. Төсөв хэлэлцэх явцад тодорхой салбар, орон нутгийн хүсэл сонирхол, хэтийн төлөвийн талаар УИХ дахь улс төрийн намуудын бүлэг, гишүүд байр сууриа илэрхийлж, хэлэлцэн, санал хурааж, шийдвэр гаргадаг. Тэрхүү хэлэлцүүлэг, шийдвэр нь улс төрийг маш тодорхой илэрхийлнэ. Гэтэл төсөв хэлэлцэх явцад иргэний нийгмийн төлөөлөл болсон төрийн бус байгууллагууд, бизнес эрхлэгчид төрийн ордны гадаа жагсаал цуглаан зохион байгуулан төсвийн хэлэлцүүлэгт хүсэл сонирхол, ашиг сонирхлоо тусгах хүсэлтэй байгаа бол үүнийг мөн адил улс төр хийж байна гэж ойлгоно. Үүнд тулгуурлан улс төр нь ямар үйл явц, ямар хүрээг, ямар цаг үед хэрхэн хамарч болохыг төсөөлөх боломжтой юм.

Үүний зэрэгцээ нийгмийн амьдралд өрнөж байгаа үйл явц, илэрч байгаа аливаа үзэгдлийн чухам аль нь улс төрийн шинж чанартай вэ? гэсэн асуулт тавигдах нь зүйн хэрэг. Учир нь нийгмийн амьдралд болж, өрнөж байгаа бүхий л юмс үзэгдэл улс төрийн шинж чанар, агуулгатай гэж үзвэл өрөөсгөл болох бизээ. Иймд улс төр гэсэн ойлголт, нэр томъёог нарийвчлан тодорхойлж, ▶



засаг, соёлын хүрэн дэх харилцаа нарийн төвөгтэй, нийлмэл болж ирсэнтэй холбож ойлгож болох талтай. Хүмүүс нийгмийн зохион байгуулалттай амьдарч байгаа нөхцөлд улс төрийн харилцаанд ямар нэг байдлаар оролцож байдаг. Иймд тус өгүүллийн хүрээнд нийгмийн үзэгдэл, үйл явц болохын хувьд улс төрийг хэлэлцэж, тайлбарлахыг хичээсэн болно.

Хэл зүйн талаасаа улс төр гэсэн ойлголт “Polis - полис” гэсэн Грек үгнээс гаралтай. Эртний Грект бие даасан хот улсуудыг полис гэж нэрлэдэг байсан бөгөөд тухайн хот улстай холбоотой аливаа асуудлыг шууд ардчиллын зарчмаар хэлэлцэж шийддэг байв. Тийнхүү хот улстай

► тайлбарлах шаардлагатай болж байна. Улс төрийг олон талаар, харилцан адилгүй байдлаар тодорхойлсон байх бөгөөд тэдгээрийг дараах хоёр хүрээнд авч үзжээ. Нэгдүгээрт: улс төрийн нам, нийгмийн тодорхой байгууллын түвшинд авч үзэх хандлага. Энэхүү хандлагын хүрээнд “Улс төр бол засгийн эрх мэдлийн төлөөх өрсөлдөөн, зөрчилдөөн бүхий үйл ажиллагаа” гэж үздэг. Тухайлбал, улс төрийн намууд сонгуульд өрсөлдөж байгаа нь засгийн эрх мэдлийн төлөөх өрсөлдөөний нэг хэлбэр бөгөөд энэ нь хэлбэр болон агуулга талаасаа улс төрийг бүрэн илэрхийлнэ. Хоёрдугаарт: төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх шаг шатны байгууллага, хувь хүмүүс буюу улс төрийн субъект болохын хувьд улс төрийг тодорхойлох хандлага бий. Энэ хандлагын хүрээнд “Улс төр гэдэг нь төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх шаг шатны байгууллагуудыг өөртөө агуулсан тогтолцоо юм. Иймд төрийн гадаад, дотоод бодлого, эдийн засгийн өсөлтийг хангах, ядуурлыг бууруулах, ажлын байр бий болгох гэх мэт ойлголтууд нь бүхэлдээ улс төрийг илэрхийлнэ.

Ямартай ч нэгдүгээр хандлагын хүрээнд манай тооллын өмнөх үеийн Грекийн сэтгэгчид болон өнөө цагийн судлаачдын байр суурийг эсрэг тэсрэг шинж чанар, агуулга бүхий хоёр үндсэн бүлэгт авч үзэж болохоор байна. Улс төрийг тодорхойлох тэрхүү эсрэг тэсрэг үзэл хандлага нь улс төрийн харилцаа, үйл явц, тэдгээрийн үр дүн, үр нөлөөг өөртөө агуулсан гэдгийг тэмдэглэхгүй өнгөрч болохгүй. Эхний үзэл хандлагаар “Улс төр бол нийгэмд бий болсон зөрчил, тэмцэл, мөргөлдөөн” юм. Нийгмийн гишүүдийн ашиг сонирхол, хүсэл эрмэлзэл, үнэт зүйл, хандлага харилцан адилгүй байх бөгөөд энэ байдал нь нийгэмд зөрчил бүхий харилцааны үндсийг тавьж, басхүү өрнүүлж байдаг. Нийгэмд бий болсон аливаа оюуны болон материаллаг баялагийг эзэмших ашиг сонирхлын зөрчлүүд нь эрх мэдлийн төлөөх улс төрийн үйл явцын үндсийг тавьж, өрнүүлж байдаг. Улс төрийг энэхүү агуулга, мөн чанараар нь авч үзвэл улс төр бол нийгмийн харилцаанд бий болсон эрх мэдлийн төлөөх зөрчил, тэмцэл гэж ойлгогдож байна. Товчхондоо “улс төр хийхийн эцсийн зорилго нь эрх мэдлийг гартаа авах, түүнд тулгуурлан тодорхой ашиг сонирхлыг хэрэгжүүлэх” явдал ажээ.

Харин үүний эсрэгээр зарим судлаачид улс төр бол эсрэг тэсрэг санаа үзэл бодол, ашиг сонирхлын зөрчлөөр хязгаарлагдах эсхүл хэмжигдэх төдий зүйл биш гэж үздэг. “Улс төрийн зорилго нь нийгмийн харилцаанд нэгдмэл байдал бий болгох, нийтийн ашиг сонирхлыг тодорхой субъектүүдийн ашиг сонирхлын дээр тавьсан бодлого тодорхойлж, хэрэгжүүлэх явдал юм.” Энэхүү тодорхойлолт нь идеалист эсхүл утопи шинж чанартай болохыг уншигч та эрх биш ойлгож байгаа болов уу. Үүнээс үзвэл улс төр гэдэг нь хүн бүрийн ашиг сонирхолд нийцсэн нийгмийн хэм хэмжээ, хэв журам тогтоох явдал болж байна.

Үүнээс үзвэл улс төрийг бүрэн төгс тодорхойлсон нэгдмэл ойлголт гаргах бэрхшээлтэй юм байна гэдгийг улс төр судлаачийн хувьд тэмдэглэх нь зүйтэй. Гэхдээ энэ нь улс төрийг нийтлэг байдлаар тодорхойлж, тайлбарлаж болдоггүй юм байна гэсэн санаа огт бишээ. Дээр сийрүүлсэн тодорхойлолтууд улс төрийн талаар нийтлэг ойлголт, чиг хандлага байгааг, өөрт нь тохирсон тодорхой хүрээ байгааг бэлхэнээ хэлээд өгч байна. Иймд дээрх хоёр үзэл хандлагын хүрээнд улс төр гэдэг нь “зөрчил, тэмцэл” хийгээд “нийгмийн зүй тогтол, эв нэгдэл, нэгдмэл байдал” гэсэн нийтлэг ойлголтод хүрч болно.

Энэ бүгдэд тулгуурлан улс төр бол “Нийгмийн гишүүд (хүмүүс)-ийн амьдралыг зохицуулахад шаардлагатай хэм хэмжээ тогтоох, тэдний эрхийг хангах, хамгаалах зорилгоор хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаануудын цогц мөн” гэж тодорхойлж болохоор байна. Нийгмийн гишүүдийн олон талт хүсэл сонирхол, хэрэгцээ шаардлага бүрийг биелүүлэх гэхээсээ илүүтэй тэдгээрийн шийдлийг хайх олох үйл явц улс төрийг илүү тодорхой тайлбарлах юм. Хүмүүсийн хязгааргүй хэрэгцээг хангах шаардлага нь улс төрийг зайлшгүй болгож байдаг.

Ийнхүү дээрх бичиглэлээр улс төрийг хоёр үндсэн хандлагын хүрээнд тайлбарлахыг хичээлээ. Харин улс төр, түүний хамрах хүрээг ойлгож мэдэх нь улс төрийн талаарх ойлголтоо илүү тодорхой болгоход тус дөхөм болох бизээ. Аливаа юмс үзэгдлийг тэдгээрийг агуулж байгаа хүрээгээр нь дүрслэн тайлбарлах нь тэдгээрийн талаар маш тодорхой төсөөлөл бий болгодог. Иймд улс төрийн хамрах хүрээг тайлбарлаж, зарим талаар дүн шинжилгээ хийх нь зүйтэй болов уу.

Үүнтэй уялдуулан “улс төрийн үндсэн үүрэг нь төрийн удирдлагыг хэрэгжүүлэх, нийтийн сайн сайхан, зүй зохистой байдлыг хангах явдал мөн” гэсэн ойлголтыг сэргээж сануулах нь зүйтэй болов уу. Улс төрийн эс бөгөөс улс төрийн институцуудын тухайд төрийн удирдлагыг хэрэгжүүлж, нийгмийн хэм хэмжээг зохистой байлгах үүрэг нь түүний түгээмэл, зайлшгүй хэрэгжүүлэх үүрэг гэж ойлгогдоно. Эртний Грект “Polis – хот улс” нь дан ганц нийгэм-улс төрийн зохион байгуулалт байхаар хязгаарлагдахгүй цэрэг арми, улс төрийн зохион байгуулалтыг өөртөө агуулж байжээ. Үүнээс үзвэл нийгмийн амьдралын бүхий л хүрээнд улс төрийн институцуудын үүрэг зайлшгүй байжээ. Гагцхүү улс төрийн хамрах хүрээг хүмүүс нийгмийн харилцаанд оролцох явцад нийтийн эсхүл хувь хүний өөрт нь хамаатай орчины алинаар нь дамжиж байгаагаар ялгах боломж бий. Тухайлбал, гэр бүл, найз нөхдийн ердийн харилцаа нь хувь хүнд өөрт нь хамаатай орчныг тодорхойлох бол сонгуульд санал өгөх, төрийн байгууллагатай харилцах, татвар төлөх үйл ажиллагаа нь нийтийн буюу нийтлэг зохицуулалт шаардсан орчин бий болгож байдаг.

Нийгмийн тодорхой чиг үүрэг болохын хувьд улс төрийн хүрээг яг таг тогтоох зарим талаар боломжгүй юм. Хэдий тийм боловч энэ нь улс төрийн хүрээг тогтоох боломжгүй гэсэн үг бишээ. Учир нь нийгмийн амьдралд өрнөж байгаа мянга мянган харилцаа зарим тохиолдолд шууд улс төрийн хүрээний харилцааны шинж чанарыг агуулдаг бол зарим талаар улс төр-эдийн засгийн, нийгэм-улс төрийн гэх мэт шинж чанарыг агуулна. Тухайн харилцааг хэрхэн ойлгож, тэрхүү асуудалд хэрхэн хандаж байгаагаас шалтгаалан улс төрийн агуулгатай юу? улс төрийн хүрээний юу? гэдгийг хэлэлцэх боломжтой. Хувь хүнд хамаарах асуудал нь зарим тохиолдолд дан ганц түүнд өөрт нь хамаатай байдаг бол зарим тохиолдолд улс төрийн шинж чанартай болох нь бий. Амьдрал ахуйгаа өөд татах гэсэн хувь хүний хүсэл сонирхол, эрх чөлөөнд хэн нэг нь хөндлөнгөөс хутгалдах эрхгүй боловч тухайн хүний эрхэлж байгаа бизнес захиргааны шийдвэр, татварын бодлогын улмаас түүний хувийн амьдралд хүндрэл бэрхшээл тулгарч, улмаар өрхийн орлогод нь нөлөөлөөд эхэлсэн бол хувь хүний асуудал байхаа больж улс төрийн шинж чанартай болж хувирна. Аристотелийн хэлсэнчлэн “Хүн бол угтаа улс төрийн амьтан” болж байгаа нь үүгээр илэрхий ойлгогдох бизээ. ■

Холын зорилго үгүй бол ойрын зовлон оршино-3

(Сонгуулийн тухай эргэцүүлэл)
Түүрүүч нь 101, 102 дугаарт



П.ЦАГААН

Усны эх нь булингартай бол адаг нь булингартай

УИХ-д нэгэнт сонгогдсон гишүүнээ шүүмжилж зүхэх нь өнгөрсөн борооны хойноос цув нөмрөхтэй адил. Төрийн байгууллагад, түүний дотор УИХ-д нэр дэвшинэ, нэр дэвшүүлнэ, сонгуульд оролцож саналаа өгнө гэдэг бол төрийг төвхнүүлэх чухал үйл хэрэг юм. Бидний гол дутагдал бол чухамхүү төрийг төвхнүүлэх хамгийн хариуцлагатай ажлын эх-гараанд хайнга, бодлогогүй хандаж ирсэн явдал. Усны эх нь булингартай бол адаг нь булингартай гэдэг. Тиймээс усныхаа эхийг буюу ундаргыг тунгалаг болгох талаар бодох цаг болжээ. Үүнээс үүдэж нэн түрүүнд УИХ-ын Сонгуулийн хуулийг чамбайруулахыг амьдрал шаардаж байна.

Нэр дэвшигчдэд шинэ шаардлага тавих

Орчин үед дэлхий дээр “улс” гэдэг тодотголтой 200 гаруй компани хөгжил, дэвшлийн төлөө уралдаж байна. Удирдагчид нь ямар байна вэ, улс орон ч, компанийн ажил үйлс ч мөн тийм л байна. Улс орны өрсөлдөх чадварыг үнэлж, хэмждэг дөрвөн багц шалгуурын нэг нь Засаглал, түүний үр өгөөж юм. “Монгол Улс” хэмээх компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Улсын Их Хурал. Томоохон компаниуд ТУЗ-ийн гишүүнд тавих шаардлага, нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах зэрэгтээ онцгой анхаарах болов. Учир нь ТУЗ-ийн бодлого, шийдвэрээс компанийн хувь заяа шалтгаалдаг. Монгол хэмээх их айлын хувь заяа, ажил амьдралыг зохицуулсан хэм хэмжээ тогтоох онцгой бүрэн эрхтэй УИХ-ын гишүүнд нэр дэвшигчдэд нас, иргэний харьяаллаас гадна шинэ шаардлага тавьж, шигших нь үндэсний эрх ашгийн төлөөх үйл хэрэг гэж үзэж байна. Үүнд:

Эрүүл мэндийн яам сонгуульд нэр дэвших сонирхолтой хүмүүсийг бие бялдар, сэтгэл мэдрэл, мансууруулах бодис, янз бүрийн донтолтгын өвчний нарийн үзлэгт хамруулах хэрэгтэй. Эрүүл биед саруул ухаан оршино. Саруул ухаантаас сайн хууль төрнө. Сонирхуулахад, нийгмийн гарал үүсэл, цэргийн цол хэргэм, шашны мяндаг зэргийг үл харгалзан, гагцхүү ухаанаараа доторсон эрдэмтэн мэргэдээр олон зуун жил улс орноо удирдуулсан үндэстэн бол Хятад юм. Тэд бичгийн чадвар, гүн ухаан, Күнзийн сургааль зэргээс бүрдсэн төрийн албаны шалгалтанд хамгийн өндөр оноо авсан хүнд хамгийн өндөр албан тушаал өгдөг байсан бөгөөд одоо ч энэ уламжлал ханхалдаг. Тэд боловсрол мэдлэгээ гадна эх орондоо хайртай байх зарчмыг мөрддөг болой.

Төрийн Албаны Зөвлөл /ТАЗ/ сонгуульд нэр дэвших сонирхолтой хүмүүсийн оюуны итгэлцүүрийн (IQ) түвшинг тогтоож, Монгол Улсын түүх, Үндсэн хууль, монгол хэлний \кирил\ болон компьютерийн хэрэглээний чадварын тест авч, нийтэд зарлах буюу оюуны итгэлцүүрийн босго даваагүй хүнийг шууд хасах хэрэгтэй. Зарим оронд, эрэгтэйчүүд цэргийн алба хаасан байхыг шаардах, боловсролын түвшний босго шаардлага \тухайлбал, Африкт бичиг үсэг тайлагдсан, Зүүн Азид ерөнхий

боловсролын сургууль төгссөн, Казакстанд дээд боловсролтой гэх мэт\ тавьдаг бол Англо-Саксоны орнуудад дампуурлаасаа гараагүй, мөн гадаад орны өмнө үүрэг хүлээсэн этгээдийг парламентад нэр дэвшихийг хориглодог зэрэг олон янзын шаардлага, хязгаарлалт тавьдаг.

Дээр чухал үүргийг биелүүлдэг болохоосоо өмнө ТАЗ өөрөө асар их өөрчлөгдөх хэрэгтэй болно. Ядаж л тодорхой нэгэнд зориулж “сонгон шалгаруулалт” хэмээх “жүжиг” тавьж, төрийн албыг сулруулахад “хувь нэмэр” оруулдаг увайгүй үйлдлээ болих хэрэгтэй.

Татвар бол төр ба иргэний хоорондын суурь холбоо юм. Тиймээс татварын алба сонгуульд анх нэр дэвшигчийг сүүлийн гурван жилд тухайн тойрогт амьдарч, улсад татвар тасралтгүй төлсөн эсэхийг баталгаажуулдаг байж болох юм. Татварын ноцтой зөрчил илэрвэл нэр дэвших эрхийг нь нэг сонгуульд өнжүүлж болох талтай. Ингэхдээ уг асуудлыг шүүх маш шуурхай, эцсийн байдлаар шийддэг байвал зохино. Барууны ардчилсан орнуудад анхандаа зөвхөн татвар төлөгчид сонгуульд оролцох буюу төрийг төвхнүүлэх онцгой эрх эдэлдэг байсан түүхтэй. Манай өвөг дээдэс ч гэсэн “татвар төлдөггүй хүнийг малын дансанд бүртгэ” хэмээн лүндэн буулгадаг байсан билээ.

Нэр дэвшүүлэхэд хяналт тавих

Сонгуульд нэр дэвшүүлэх нь намын эрх хэмжээ мэт боловч утгаа төрийг төвхнүүлэх хариуцлагатай ажлын эхлэл учраас түүнд төрийн зүгээс хяналт тавих зайлшгүй шаардлагатай болно. Иймээс УИХ-д нэр дэвшүүлэх субъектүүдэд тавих шаардлагыг нарийвчилж, түүний хэрэгжилтэд хуулийн болон сонгууль зохион байгуулж буй байгууллага чанд хяналт тавьдаг болох нь зүйтэй. Энэ нь олон арга хэлбэрээр хэрэгжиж болно. Жишээ нь, намууд сонгуульд нэр дэвшүүлэх хурлын дэг, зохион байгуулалт, саналын хуудас, стандартыг тогтоож, санал хураалтыг зохион байгуулах, саналын дунг тоолоход хяналт тавьж, батлагаажуулж болно. Өөрөөр хэлбэл, бүх нам нэгэн дүрэм журмаар “тоглож”, шударгаар нэр дэвшүүлж буйд хяналт тавина гэсэн үг юм. “Намын даргын санал намын удирдах байгууллагын саналын 50 хувьтай тэнцэнэ” гэсэн дүрэмтэй нам саяхан хүртэл байсан бөгөөд тэр дүрмээрээ сонгуульд нэр дэвшүүлж байсан нь үнэн түүх. Ийм дүрэмтэй нөхцөлд хэн нэр дэвших, бас нэр дэвшигч УИХ-д сонгогдвол хэний “утсан хүүхэддэй” болох нь нэн ойлгомжтой. Ийм байдлыг цэглэх нь зүйтэй. Монголын зөвшилцлийн ардчилал цааш дахин нэг алхах, болж өгвөл холхон алхахыг эрхэмлэж байж сая илүү үр дүнд хүрнэ. Тийм учраас улс төрийн намуудын удирдагчид хариуцлагаа ухамсарлаж, даргын, намын явцуу эрх ашгаа давж, үндэсний эрх ашгийн төлөө эвлэлдэх, хамтран ажиллахыг цаг үе шаардаж байна.

Оролцоог дэмжих

УИХ-ын сонгуульд нэрээ дэвшүүлж, өрсөлдөнө гэдэг бол тухайн иргэний улс төрийн идэвх, төр түмний төлөө зүтгэх гэсэн ▶

► эх оронч санаа бодлын илрэл гэж үзвэл зохино. УИХ-ын сонгуульд олон хүн өрсөлдөж, олон хүн сонгуульд санал өгөх тусам төр, түмний холбоо бат бэх, байгуулагдсан төр засаг нь ч чадамжтай, бас итгэл даах магадлал өснө. Иймээс Сонгуулийн хуулийг шинэчлэхдээ баримтлах энгийн бөгөөд маш чухал зарчим бол сонгуульд оролцох боломжийг аль болох тэлэх, дэмжих явдал юм. Жишээ нь, нэр дэвшээд сонгогдож чадаагүй боловч сонгогчдын тодорхой хувийн, тухайлбал, тойргийн сонгогчдын 10-аас доошгүй хувийн санал авсан бол төрөөс тогтоосон сонгуулийн зардлын 50 хувийг нэр дэвшсэн хүнд нөхөж өгдөг байж болно. Оролцоог хамгийн их дэмжих арга зам бол сонгуулийн зардлын хязгаар, зарцуулалт бөгөөд энэ тухай дор өгүүлсү.

Өрсөлдөх тэгш боломж олгох

Манай улсад үгүйлэгдэж, ардчилсан бусад оронд хэдийнээ хэвшсэн нэг зүйл бол сонгуульд нэр дэвшигчдэд өрсөлдөх тэгш боломж олгох явдал юм. Сонгууль бол автомашины уралдаантай төстэй зүйл. Автомашины уралдаанд гарааны зурхай, зам, зай, бариа чухал нь мэдээж боловч уг уралдаанд ямар маркийн, ямар хүчин чадалт хөдөлгүүртэй машинаар уралдах вэ гэдэг нь анхдагч зайлшгүй нөхцөл. Манай улсын сонгуулийн хувьд гараа, бариа, зам, зай нь осолдохгүй байна. Бусад нь алга буюу нэр төдий гэхэд хилсдэхгүй. Ижил зайнд, ижил мотортой машинаар уралдаж байж л уралдаан сая шударга болно. Машины мотор нь сонгуулийн хувьд мөнгө, бас дахин мөнгө. Францын парламентад нэг нэр дэвшигчийн сонгуулийн төсөв 2012 онд 98 мянган евро байхад Монголын парламентад нэр дэвшигчийн сонгуулийн зардал үүнээс хэд дахин их байсан нь яавч эрүүл үзэгдэл биш. Тийм учраас ямар зохицуулалт хийж болох гэвэл:

-Нэг нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны мөнгөний хэмжээнд хязгаар тогтоох; Тухайлбал, хязгаарыг нэг хүнд ноогдох ДНБ-ий хэмжээг 10-20 дахин үржүүлсэн дүнгээс хэтрүүлэхгүй байхаар тогтоож болно.

-Нэр дэвшигчдийн болон намын сурталчилгааны мөнгийг шилэн дансанд байршуулах бөгөөд сурталчилгаагаар сонгууль зохион байгуулах байгууллагын хуваарилсан хэвлэл, радио, телевизийн сувгаар, ижил талбай, хугацаанд явуулах;

-Тойргийн нийт нэр дэвшигчдийн хэвлэмэл материалыг нэг товхимол болгон сонгогчдод хүргэдэг, байршуулдаг болох, нэр дэвшигч материалаа тусдаа дангаар тараахыг хориглох;

-Нэр дэвшигчдийн сонгогчидтой хийх уулзалтыг хамтад нь зохион байгуулах;

Дундаж орлоготой иргэн сонгуулийн санхүүжилтын хүндрэлээс болоод УИХ-ын сонгуульд нэр дэвшиж чадахгүй байвал сонгуулийн хууль тогтоомж үндэсний эрх ашигт нийцэхгүй байна гэж үзвэл зохино. Сонгуулийн дүнд мөнгөний нөлөөлөл давамгайлах нь булингартай төр байгуулагдахын анхдагч шалтгаан мөн. Эрдэм чадалтай эмчийг сонгож биеэ эмчлүүлж, эрүүл болдог шиг эрдэм боловсролтой, ухаантай хүмүүсийг л олноор сонгож төр түшүүлж байж гэмээнэ Монголын заяа гэрэл гэгээтэй байх болно.

Улстөр, бизнесийн зааг

Монгол Улс одоо улс төр ба бизнесийг зааглах цагт тулж ирээд байна. Эс бөгөөс зарчимгүй, аль эсвэл хардлага дагуулсан улстөр, ёс зүйгүй бизнес, үлбэгэр төрийн дууль үргэлжилж, ард түмний түүхэн

сонголтын хувь заяа ээдрээтэй болох эрсдэл нэмэгдэж байна.

Бизнес эрхлэгчид бол баялаг бүтээгчид, ажлын байр бий болгогчид, татвар төлөгчид, төрийн зардлыг нуруундаа үүрэгчид юм. Тэд бол буянтай хүмүүс, эх оронч хүмүүс. Гэдний төлсөн татвараар амьдардаг, татвараар цугласан мөнгийг зөв, ариг гамтай захиран зарцуулж, татвар төлөгчдөд тайлагнах үүрэгтэй, татвар төлөгчдийн итгэмжлэгдсэн хүмүүс бол УИХ-ын гишүүд юм. УИХ-ын гишүүний эрхэм чухал үүрэг бол бизнес эрхлэгчид, татвар төлөгчдийн эрх, ашгийг хамгаалах явдал. Ийм учраас ардчилсан орнуудын парламентын гишүүд шинэ татвар санаачлахаас зайлсхийдэг. Зарим оронд үүнийг шууд хориглодог. Татвар тогтоогч өөрөө татвар санаачлахыг ёс зүйгүй санаачилга гэж үздэг. Харин Засгийн газраас ирсэн татварын талаарх саналыг зөвшөөрөх, эс зөвшөөрөх онцгой бүрэн эрхтэй хүмүүс бол яах аргагүй хууль тогтоогчид юм.

УИХ-ын гишүүн бол Үндсэн хууль, ардчиллын түгээмэл зарчим, хэм хэмжээний дагуу өөрийн явцуу ашиг сонирхолыг биш, ард түмний эрх ашгийг хамгаалах үүрэгтэй байдаг. Тийм учраас бизнес эрхэлдэг хүн УИХ-ын гишүүнээр сонгогдоход зүй ёсны болон хийсвэр хардлага, сэрдлэгт өртөх их магадлалтай. Тийм учраас энэ асуудлыг бусад орны туршлагыг харгалзан дараах байдлаар зохицуулж болох юм.

Сонгох, сонгогдох нь Үндсэн хуулиар олгогдсон хүний эрх учраас бизнес эрхэлдэг хүмүүс сонгуульд нэр дэвшихийг хориглож болохгүй, харин ч дэмжиж болох юм. Гэхдээ тодорхой болзол нөхцөлтэйгээр шийдэх хэрэгтэй. Тухайлбал, бизнесмэн хүн УИХ-д нэр дэвшиж, сонгогдсон тохиолдолд гурван сонголтын аль нэгийг хийхээ албан ёсоор зарлана. Эхний сонголт нь компаниа дуудлага худалдаагаар зарна. Үүнд төрийн холбогдох байгууллага хөндлөнгийн хяналт тавина. Хоёрдугаарт, компаниа хувьцаат буюу олон нийтийнх болгоно. Гуравдахь нь төрийн эрх бүхий байгууллагаас, тухайлбал, Төрийн өмчийн хорооноос томилсон удирдлагын баг уг гишүүний компанийг УИХ-ын гишүүний бүрэн эрх нь дуусах хүртэл удирдана. Тайлангаа нийтэд тавина. УИХ-ын гишүүн компанийн үйл ажиллагаанд ямар нэгэн хэлбэрээр оролцохыг хориглоно. Оролцвол гишүүнээсээ чөлөөлөгддөг байх хэрэгтэй. Ингэвэл УИХ-д сонгогдсон бизнес эрхэлж байсан хүмүүсийн үг үнэтэй, үйл хөдлөл нь хардлага сэрдлэг дагуулахгүй амар болно.

Сонгуулийн тов ба тогтолцоо

УИХ-ын сонгуулийг 2016 оноос эхлэн намар оройхон буюу ургац хураалт, хадлангийн хариуцлагатай ажил цэгцэрч, айлууд өвөлжөөндөө буун, сургууль номын ажил жигдэрсэний дараа аравдугаар сарын сүүлч, арваннэгдүгээр сарын эхээр явуулдаг болбол хөрөнгө мөнгө хэмнэх, ажил бага алдах зэрэг олон давуу тал байна. Тэгээд ч АСЕМ-ийн дээд түвшний уулзалт 2016 оны долдугаар сард болно. Бэлтгэх, зохион байгуулалтын ажил маш их байна. Улсынхаа нэр хүндийг бодох уу? Улсын их хурлынхаа сонгуулийг бодох уу? Улсаа ч бодье, сонгуулиа ч хийе. Мөн санхүүгийн буюу төсвийн жилээ дөрөвдүгээр сарын 1-нээс эхлүүлдэг болох нь зөв биш үү.

Сонгуулийн тогтолцооны хувьд одоогийн холимог хувилбарыг хадгалах нь зөв боловч пропорциональ тойргийг улсаар биш, бүсчилж байгуулах нь оновчтой болно. ■

Үргэлжлэл бий. 2015.05.17

Ёс суртахуунлаг хүмүүс төр барьсан цагт л Монгол Улс хөгжинө

Б.ОЮУНЧИМЭГ

(Доктор (Ph. D), профессор)

Жирийн иргэдийн амьдрал өдрөөс өдөрт доройтож, ихэнх аж ахуйн нэгж ажилчдынхаа цалинг өгөх чадалгүй болж, зарим нь хаалгаа барьж, монголчууд хангалуун сайхан амьдарч чадахгүй байгаа төдийгүй монгол хүн бүрт ногдох өрийн хэмжээ улам бүр нэмэгдсээр байгаа нь Монголын өнөөгийн төр нь төр шиг, засаг нь засаг шиг байж чадахгүй байгааг харуулж байна.

Хагуухан хэлэхэд Монголд төр байхгүйтэй адил. “Төргүй газар хүн хүндээ чоно” гэж Английн төрийн онолч Томас Хоббэс хэлсэлчлэн Монголд хүн-чоно олширсоор. Төр нь сул дорой бол иргэд нь төрдөө итгэхгүйд хүрч, дээдлэхээ больж, түмнээ гэх төрийн бодлого алдагдаж, эмх замбараагүй байдал, хүчирхийлэл, хуулийг эс хэрэгсэх явдал газар авдаг жамтай. Төрөө дээдлэх түмний ёс, түмнээ гэх төрийн уламжлалт бодлогыг алдах ёсгүй.

“Төрийн хүн цэцэн байх нь чухал” гэж эртний Грекийн гүн ухаантан Платон хэлж, “Философич хүн л төрийг удирдах ёстой. Энэ нь төрийн үндсэн гурван шинжийн нэг” гэж иран гаралтай онолч Ал Фараби “Үлгэр жишээ төр” номондоо төрийн хүний гол шинжийг тодорхойлон бичсэн нь бий. Философич нь үнэнийг танин мэдэхийг эрхэмлэгч ухаантан юм. Үнэнийг эрхэмлэх ухаантай, түмний төлөө сэтгэлтэй байх явдал төрийн хүнд тавигдах гол шаардлага болох тухай цаг цагийн мэргэд хэлсээр иржээ. Даанч өнөөгийн төр засгийнхан, улстөрчдөд энэ шинж алга.

Төрийн томоохон албыг хөрөнгө мөнгөтэй хүмүүс хашиж, албан тушаал, эрх мэдлийг хөрөнгөө арвижуулах хэрэгсэл болгон ашиглах явдал гаарч, мөнгөтэй л бол “хаан суудал”-д сууна хэмээн улайран зүтгэх болов.

Төрийнхөн өөрийн хувийн сонирхолд нөлөөлж болзошгүй шийдвэр гаргахад оролцох, эрх мэдэл, албан тушаалаа ашиглан шууд буюу шууд бусаар нөлөөлөх, ажил үүрэгтэй нь холбоотой болон хяналт тавих үүрэгт нь багтах өөр бусад ажил, албан тушаал эрхлэх, хавсран гүйцэтгэх, хувийн өмчит компани болон хуулийн бусад этгээдийн удирдах байгууллагын гишүүнээр

ажиллах, хянаж ажилладаг байсан байгууллагад төрийн албанаас гарснаас хойш ажиллах, хөрөнгө орлогоо ил тод мэдээлэхгүй байх, нуун дарагдуулах, дутуу мэдээлэх, шийдвэрийг өөрт ашигтай гаргуулах зорилгоор төрийн захиргааны ажилтанд нөлөөлөх, талдаа татах зэргээр лоббидож байна.

Төр, засгийн аппаратын зардлыг өсгөж, үргүй зардал гаргасаар ирлээ. Монгол Улсын Засгийн газрыг анх 1911 онд таван яамтай байгуулж байсан бол одоо 16 яам, 19 сайдтай болгочихоод байгаа.

Төрийн тогтолцоо иргэд төвтэй байх учиртай атал манай төрийнх улс төрийн нам төвтэй учир намын гишүүн нэртэй худал амласан, бүлэглэн хуйвалдсан, намынхаа даргын төлөө зүтгэсэн, албан тушаал горилсон, нам сольсон хуурмаг “намтангууд” төрд шургалж, нийтийн хөрөнгийг ил, далд завшиж, зөвхөн өөрсдийгөө хамгаалж, иргэдийн эрх ашиг, сонирхлыг хөсөр хаясаар. Монголын намуудын аль нь ч нийт олны, улс орны эрх ашиг, сонирхлыг бодохгүй байна.

Олон хуулийг дутуу дулимаг, “цоорхойтой”, ёс суртахуунд нийцүүлэхгүйгээр, бүр ёс суртахуунгүй хүмүүс оролцон гаргаж, хуулийн нэрээр хууль бус, хүн ёсны биш олон үйлдэл хийж, хуулийг хувийн эрх ашгаа хамгаалах хэрэгсэл болгож, өөрт ашигтайгаар тайлбарлаж, хэрэглэсээр. Төрийнхөн хуулийг хүслээ гүйцэлдүүлэгч болгон ашиглаж байна.

УИХ-ын чуулган, ажил албандаа согтуу ирдэг, ажлын байранд зохисгүй зан авир гаргадаг, төрийн өмч хулгайлдаг, төсвийн хөрөнгө завшдаг, төрийн албанд ах дүү, хамаатан садангаа цуглуулдаг, сонгогчдод худал ярьдаг, сонгуульд өрсөлдөгчөө гүтгэдэг, бусдад боломж олгох замаар олсон ашгаараа сонгуулийн зардлаа босгодог улстөрч цөөнгүй.

Улстөрчид нам намаараа талцаж, өөрийн намынх бол буруутай байсан ч хамгаалж, өөр намынх бол цагааныг нь хар болгож, өөлөн адалж байна. Улс төрийн намууд нэг нэгнийхээ хийсэн, хийж байгаа, хийх гэсэн ажлыг эс тоож, үгүйсгэсээр.

1.5 тэрбум төгрөгөөс доош орлоготой аж ахуйн нэгжийн албан татварыг нэг хувь болгох, мал аж ахуйн салбарт ажиллаж буй хүмүүсийг дэмжих (“Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих тухай “хуульд багахан өөрчлөлт оруулах замаар) хуулийн төслийг МАН-ын гишүүд дангаараа санаачилсан гэдэг шалтгаанаар унагасан гэж Улсын Их Хурлын нэгэн гишүүн сонинд өгсөн ярилцлагадаа өгүүлсэнийг олж үзлээ. Уг нь хуулийг аль намын гишүүн санаачилсан нь гол биш, хуулийн ач холбогдол, нийгмийн хэрэгцээ шаардлага нь чухал баймаар.

Улс төрийн намд ихээхэн хэмжээний хандив өргөж бүх шатны хурлын гишүүн болох, улмаар улс төрийн өндөр албан тушаалд очих нь хэвийн үзэгдэл болж. Аль намын ямар фракц, бизнесийн аль бүлэглэлийн төлөөлөл нь төр засгийн эрх мэдэлд хэрхэн нөлөөлж байгаагаараа л улс төрийн намууд ялгагдаж байгаа.

Ардчилсан засаглал, ил тод төр гэж хий ярих төдий. Ил ▶



► тод төр бол “тунгалаг төр” юм гэцгээж байна. Монгол хэлний “с” үсгээр төгссөн нэртэй юмсыг тухайлбал, ус, тос, цас, хөлс, шүлс, мөс тунгалагийг илэрхийлдэг ч урсдаг, тогтворгүй, хэврэг шинжийг мөн илэрхийлдэг. Уг нь төр, засаг тогтвортой, бат бэх, хүчтэй байх ёстой.

Улс орныхоо эдийн засгийг доройтуулж, монголчуудыг өрөнд баригдуулж, ашигт малтмалыг нь гадныхнаар цөлмүүлж байгаагийн үндсэн шалтгаан нь төрийнхөн ёс суртахуунгүй байгаа явдал юм. Уг нь төрийнхөн ёс суртахууныг дээд зэргээр эрхэмлэж байж төрөө төр шиг болгоно, хүн ардаа шударгаар үйлчилнэ, улс орноо хөгжүүлж дэвшүүлнэ. Ёс суртахууны ач холбогдлыг үл ойшоож, эс хэрэгсэснээр иргэдээ сайн сайхан амьдруулах үүргээ өнөөгийн төр, засгийнхан биелүүлж чадахгүй байна.

Монголын гурван иргэний нэг нь ядуу зүдүү амьдардаг гэсэн дүгнэлт сэтгэл түгшээсээр. Ядуурал нь монгол хүн эрүүл энх аж төрөх, ург наслах, бүтээлчээр сэтгэх, сурч боловсрох, нийгмийн таатай орчинд сэтгэл хангалуун, сайхан амьдрах, өөрийгөө болон бусдыг хүндлэх зэрэг хүний хөгжлийн хамгийн наад захын боломж бололцоо, сонголтыг хяхан боогдуулсаар.

Төрийн алба нь түүнийг хашигчаас нэр хүнд, хариуцлага, зориг тэвчээр шаарддаг ажил. Төрийн хариуцлагыг түүний бүтцэд алба хашиж, мэргэжлийн үйл ажиллагаа явуулж байгаа төрийнхөн л хүлээж, хэрэгжүүлэх ёстой. Аль ч түвшингийн албан хаагч, ялангуяа төрийн толгойд байгаа хүмүүс ёс суртахууны зарчим, хэм хэмжээг чанд сахин мөрдөж, иргэнлэг, эх оронч, авлига, сонирхлын зөрчлөөс ангид, хувийн ашиг сонирхлыг тэвчдэг, олны төлөө сэтгэлтэй байх ёстой атал төрийнхний олонх ийм биш байгаад иргэд шүүмжлэлтэй хандаж байгаа.

Төрийнхөн дээд зэргийн эх оронч, иргэнлэг байх учиртай. Төрийн хүн иргэнлэг байна гэдэг нь өөрийгөө төрийн нэг хэсэг нь, нийгмийн өмнө хариуцсан ажил үүргээ чанд гүйцэтгэх ёстой хүн гэж ухааран ойлгох явдал. Иргэнлэг чанар нь хайр хишиг горилон суухгүй, албан үүргээ чанартай биелүүлэх, хүч чадлаа бүрэн ашиглах, нэр төрөө дээдлэхэд оршдог.

Эх орныхоо ололт амжилт, зовлон бэрхшээлийг өөрт тохиолдсон мэт хүлээж авдаг, эх орныхоо төлөө ямагт хичээл зүтгэл гаргадаг, хөгжил дэвшилд нь хувь нэмрээ оруулахыг эрмэлздэг, өөриймсөг сэтгэлтэй төрийн хүнийг эх оронч гэж үзнэ. Ажил, албан тушаалаа өөрийн, гэр бүлийнхээ санхүүгийн болон бусад байдлыг дээшлүүлэхэд ашиглахгүй, ажил албатайгаа харшилсан гэрээ, хэлэлцээр байгуулах, шийдвэр гаргахад оролцохгүй байх нь эх орончийн шинж.

Манай төрийнхөн эх оронч хүмүүс мөн үү гэж асууval хариулахад хэцүү байх болов уу. Эрдэс баялгаа олборлох замаар ашиг олж, эдийн засгаа өсгөх хүсэл улс орнуудад байсаар ирсэн ч бүгд баяжин хөлжиж, хөгжин дэвжиж чадаагүй байдаг. Ихэнх буурай орон байгалийн баялгаа нээн илрүүлж, гадаадад гаргаж эхэлмэгц дийлэнх иргэд нь улам ядуурдаг болохыг эдийн засагчид хэдийнээ ажигласан. Байгалийн баялгаа олборлож, гадаадад гаргасны дараа дотоодын үйлдвэрлэл буурч, зарим нь дампуурч, ажиллах хүсэлгүй хүн олширноос ажилгүйдэл ихэсдэг амьдралын гашуун туршлага олон улсад цөөнгүй. Манайхан байгалийн баялагаа гаргаж ашиглахаас өмнө, бүр хөрсөн дор байхад нь гадаадынханд алдаж байгаа.

Хувийн болон албан үүргийн ашиг сонирхлын зөрчил үүсэх үед, зөрчилд орж болзошгүй тохиолдолд төрийн албан хаагч нь түүнийг нэн даруй арилгах аргыг сүвэгчлэн таслан зогсоох, сонирхлын аливаа зөрчлөөс ангид байх үүргээ чанд биелүүлэх нь төрийн хүний хариуцлага. Хувийн ашиг сонирхлыг тэвчих нь олонд тустай эрхэм чанар, төрийн хүнд зайлшгүй байх ёстой чадвар. Төрийн хүн шуналгүй байх ёстой.

Хувийн биш, харин нийтийн ашиг сонирхлыг эрхэмлэн хамгаалдаг, түүнд нийцсэн шийдвэр гаргадаг, зарчимч, албан үүрэгтэй сөргөөр нөлөөлөхүйц санхүүгийн болон бусад амлалт өгдөггүй, аливаад бодитой ханддаг, хариуцлагатай, гаргасан шийдвэр, явуулсан үйл ажиллагааныхаа төлөө олон нийтийн өмнө хариуцлага хүлээж чаддаг, хяналт, шалгалтаас зайлсхийдэггүй, төр, түмэн, ажил албандаа үнэнч байх, шударга ёсыг эрхэмлэх үүрэгтэйгээ төрийнхөн умартсан бололтой. Үүнийг огт мэддэггүй, мэдэхийг хүсдэггүй увайгүй хүмүүс Монголын төрд шургалсаар.

Өөрийнх нь мэдлэг боловсрол, чадал чинээнд тохирохгүй ажил, албан тушаалд шунагч “улстөрч” нэртэнгүүд олширсоор. Тохироогүй албан тушаал тэнэг харагдуулдаг, хүнээ олоогүй шагнал хүндэтгэлгүй болгодог, хэтэрсэн хэргэм зэрэг доогуур үнэлэгддэгийг төрийн эрхэмүүд мэдмээрсэн.

“Танайд ямар ч хямрал алга. Харин төрөө авдаг хулгай л их байна” гэж нэгэн япон хүн голоор нь онож хэлсэн тухай сонинд бичсэн нь ортой юм. Өр, чирэгдэл дагуулах, авлига хээл хахууль “бойжуулах”, ажил бүтээлийг цалгардуулах, бодлогоо буруу тодорхойлох, алдаатай бодлого хэрэгжүүлэх, гаргасан бодлогоо эс хэрэгсэх гээд олон дутагдал өнөөгийн төрд байна.

320 сурагч хичээллэх сургуулийн яг адилхан гурван барилгын үнийг зөрүүтэй тогтоож, тухайлбал, Сүхбаатар аймгийн Түмэнцогт суманд 63 сая, Завхан аймгийн Отгон суманд 950 сая, Хөвсгөл аймгийн Улаан-Уул суманд 750 сая төгрөгөөр барихаар улсын төсөвт тусгуулсан явдал төрийг ёс суртахуунлаг хүмүүс л барих зайлшгүй шаардлагатайг тодорхой харуулж байгаа юм. Иймэрхүү жишээ олныг дурдаж болно. Хөрөнгө зардлыг ийм байдлаар улсын төсөвт тусгуулдаг, баталж суудаг хүмүүс бол төрийнхөн, Улсын Их Хурлын гишүүд.

Төрийн өмч гэж байна уу? Төрийн эрхийг сонгуульд ялсан намынхан, зарим тохиолдолд хэд хэдэн намынхан нийлж барьж, “төрийн” гэгддэг хөрөнгөд эзэн сууж, зарж, үрж байна. Нэг хүчин ялагдмагц төрийн өмч хөрөнгийг өөр нэг нь гартаа оруулан авч, дур мэдэн зарцуулна. Төрийн гэгддэг өмч нь төр барьж буй нам, түүний удирдагчдын мэдлийн өмч болчихжээ, манайд. Төрийн гэсэн нэртэйгээс цаашгүй уг өмчийг элдэв аргаар завших явдал улам бүр газар авсаар.

Эрүүл зөв сэтгэдэг, ёс суртахууныг дээдэлдэг, амьдралыг идэх уух, эдэлж хэрэглэх зүйл төдийхнөөр хэмжихгүй, шуналгүй, хүн ардынхаа бодит амьдралыг мэдэрдэг, түүнд харшлах арга замаар ашиг хонжоо олох гэдэггүй, хүнлэг, шударга хүмүүс л Монгол орныг хөгжүүлнэ, ард иргэдээ амар амгалан, сайн сайхан амьдруулна.

Төрийнхөн ёс суртахуунлаг болох явдал өнөөгийн нийгмийн бодит шаардлага болоод байна. Ёс суртахуунлаг хүмүүс төр барьдаг болсон цагт Монгол Улс хөгжиж, хүн ард нь сайн сайхан, сэтгэл хангалуун амьдарна. ■

2015.12.01